

**БАТЛАВ.**

**УЛСЫН ИХ ХУРЛЫН ГИШҮҮН**



**Н.ЭНХБОЛД**

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН  
ТӨСЛИЙН ҮЗЭЛ БАРИМТЛАЛ**

ТУС3754 8023051393 9087184

**Нэг.Хуулийн төсөл боловсруулах болсон үндэслэл, шаардлага**

**1.1.Хууль зүйн үндэслэл**

1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Монгол Улсын Их Хурлын 2019-2024 оны стратеги төлөвлөгөөний Стратегийн зорилт 1.1-д “Хууль тогтоох үйл явцыг боловсронгуй болгож, парламентат ёсны шаардлагад нийцүүлэн, ард түмний хүсэл зориг, эрх ашгийг хангахад чиглүүлж, тэдний оролцоог нэмэгдүүлэх эрх зүйн орчныг бүрдүүлэх.”-ээр тодорхойлсон бөгөөд энэхүү зорилтын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний 1.1.1-д “Үйл ажиллагаа нь Байнгын хорооддоо төвлөрсөн парламентыг төлөвшүүлэх, парламентаар хуулийн төслийг хэлэлцэх дэгийг боловсронгуй болгох, дэг тогтоох олон улсын жишгийг судалж нэвтрүүлэх;”, 1.1.2-т “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтийн хүрээнд шаардлагатай хууль тогтоомжид өөрчлөлт оруулж, эрх зүйн орчныг боловсронгуй болгох;”, 1.1.7-д “Хууль тогтоомж санаачлах, боловсруулах, зөвлөлдөх, хэлэлцэн батлах, хэрэгжилтийг хянах үйл ажиллагаанд оролцогч талуудын оролцоог тодорхойлсон эрх зүйн орчныг боловсронгуй болгох;” гэж тус тус заасан.

2.Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг баталсан. Уг өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулж “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж заасан.

Улсын Их Хурлаас 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.” гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлд “2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн баталж мөрдөх хүртэл тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө.” гэж тус тус заасан.

Мөн Улсын Их Хурлын 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдөр баталсан “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлттэй холбогдуулан авах арга хэмжээний тухай”

44 дүгээр тогтоолын 1 дүгээр хавсралтаар “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд хууль тогтоомжийг нийцүүлэх хуваарь”-ийг баталсан. Уг хавсралтын 7-д Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг Улсын Их Хурлын 2024 оны хаврын ээлжит чуулганы хугацаанд дээрх өөрчлөлттэй нийцүүлэхээр тогтоосон болно.

## **1.2. Практик хэрэгцээ, шаардлага**

Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг нь цаг үеийн шаардлага, нийгэм, улс төр, эдийн засгийн орчинтой зэрэгцэн тасралтгүй шинэчлэгдэж, боловсронгуй болж байх ёстой бөгөөд Улсын Их Хурлын хууль тогтоох үйл ажиллагааг үр дүнтэй явуулах хамгийн гол хэрэгсэл юм.

2019 онд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан нэмэлт, өөрчлөлтөд нийцүүлэн тухайн үеийн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг шинэчлэн найруулж 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан бөгөөд 2020 онд бүрдсэн Улсын Их Хурал энэхүү шинэ дэгээр үйл ажиллагаагаа явуулж 4 жил орчим хугацаа өнгөрч байна.

Өдгөө хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль 131 зүйл, 744 хэсэг, 223 заалттай бөгөөд 2020 оноос хойш нийтдээ зургаан удаа буюу 2020.11.06, 2021.12.24, 2022.07.05, 2022.08.24, 2023.05.04, 2023.07.07-ний өдрүүдэд оруулсан нэмэлт, өөрчлөлтүүдээр тус хуулийн 115 хэсэг, заалтад өөрчлөлт оруулсан байна.

Энэ нь зарим зохицуулалтыг боловсронгуй болгох цаг үеийн шаардлагаас улбаатай бөгөөд 2020 оны 11 дүгээр сарын 06-ны өдөр чуулганы хуралдааны дэг зөрчсөн тохиолдолд гишүүнд хүлээлгэх хариуцлагыг тодорхой болгох зорилгоор, 2021 оны 12 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль батлагдаж, Улсын Их Хурлын хянан шалгах чиг үүргийг хэрэгжүүлэхтэй холбоотой дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор, 2022 оны 08 дугаар сарын 24-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуулийн цэцээс Үндсэн хуулийн холбогдох заалтыг хүчингүй болгосонтой холбоотойгоор Цэцийн шийдвэрийг хэлэлцэх дэгийн зохицуулалтыг бий болгох зорилгоор гэх мэтчилэн цөөнгүй зүйл, хэсэг, заалтад нэмэлт, өөрчлөлт оруулжээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байхаар заасны дагуу чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахтай холбогдсон харилцаанд зохион байгуулалтын шинжтэй холбогдох өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай байна.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэглэх явцад зарим зохицуулалтыг илүү тодорхой болгох, нарийвчлах, нэр томъёог Үндсэн хууль, бусад хууль, монгол хэлний дүрэмд нийцүүлэх, жигдлэх, хууль зүйн техникийн шинжтэй засвар оруулах практик хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн.

Дээр дурдсан хууль зүйн үндэслэл, практик хэрэгцээ шаардлагад нийцүүлэн хийх өөрчлөлт нь Хууль тогтоомжийн тухай хуулийн 25.1.2, 25.1.4-т тус тус заасанчлан

хуулийн нийт заалтын 50-аас дээш хувьд нэмэлт, өөрчлөлт оруулах, зохицуулж байгаа харилцааны төлөв байдал, агуулгад өөрчлөлт гарч, түүнтэй уялдуулан шинэчлэн батлах шаардлага үүссэн тул Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл хэлбэрээр боловсруулах нь зөв гэж үзэв.

### **Хоёр.Хуулийн төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг нэг зуун хорин зургаан гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үр дүнтэй зохион байгуулах, хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг бүтээмжтэй, үр нөлөөтэй байлгах, асуудлыг ажил хэрэгч, шударга мэтгэлцээний зарчмаар шийдвэрлэхэд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын зорилго оршино. Түүнчлэн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох Улсын Их Хурлын гишүүдийн ирц, идэвх, оролцоо, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. Ингэхдээ дэлхийн зарим орны парламентын дэгийн сайн туршлагаас холбогдох зохицуулалтыг нэвтрүүлэх, Монголын парламентын үйл ажиллагаанд нутагшуулах асуудлыг анхаарч үзнэ.

Монгол Улсын Үндсэн хуульд 2023 онд оруулсан өөрчлөлт, одоогийн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хэрэглэх явцад бий болсон нөхцөл байдал дээр тулгуурлан дэгийн зохицуулалтыг илүү тодорхой болгох, нарийвчлах, зарим шинэлэг зохицуулалтыг дараах чиглэлд хийнэ. Үүнд:

**1.Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болгож нэмэгдүүлсэнтэй холбогдуулан гишүүдийн асуулт асуух, үг хэлэх, санал хүраах журам, хугацаанд холбогдох өөрчлөлтийг оруулж, дэг тогтоох олон улсын жишигт нийцсэн мэтгэлцээний зарчмыг тусгана. Үүнд:**

-Улсын Их Хурлын стратеги төлөвлөгөө ёсоор Байнгын хорооддоо төвлөрсөн парламентыг төлөвшүүлэх зорилт тавьсанчлан баруун Европын орнуудад түгээмэл тархсан Байнгын хороодын хуралдаан нь парламентад хэлэлцэгдэж буй асуудлыг шийдвэрлэхэд чухалд тооцогддог, мөн хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоотой улсуудад өргөн хэрэглэгддэг парламентын дэгийн зарим зохицуулалтыг нутагшуулна.

-Нам, эвслийн бүлгээс санал, дүгнэлт гаргахдаа үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд чуулганы Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлгийн үе шатуудыг мэтгэлцэх зарчмаар явуулах зохицуулалтыг нэвтрүүлнэ.

Ингэхдээ хуралдаан даргалагч хэлэлцэж буй асуудлын цар хүрээнээс хамаарч мэтгэлцээний үргэлжлэх хугацааг тогтоох, мэтгэлцээн явуулахдаа дэгийг чанд мөрдүүлэх үүрэгтэй байна.

-Нэгдсэн хуралдаанд асуулт асуух хугацааг нам, эвслийн бүлгийн авсан суудлын тоонд хувь тэнцүүлэн хуваарилах тусгана. Ингэхдээ нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн хэлэлцүүлгүүдийг явуулах үед асуулт, хариулт авах үйл ажиллагааг Зөвлөлөөс тогтоосон хугацаанд багтаан зохион байгуулах, хуралдаан даргалагч урьдчилан ирүүлсэн дарааллын дагуу асуулт, хариултыг зохион байгуулахаар тусгана.

**2.Хууль, тогтоолын төслийг хэлэлцэх үе шатны зохицуулалтыг боловсронгуй болгож, хууль, тогтоолын төслийг чанартай, хийдэлгүй батлагдах нөхцлийг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусгана. Үүнд:**

-Чуулганы хуралдааны тов, дарааллыг тогтоох, түүнийг гишүүдэд мэдээлэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тодорхойлно. Тухайлбал, хуулийн төслийг хэлэлцэх дарааллыг тогтоохдоо түүнийг өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан үздэг байх, ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг тогтоосон УИХ-ын тогтоолд ороогүй хуулийн төслийг өргөн мэдүүлсэн тохиолдолд түүнийг хэлэлцэх асуудлын жагсаалтад оруулах шаардлагатай тохиолдолд уг асуудлыг дахин хэлэлцэж, тогтоолд өөрчлөлт оруулах эсэхийг шийдвэрлэдэг байх зэрэг болно.

-Гишүүдийн гаргасан зарчмын зөрүүтэй саналыг төсөлд хэрхэн тусгах, хууль хоорондын нийцлийг хэрхэн хангах, төслүүдийг чанартай, алдаа хийдэлгүй хэлэлцүүлэх үүднээс хэлэлцүүлэг хооронд тодорхой хугацаа тогтоосон зохицуулалт тусгана. Улмаар гишүүн, нам, эвслийн бүлэг хууль, тогтоолын төсөлд зарчмын зөрүүтэй санал гаргах бол саналаа Байнгын хороонд хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас тодорхой хугацааны өмнө бичгээр урьдчилан ирүүлсэн байх шаардлагыг тусгана.

-Улсын Их Хурлын Тамгын газраас холбогдох хууль, тогтоолын төслийг өргөн мэдүүлэхийн өмнө болон хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө хууль, тогтоолын төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэх, тухайн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдсөн эсэх, хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд шаардлагатай бүх хууль, зүйл, хэсэг, заалтыг хамааруулсан эсэх зэрэг асуудлаар хууль зүйн дүн шинжилгээ хийж эрх зүйн дүгнэлт, төсөвт үзүүлэх нөлөөллийн асуудлаар төсвийн дүн шинжилгээ хийх зохицуулалтыг тусгана.

-Байнгын хорооноос хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах тохиолдолд УИХ-ын гишүүдийн оролцоог нэмэгдүүлж, баримтлах дэгийг тодорхойлно.

-Байнгын хороо хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах хүрээ хязгаарыг илүү тодорхой болгож, төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль хоорондын уялдааг хангуулахаар холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болох зохицуулалтыг тусгана. Түүнчлэн Байнгын хороонд хуулийг дагаж мөрдөх журмын буюу шилжилтийн үеийн зохицуулалт, хуулийг дагаж мөрдөх хугацааны талаар эцсийн хэлэлцүүлгийн шатанд санал, дүгнэлт гаргах боломжийг нээж өгнө.

### **3.Чуулганы хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүдийн сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, дэг сахихтай холбоотой зарим зохицуулалтыг шинэчилнэ. Үүнд:**

-Хаалттай хуралдаанаас бусад чуулганы хуралдааны тэмдэглэлд гишүүдийн өгсөн саналыг тусгаж, ил тод байдлыг хангана. Мөн хуралдааны дэг сахиулахтай холбогдуулан авсан арга хэмжээг хуралдааны тэмдэглэлд тусгах зохицуулалтыг нэмнэ.

-Гишүүд чуулганы хуралдаан эхлэхээс өмнө танхимд суудлаа эзэлсэн байх, ирцэд бүртгүүлсэн байх асуудлыг үүрэгжүүлнэ. Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүн хүндэтгэн үзэх тодорхой шалтгаанаар танхимаас гарах тохиолдолд хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авах зохицуулалтыг тусгана.

**4.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэглээг ойлгомжтой болгоход чиглэсэн бүтэц, нэр томьёо, хууль зүйн техникийн шинжтэй бусад өөрчлөлтийг тусгана. Үүнд:**

-“Чуулганы хуралдааныг зохион байгуулах нийтлэг журам”, “Олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг хэлэлцэх, гадаад харилцаатай холбогдох асуудал хэлэлцэх зэрэг бие даасан бүлгүүдийг нэмнэ.

-“Төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах”, “Эрдэнэсийн сангийн төсөв хэлэлцэх”, “Нийтийн ашиг сонирхолд хамаарах тодорхой асуудлыг хэлэлцүүлэхээр иргэний гаргасан саналыг хэлэлцэх”, “Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд тангараг өргөх” зэрэг зүйлүүдийг нэмж бүтцийн хувьд зохих өөрчлөлт хийнэ.

-Улсын төсөв, төсвийн хүрээний мэдэгдэл, төсвийн гүйцэтгэл, улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэх дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгоно.

-Ерөнхий сайдын мэдээлэл, гишүүний асуулга, асуултын хариуг сонсох, хуулиар тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээллийг сонсох, хэлэлцэхтэй холбоотой дэгийн зохицуулалтыг тодорхой болгоно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг нийт 16 бүлэгтэй, үүнд:

Нэгдүгээр бүлэг.Нийтлэг үндэслэл;  
Хоёрдугаар бүлэг.Чуулганы хуралдааныг зохион байгуулах нийтлэг журам;  
Гуравдугаар бүлэг.Анхдугаар чуулган;  
Дөрөвдүгээр бүлэг.Хуулийн төсөл хэлэлцэн батлах;  
Тавдугаар бүлэг.Хууль, тогтоолын эцсийн найруулга хийх, ёсчлох;  
Зургадугаар бүлэг.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах төсөл хэлэлцэх журам  
Долдугаар бүлэг.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэн батлах;  
Наймдугаар бүлэг.Төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, мөнгөний бодлого, эрдэнэсийн сангийн төсөв хэлэлцэх журам;  
Есдүгээр бүлэг.Улсын төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх журам;  
Аравдугаар бүлэг.Олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг хэлэлцэх, гадаад харилцаатай холбогдох асуудал хэлэлцэх журам;  
Арван нэгдүгээр бүлэг.Бусад асуудал хэлэлцэх журам;  
Арван хоёрдугаар бүлэг.Албан тушаалтны бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх, томилох, чөлөөлөх, огцруулах, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх журам;  
Арван гуравдугаар бүлэг.Ерөнхий сайдын мэдээлэл, гишүүний асуулга, асуултын хариуг сонсох;  
Арван дөрөвдүгээр бүлэг.Засгийн газар, холбогдох бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэлийг сонсох, хэлэлцэх;  
Арван тавдугаар бүлэг.Хяналтын сонсгол зохион байгуулах журам;  
Арван зургадугаар бүлэг.Бусад асуудал гэсэн ерөнхий бүтэцтэй байхаар боловсруулна.

**Гурав.Хуулийн төсөл батлагдсаны дараа үүсч болох**

## эдийн засаг, нийгэм, хууль зүйн үр дагавар

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл батлагдсанаар хуралдааны дэгийг сахих, хэлэлцүүлгийг үр дүнтэй, шинжлэх ухааны үндэс, баримт нотолгоонд үндэслэсэн мэтгэлцээнд тулгуурлан явуулах, хуралдааны дэгийг тайлбарлах, хэрэглэх асуудал илүү тодорхой, ойлгомжтой болж, батлагдан гарах хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн чанар сайжрах, хууль тогтоомж хоорондын давхардал, хийдэл, зөрчил багасах, иргэдийн санал, хүсэлтийг чуулганы нэгдсэн хуралдаанд хэлэлцэж, тэдний оролцоог хангах боломж бүрдэнэ.

**Дөрөв.Хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуультай хэрхэн уялдах, хуулийг хэрэгжүүлэхэд шинээр боловсруулах, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, хүчингүй болсонд тооцох тухай хууль тогтоомжийн талаар**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийн хамт боловсруулна.

Мөн одоогийн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулна.

—oOo—

## ДЭЛГЭРЭНГҮЙ ТАНИЛЦУУЛГА

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/-ийн төслийн талаар

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг баталсан бөгөөд тус өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулж “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж заасан.

Улсын Их Хурлаас 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.” гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлд “2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн баталж мөрдөх хүртэл тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө.” гэж тус тус заасан билээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байхаар заасны дагуу чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахтай холбогдсон харилцаанд зохион байгуулалтын шинжтэй холбогдох өөрчлөлтүүдийг тусгах шаардлагатай байна.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааныг 126 гишүүний бүрэлдэхүүнтэйгээр үр дүнтэй зохион байгуулах, хууль тогтоох байгууллагын үйл ажиллагааг бүтээмжтэй, үр нөлөөтэй байлгах, асуудлыг ажил хэрэгч, шударга мэтгэлцээний зарчмаар шийдвэрлэхэд Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын зорилго оршино. Мөн хууль тогтоох үйл ажиллагаанд оролцох Улсын Их Хурлын гишүүдийн ирц, идэвх, оролцоо, сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэхэд чиглэгдэнэ. Ингэхдээ дэлхийн зарим орны парламентын дэгийн сайн туршлагаас холбогдох зохицуулалтыг нэвтрүүлэх, Монголын парламентын үйл ажиллагаанд нутагшуулах асуудлыг анхаарч үзнэ.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэглэх явцад зарим зохицуулалтыг илүү тодорхой

болгох, нарийвчлах, нэр томъёог Үндсэн хууль, бусад хууль, монгол хэлний дүрэмд нийцүүлэх, жигдлэх, хууль зүйн техникийн шинжтэй засвар оруулах практик хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн энэ удаагийн өөрчлөлт, шинэчлэлийг Үндсэн хуулийн хүрээнд шинээр үүссэн онцлог зохицуулалтыг харгалзан, бусад орнуудын туршлагад тулгуурлан шинэчлэн боловсрууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 16 бүлэг, 137 зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгав.

### **Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэг Нийтлэг үндэслэлийн хүрээнд**

Хуулийн төслийн Нэгдүгээр бүлэг буюу “Нийтлэг үндэслэл” 4 зүйлтэй. Хуулийн зорилтыг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн төсөлд зөвхөн хянан шалгах асуудлаар түр хороо байгуулахаар туссантай нийцүүлэн, Монгол Улсын Их Хурлын чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахаар тодорхойлсон.

Төслийн 4 дүгээр зүйлд зарим нэр томъёоны тодорхойлолтыг шинэчлэх замаар дэгийн хэрэглээг ойлгомжтой болголоо. Тухайлбал, төслийн талаарх зарчмын зөрүүтэй саналыг хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд өөрчлөлт оруулахтай холбоотой Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс бичгээр гаргасан, түүний хамт холбогдох үндэслэлээ тайлбарласан саналыг ойлгохоор тодорхой тусгалаа.

### **Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг Чуулганы хуралдааныг зохион байгуулах нийтлэг журмын хүрээнд**

Хуулийн төслийн Хоёрдугаар бүлэг буюу “Чуулганы хуралдааныг зохион байгуулах нийтлэг журам” 13 зүйлтэй. Улсын Их Хурлын гишүүдийн тоог 126 болгож нэмэгдүүлсэнтэй холбогдуулан чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахтай холбогдсон харилцаанд зохион байгуулалтын шинжтэй зарим өөрчлөлтүүдийг тусгалаа.

Үүнд, Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулахаар тусгалаа. Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалт батлах тухай тогтоолд орсон төслийг өргөн мэдүүлсэн дарааллыг нь харгалзан сар бүр хэлэлцэх асуудлын дараалалд оруулж баталдаг байх зохицуулалтыг хийсэн. Хэлэлцэх асуудлын дараалал батлагдсанаас хойш өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулах бол Төрийн байгуулалтын байнгын



хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд танилцуулах, нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн тохиолдолд тогтоолд өөрчлөлт оруулах зохицуулалтыг тусгалаа.

Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Байнгын хороо заавал урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргадаг байх зохицуулалтыг хийсэн болно.

### **Гишүүн хуралдаанд асуулт асуух, үг хэлэх журмын хүрээнд:**

Улсын Их Хурлын гишүүдийн тоо 126 болж нэмэгдсэнтэй холбогдуулж хууль, тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүний үг хэлэх, асуулт асуухтай холбоотой зарим зохицуулалтыг тусгалаа. Үүнд:

-Хуралдаанд асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан тухайн нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилахаар тусгалаа.

-Тухайн нам, эвслийн бүлэг хуваарилагдсан хугацаанд багтаан асуулт асуух гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 16.00 цагаас өмнө хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэх бөгөөд аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух эсэхээ урьдчилан мэдэгддэг байх зохицуулалтыг тусгасан болно.

-Харин Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Улсын төсвийн төсөл, тэдгээрийн биелэлт, гүйцэтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд болон хэлэлцэх дэгийг тусгайлан зохицуулсан бусад асуудлыг хэлэлцэхэд дээрх асуулт асуух хугацаа хамаарахгүй байх зохицуулалтыг тусгав.

-Гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах бөгөөд үг хэлэх хугацаа 4 минутаас илүүгүй байхаар тусгалаа.

-Заасан хугацаанд үг хэлж амжаагүй тохиолдолд үгээ бичгээр илэрхийлж хуралдааны тэмдэглэлд хавсаргах боломжтой байх нөхцөлийг бүрдүүлсэн болно.

### **Хуулийн төслийн Гуравдугаар бүлэг Анхдугаар чуулганыг зохион байгуулахтай холбоотой асуудлын хүрээнд**

Хуулийн төслийн "Анхдугаар чуулган" гэсэн Гуравдугаар бүлэг 11 зүйлтэй бөгөөд 2020 онд баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн зүйл, заалтыг хэвээр хадгалж, Улсын Их Хурлын Анхдугаар чуулганы хуралдааныг зохион байгуулах асуудлын хүрээнд зарим өөрчлөлтийг тусгалаа. Тухайлбал, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга шинээр сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд тангараг өргөж дуустал чуулганы хуралдааныг хөтлөн явуулах зохицуулалтыг тусгав. Мөн Анхдугаар чуулганыг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуралдааны дэгийн дагуу явуулж, Төрийн байгуулалтын байнгын хороо

хуралдааны дэгийг шинэчлэн батлах эсэх асуудлыг Анхдугаар чуулганы хугацаанд хэлэлцэж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулах асуудлыг нэмлээ.

Мөн Хянан шалгах түр хорооны даргыг сонгох асуудлыг Монгол Улсын Их Хурлын Хяналт шалгалтын тухай хуультай нийцүүлэн холбогдох өөрчлөлтийг хийсэн болно.

### **Хуулийн төслийн Дөрөвдүгээр бүлэг Хуулийн төслийг хэлэлцэн батлах журмын хүрээнд**

“Хуулийн төсөл хэлэлцэн батлах” гэсэн Дөрөвдүгээр бүлэг 17 зүйлтэй бөгөөд хууль хуулийн төслийг хэлэлцэх үе шатны зохицуулалтыг боловсронгуй болгож, хуулийн төслийг чанартай, хийдэлгүй батлагдах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусгалаа.

“Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх” гэсэн зүйлийг шинээр нэмж Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлдэг байх зохицуулалтыг хийлээ.

Улсын Их Хурлын тогтоолын төслийг хуулийн төслийн нэгэн адил хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг, эцэслэн батлах гэсэн 4 үе шаттай хэлэлцэх бөгөөд нэн яаралтай хэлэлцүүлэх болон хуульд батлах хугацааг нь тусгайлан зааснаас бусад хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлэг хоорондын хугацаа таваас доошгүй хоног байхаар тусгав.

Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, тогтоолын төслийн танилцуулгыг хийх албан тушаалтан тодорхой болгох, хариуцлагажуулах үүднээс танилцуулах албан тушаалтныг өөрчлөгдөхөөр бол хуралдааны өмнөх өдрийн 17.30 цагаас өмнө урьдчилж мэдэгдэх, хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бол тухайн асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулдаг байх зохицуулалтыг шинээр нэмсэн болно.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгчийн болон Засгийн газраас санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг хийх албан тушаалтан төслийн хэлэлцүүлгийн бүх үе шатанд оролцох үүрэгтэй ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бол тухайн асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулах зохицуулалтыг хийсэн болно.

Хууль, тогтоолын төслийг санаачлагчид нь буцаах, татан авахтай холбогдуулан хууль санаачлагч хууль, тогтоолын төслөө татан авах тохиолдолд татан авах үндэслэлээ бичгээр ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хууль, тогтоолын төслөө татан авсанд тооцох, өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, тогтоолын төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцохоор тусгалаа.

Түүнчлэн Засгийн газар хуульд батлах хугацааг нь тусгайлан зааснаас бусад хууль, тогтоолын төслийг Улсын Их Хурлын анхны ээлжит чуулганаар хэлэлцүүлэх саналаа ээлжит чуулган эхлэхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Улсын Их Хуралд ирүүлдэг байх зохицуулалтыг хийлээ.

Улсын Их Хурлын чуулганаар төслийг яаралтай хэлэлцүүлэх зохицуулалтыг тодорхой болгож Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн боловсруулсан Ерөнхий сайд үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж шийдвэрлүүлэх, нэгдсэн хуралдаан төслийг яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Улсын Их Хурлын дарга тухайн хуулийн төслийг холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын нийт гишүүнд яаралтай хүргүүлж, хуулийн төслийг хэлэлцэн батлах журмын дагуу хэлэлцүүлэхээр тусгалаа.

Улсын Их Хурлын Тамгын газар яаралтай хэлэлцүүлэхээс бусад хуулийн анхдагч, шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулахын өмнө төслийн талаар хууль зүйн дүн шинжилгээ хийж 10-15 өдрийн дотор дүгнэлт гаргах бөгөөд Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, гишүүний гаргасан саналын томъёоллын талаар анхны болон эцсийн хэлэлцүүлэг явуулахын өмнө хууль зүйн дүгнэлт гаргуулж болох зохицуулалтыг шинээр нэмсэн болно.

Мөн Тамгын газар хуулийн төслийг хэлэлцэх эсэх үе шатанд холбогдох Байнгын хорооны хүсэлтээр хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг байхаар тусгалаа.

Мөн Байнгын хороо хуулийн анхдагч болон шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө тухайн хуулийн төсөлтэй долоогоос доошгүй хоногийн хугацаанд танилцах боломжийг гишүүдэд олгох бөгөөд Тамгын газраас хууль, тогтоолын төсөлд хийсэн хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын нийт гишүүдэд хүргүүлсэн байх асуудлыг тусгалаа.

Дэлхийн зарим орны парламентын дэгийн сайн туршлагаас холбогдох зохицуулалтыг нэвтрүүлж, баруун Европын орнуудад түгээмэл тархсан, мөн хувь тэнцүүлсэн сонгуулийн тогтолцоотой улсуудад өргөн хэрэглэгддэг мэтгэлцээний зарчмыг тусгасан болно. Үүнд, нам, эвслийн бүлгээс санал, дүгнэлт гаргахдаа үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцэх шаардлагатай гэсэн санал, дүгнэлт гаргасан бол Байнгын хорооны хуралдаанаар мэтгэлцээн явуулах, хуралдаан даргалагч хэлэлцэж байгаа асуудлын цар хүрээнээс хамаарч мэтгэлцээний үргэлжлэх хугацааг тогтоодог байх, мэтгэлцээнийг удирдаж явуулахдаа дэгийг чанд мөрдүүлж, хэлэлцэж байгаа асуудлын хүрээ хязгаарыг баримтлах, төвийг сахисан, талуудын тэнцвэртэй, тэгш оролцоог хангаж удирдах үүрэгтэй байхаар төсөлд тусгаад байна.

Ингэснээр нам, эвслийн бүлгүүд хуулийн төслийн талаарх санал, дүгнэлтээ урьдчилан гаргаж, тухайн санал дүгнэлтийн үндэслэлээ нэгдсэн хуралдаанд танилцуулах замаар иргэд олон нийтэд тухайн хууль тогтоомжийн төслийн хэрэгцээ, шаардлага, ач холбогдлыг таниулах, өөрсдийн байр сууриа илэрхийлэх боломжийг

бүрдүүлэх юм. Үүний үр дүнд хууль тогтоомжийн чанар, үр нөлөө дээшилнэ гэж үзэж байна.

Байнгын хорооны хуралдаанд гишүүд, хууль санаачлагчаас гадна тухайн салбарын эрдэмтэн, судлаачдыг оролцуулах зохицуулалтыг тусгаж гишүүд, хууль санаачлагч, бусад оролцогчид баримт, нотолгоонд суурилсан, үнэн, бодитой мэдээлэлд тулгуурлаж асуулт асууж, хариулт өгч мэтгэлцээнд оролцох зохицуулалтыг тусгалаа.

Нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах үеэр Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаагаар үг хэлнэ. Гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэхдээ индэрээс үг хэлэхээр тусгалаа.

Мөн үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хууль, тогтоолын төслийг нэг жилийн дотор дахин өргөн мэдүүлэхгүй байх зохицуулалтыг тусгасан болно.

Байнгын хорооноос хууль, тогтоолын төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулах, ажлын хэсгийн бүрэлдэхүүн, ажлын хэсгийн ахлагчийг томилох, ажлын хэсэг хуралдахад баримтлах дэгийг тодорхой болгов.

Мөн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар санал, дүгнэлт гаргах хүрээ, хязгаарыг уян хатан болголоо.

Гишүүн, нам, эвслийн бүлэг хууль, тогтоолын төсөлд зарчмын зөрүүтэй санал гаргах бол саналаа Байнгын хороонд хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас тодорхой хугацааны өмнө бичгээр урьдчилан ирүүлэх, тухайн зарчмын зөрүүтэй санал нь үндэслэл бүхий байх шаардлагыг тусгалаа.

Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль хоорондын нийцлийг хангуулахаар холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан, хамтад нь хэлэлцүүлэх боломжийг бүрдүүлнэ.

### **Хуулийн төслийн Тавдугаар бүлэг Хууль, тоогтоолын төслийн эцсийн найруулга хийх, ёсчлох асуудлыг хүрээнд**

Хуулийн төслийн “Хууль, тогтоолын төслийн эцсийн найруулга хийх, ёсчлох” гэсэн Тавдугаар бүлэг 1 зүйлтэй бөгөөд хууль хуулийн төслийг хэлэлцэх үе шатны зохицуулалтыг боловсронгуй болгож, хуулийн төслийг чанартай, хийдэлгүй батлагдах нөхцөлийг бүрдүүлэхэд чиглэсэн зохицуулалтыг тусгасан. Мөн “Төрийн мэдээлэл” эмхэтгэл цаасан болон цахим хэлбэртэй байх зохицуулалтыг тусгаснаар хууль тогтоомжийг иргэд, олон нийтэд цаг алдалгүй шуурхай хүргэх, хүртээмжийг дээшлүүлэх ач холбогдогдолтой гэж үзэж байна.

### **Хуулийн төслийн Зургадугаар бүлэг Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх асуудлын хүрээнд**

Хуулийн төслийн “Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх” гэсэн Зургадугаар бүлэг 9 зүйлтэй бөгөөд 2020 оны хуулийн зүйл, заалтад зарчмын өөрчлөлт оруулаагүй болно.

**Хуулийн төслийн Долдугаар бүлэг Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн төслийн хэлэлцэх ерөнхий журмын хүрээнд**

Хуулийн төслийн “Хөгжлийн бодлого төлөвлөлтийн баримт бичгийн төслийн хэлэлцэх үе шат, хэлэлцүүлгийн ерөнхий журам” гэсэн Долдугаар бүлэг 8 зүйлтэй.

Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хэлэлцэн батлах үе шаттай холбоотой 2021 оны хуулийн холбогдох зүйл заалтыг хэвээр хадгална.

**Хуулийн төслийн Наймдугаар бүлэг Төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, мөнгөний бодлого, Эрдэнэсийн сангийн төсөв хэлэлцэх журмын хүрээнд**

Төслийн “Төсвийн хүрээний мэдэгдэл, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, мөнгөний бодлого, Эрдэнэсийн сангийн төсөв хэлэлцэх журам” гэсэн Наймдугаар бүлэг 5 зүйлтэй.

Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэж батлах журамд дараах зарчмын өөрчлөлтийг тусгалаа. Үүнд:

-Тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаар нэгдсэн хуралдаанд илтгэхдээ төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажилласан, гарсан үр дүнг хэрхэн тусгасан талаар танилцуулах, олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан санал, түүнийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгасан байдалд Тамгын газар дүн шинжилгээ хийх зохицуулалтыг шинээр нэмлээ.

-Мөн тухайн жилийн төсвийн төслийг боловсруулахад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах шаардлагатай гэж Засгийн газар үзвэл төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлтэй хамт Улсын Их Хуралд өргөн мэдүүлж, шийдвэрлүүлэхээр төсөлд тусгасан болно.

-Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийг хуульд заасан хугацаанд заавал батлах хуулийн зохицуулалттай тул Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар нэг, хоёр, гурав дахь хэлэлцүүлэг явуулж батлах зохицуулалтыг хийлээ.

Мөнгөний бодлого, Эрдэнэсийн сангийн төсвийн төслийг “Улсын Их Хурал хуульд тусгайлан заасан бусад асуудал хэлэлцэх” дэгийн дагуу Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гарган шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулах, нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, холбогдох шийдвэрийг гаргахаар тусгасан болно.

## **Хуулийн төслийн Есдүгээр бүлэг Улсын төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх журмын хүрээнд**

“Улсын төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх журам” гэсэн Есдүгээр бүлэг 6 зүйлтэй бөгөөд дараах зарчмын шинжтэй өөрчлөлтийг тусгасан болно.

Улсын төсвийн төслийг Улсын Их Хурал 10 дугаар сарын эхний 7 хоногт хэлэлцэж эхлэх ба 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор батлахаар тусгалаа.

Улсын төсөв, түүний гүйцэтгэлийг хэлэлцэх дэгийн зохицуулалтыг боловсронгуй болгох зорилгоор дараах зохицуулалтыг нэмсэн болно. Үүнд:

-Улсын Их Хурал Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн төсвийг батлахдаа энэ бүлэгт заасан Улсын төсвийг хэлэлцэн батлах журмыг баримтлах;

- Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэгт төсвийн төслийн талаарх илтгэлийг ерөнхий сайд, тухайн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаарх төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тус Зөвлөлийн дарга тус тус танилцуулна. Ерөнхий сайдын илтгэлд төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажилласан байдал, гарсан үр дүнг төсвийн төсөлд тусгасан талаар танилцуулах;

-Төсвийн төсөлтэй холбогдуулан Төрийн аудитын төв байгууллага болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөл дүгнэлт хийхээс гадна төсөв нь Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд тусгасан зорилт, холбогдох шалгуур үзүүлэлт тус бүрээр төсөвлөсөн эсэх талаар Тамгын газар дүн шинжилгээ хийх;

-Улсын Их Хурал төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийсний дараа Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулах;

- Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг Байнгын болон дэд хорооны хуралдаанаар хийх үед гишүүд Байнгын хорооны өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хамаарах асуудлаар хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болох;

- Байнгын хороод, нам, эвслийн бүлэг төсвийн гүйцэтгэлийн хоёр дахь хэлэлцүүлгийг хийх үед төсвийн гүйцэтгэлийн талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний илтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг сонсож, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч асуулт асууж, үг хэлж, гаргасан санал дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд өгөх ба тус дэд хороо эдгээр санал, дүгнэлтийг хэлэлцэн, нэгтгэн гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулдаг байх зохицуулалтыг тусгасан болно.

**Хуулийн төслийн Аравдугаар бүлэг Олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг хэлэлцэх, гадаад харилцаатай холбогдох асуудал хэлэлцэх журмын хүрээнд:**

“Олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг хэлэлцэх, гадаад харилцаатай холбогдох асуудал хэлэлцэх журам” гэсэн Аравдугаар бүлэг 8 зүйлтэй.

Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар Улсын Их Хурал соёрхон батлах хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах бол уг олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний эцэслэн тохиролцсон, эсхүл үзэглэсэн төсөл, эсхүл баталсан буюу жинхэлсэн эх бичвэрийн хуулбар, боломжтой бол баталгаат хуулбар, тэдгээрийн орчуулга, олон улсын гэрээнд нэгдэн орсноор Монгол Улсад үзүүлэх үр нөлөө, үр дагаврын талаарх дүн шинжилгээний хамт тухайн олон улсын гэрээнд гарын үсэг зурахаас өмнө Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлэх асуудлыг тусгасан.

Мөн дараах олон улсын гэрээний тухайд олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг дараах Байнгын хороо тус тусдаа урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлдэг байхаар нэмэлт орууллаа. Үүнд:

-Чөлөөт худалдаа, давхар татвар, хөрөнгө оруулалттай холбоотой олон улсын гэрээний төслийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо;

-Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн олон улсын гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээний төслийг Хууль зүйн байнгын хороо;

-Хүний салшгүй эрх, эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээний төслийг Хууль зүйн байнгын хороо хэлэлцэхээр төсөлд тусгав.

### **Хуулийн төслийн Арван нэгдүгээр бүлэг Бусад асуудлын хүрээнд**

“Бусад асуудал” гэсэн Арван нэгдүгээр бүлэг 13 зүйлтэй бөгөөд Ард нийтийн санал асуулга явуулах, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх журам, Албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх, албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх, Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тогтоолоор хууль, тогтоолын зарим зүйл, хэсэг, заалт хүчингүй болсонтой холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэх журам, Цэцэд хүсэлт гаргах, Цэцийн хуралдаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох, тайлбар гаргах, Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хэлэлцэх, Монгол Улсын Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны танилцуулгыг хийх, Онц болон дайны байдал зарлах, цуцлах асуудлыг хэлэлцэх, Улсын Их Хурал тарах асуудлыг хэлэлцэх, ээлжит бус сонгууль товлон зарлах холбоотой зохицуулалтыг хийв.

Улсын Их Хурал Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэхдээ хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол энэ тухай тогтоолыг ажлын 10 өдрийн дотор ёсчилж Цэцэд хүргүүлэх, онц болон дайны байдал зарласан, цэрэг хөдөлгөх тухай, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн, эсхүл бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр нь Үндсэн хуульд нийцсэн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хойшлуулшгүй хэлэлцэх асуудлыг тусгалаа.

Мөн Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх асуудлыг нарийвчлан тусгасан.

Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасны дагуу нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг Улсын Их Хурлаас тусгайлан ажиллуулсан санал хүлээн авах цахим системд 30 хоногийн хугацаатай байршуулах бөгөөд цахим системд байршуулсан нийтийн өргөдлийг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэдийн дэмжсэн санал Монгол Улсын Их Хурлын тухай хуульд заасан тоонд хүрсэн тохиолдолд Улсын Их Хурал авч хэлэлцээд холбогдох бодлогын баримт бичиг, хууль, тогтоолын төсөл боловсруулах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх, Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах, Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн хууль тогтоомжийн төсөл, бодлогын баримт бичиг боловсруулах үүрэг бүхий ажлын хэсэг байгуулах асуудлаар санал гаргах, олон нийтийн хэлэлцүүлэг, Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах, мөн гишүүн нийтийн өргөдөлд хамаарах асуудлаар холбогдох хуулийн төсөл санаачилж болох асуудлыг тусгалаа.

**Хуулийн төслийн Арван хоёрдугаар бүлэг Албан тушаалтны бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх, томилох, чөлөөлөх, огцруулах, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх журмын хүрээнд**

Арван хоёрдугаар бүлэг 16 зүйлтэй бөгөөд тус бүлэгт Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд тангараг өргөх асуудлыг шинээр нэмж тусгалаа.

Мөн Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад суух элчин сайд, бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол тухайн саналыг ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлнэ. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо тухайн саналыг Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлснээс хойш ажлын гурван өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Хэрэв нэр дэвшигчийн сонсгол явуулах санал гарсан бол сонсголын тайлан гаргаснаас хойш ажлын таван өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргах зохицуулалтыг тусгасан болно.

**Хуулийн төслийн Арван гуравдугаар бүлэг Ерөнхий сайдын мэдээлэл, гишүүний асуулга, асуултын хариуг сонсох асуудлын хүрээнд**

Төслийн Арван гуравдугаар бүлэг 3 зүйлтэй. Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл, Гишүүний асуулга, асуултын хариуг хэлэлцэхтэй холбоотой харилцааг зохицуулсан. Улсын Их Хурлын гишүүдийн тоо 126 болж нэмэгдсэнтэй холбогдуулан



мэдээлэл хийх, асуулт асуух, асуулгын хариуг хэлэлцэхэд баримтлах хугацааг тодорхой тусгасан болно.

**Хуулийн төслийн Арван дөрөвдүгээр бүлэг Засгийн газар, холбогдох бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэлийг сонсох, хэлэлцэх асуудлын хүрээнд**

“Засгийн газар, холбогдох бусад байгууллагын тайлан, мэдээлэл, илтгэлийг сонсох, хэлэлцэх асуудал” гэсэн Арван дөрөвдүгээр бүлэг 4 зүйлтэй. Улсын Их Хурлаар хэлэлцэхээр хуульд тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээллийг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлэх, түүнд Улсын Их Хурлын Тамгын газар дүн шиинжилгээ хийх, Байнгын хороонд эрхлэх асуудлын хүрээнд тухайн тайлан, мэдээллийг хэлэлцэх, шийдвэр гаргах асуудлыг тодорхой тусгасан болно.

Мөн Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн явцын тайланг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэх асуудлыг зохицуулна.

**Хуулийн төслийн Арван тавдугаар бүлэг Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах журмын хүрээнд**

“Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах журам” гэсэн Арван тавдугаар бүлэг 15 зүйлтэй. Улсын Их Хурлын хяналтын сонсгол явуулах хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх, сонсгол зохион байгуулах харьяалал, сонсголын бэлтгэл хангах, сонсгол даргалагч, оролцогчийн эрх, үүрэг, сонсголыг явуулах журам, сонсголын тайлан, тэмдэглэлийг албажуулах зэрэг асуудлыг тодорхой тусгасан.

Мөн Улсын Их Хурлын хяналтын сонсголд хамаарах зохицуулалтыг Улсын Их Хурлын хяналт, шалгалтын тухай хуульд нийцүүлж холбогдох өөрчлөлтүүдийг хийлээ.

**Хуулийн төслийн Арван зургадугаар бүлэг  
Бусад асуудлын хүрээнд**

Арван зургадугаар бүлэг нь “Чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх журам”, “Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журам”, “Хуралдааны тэмдэглэлийг ашиглах, хадгалах журам”, “Хууль хүчин төгөлдөр болох” гэсэн 4 зүйлтэй.

Чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, ажлын хэсэг, хуралдааны тэмдэглэлийг бичгээр болон цахим мэдээлэл тээгчид нэгэн зэрэг дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан хадгалах ба хуралдааны тэмдэглэл дэлгэрэнгүй ба товч гэсэн хэлбэртэй байх бөгөөд хуралдааны тэмдэглэлд санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналыг тусгахаас гадна хуралдааны дэг сахиулахтай холбогдуулан авсан арга хэмжээний талаар тусгах зохицуулалтыг нэмсэн.

Мөн хуралдааны тэмдэглэл болон дуу, дүрсний бичлэгийг чуулганы мэдээлэл бэлтгэж нийтлэх, хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл, лавлагаа өгөх, маргаантай асуудлыг шийдвэрлэх зорилгод ашиглах ба Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулж олон нийт танилцах бололцоог бий болгосон.

Хуралдааны тэмдэглэлийг хадгалах, ашиглахтай холбоотой нарийвчилсан журмыг Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга батлахаар тусгасан болно.

**Холбогдуулан боловсруулсан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн хүрээнд:**

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай болон холбогдох бусад хуулийн төслийн хамт боловсрууллаа.

Хууль тогтоомжийн тухай хуульд хуулийн төсөлд санаачлагч өргөн мэдүүлэх хууль, тогтоомжийн төсөлдөө хүний эрхэд нөлөөлөх байдлын үнэлгээг хийж, зөвлөмж гаргах зохицуулалтыг нэмсэн. Мөн хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нэн яаралтай өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөл Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангасан эсэхэд хууль зүйн дүгнэлт гаргадаг байх зохицуулалтыг нэмсэн болно.

Улсын Их Хурлын Тамгын газар Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ирүүлсэн хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хянахдаа тухайн төсөл нь Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлага хангасан, тандан судалсан эсэх, судалгаанд үндэслэн боловсруулсан эсэх, үзэл баримтлалын хүрээнд боловсруулсан эсэх, санаачлах хүрээ хязгаар, зардлын тооцооллыг холбогдох журмын дагуу боловсруулсан эсэхийг хянан үзэж дүгнэлт гаргах, шаардлагыг хангасан бол өргөн мэдүүлэх товыг хууль санаачлагчид албан бичгээр хүргүүлэх асуудлыг нэмлээ.

Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан нь хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хууль тогтоомжийн төслийг Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх, уялдааг шалгах боломжтой мэдээллийн шинэ технологид тулгуурласан шийдэлтэй байх зохицуулалтыг хийлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, мөн одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

--oOo--

**МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ  
ДЭГИЙН ТУХАЙ ХУУЛИЙН ШИНЭЧИЛСЭН НАЙРУУЛГЫН  
ТӨСЛИЙН ТАЛААРХ ТОВЧ ТАНИЛЦУУЛГА**

Монгол Улсын Үндсэн хуулийн Хорьдугаар зүйлд “Монгол Улсын Их Хурал бол төрийн эрх барих дээд байгууллага мөн бөгөөд хууль тогтоох эрх мэдлийг гагцхүү Улсын Их Хуралд хадгална.” гэж, Хорин тавдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Улсын Их Хурлын бусад бүрэн эрх, зохион байгуулалт, үйл ажиллагааны журмыг хуулиар тогтооно.” гэж тус тус заасан.

Улсын Их Хурал 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг баталсан бөгөөд тус өөрчлөлтөөр Үндсэн хуулийн Хорин нэгдүгээр зүйлийн 1 дэх хэсгийг бүхэлд нь өөрчлөн найруулж “Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байна. Улсын Их Хурлын сонгуулийг сонгуулийн холимог тогтолцоогоор явуулна. Улсын Их Хурлын далан найман гишүүнийг олныг төлөөлөх, дөчин найман гишүүнийг хувь тэнцүүлэн төлөөлөх аргаар сонгоно.” гэж заасан.

Улсын Их Хурлаас 2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг дагаж мөрдөхөд шилжих журмын тухай хуулийн 1 дүгээр зүйлд “Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтийг 2024 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс эхлэн улс орон даяар дагаж мөрдөнө.” гэж, мөн хуулийн 3 дугаар зүйлд “2023 оны 05 дугаар сарын 31-ний өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөд нийцүүлэн холбогдох хуульд өөрчлөлт оруулах болон шинэчлэн баталж мөрдөх хүртэл тухайн харилцааг зохицуулж ирсэн хуулийг дагаж мөрдөнө.” гэж тус тус заасан билээ.

Иймд Монгол Улсын Үндсэн хуульд оруулсан өөрчлөлтөөр Улсын Их Хурал нэг танхимтай, нэг зуун хорин зургаан гишүүнтэй байхаар заасны дагуу чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, түр хорооны хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахтай холбогдсон харилцаанд зохион байгуулалтын шинжтэй холбогдох өөрчлөлтүүдийг тусгах шаардлага үүссэн.

Түүнчлэн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг хэрэглэх явцад зарим зохицуулалтыг илүү тодорхой болгох, нарийвчлах, нэр томьёог Үндсэн хууль, бусад хууль, монгол хэлний дүрэмд нийцүүлэх, жигдлэх, хууль зүйн техникийн шинжтэй засвар оруулах практик хэрэгцээ, шаардлага байна гэж үзсэн болно.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн энэ удаагийн өөрчлөлт, шинэчлэлийг Үндсэн хуулийн хүрээнд шинээр үүссэн онцлог зохицуулалтыг харгалзан, бусад орнуудын туршлагад тулгуурлан шинэчлэн боловсрууллаа.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл нь 16 бүлэг, 136 зүйлтэй бөгөөд хуулийн төсөлд дараах зарчмын шинжтэй зохицуулалтыг тусгав.

Улсын Их Хурлын гишүүдийн асуулт асуух, үг хэлэх, санал хураах журам, хугацаанд холбогдох өөрчлөлтийг оруулж, хуулийн төсөл хэлэлцэх үед нэгдсэн хуралдаанд асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан тухайн нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилахаар тусгалаа.

Тухайн нам, эвслийн бүлэг хуваарилагдсан хугацаанд багтаан асуулт асуух гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 16.00 цагаас өмнө хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэх бөгөөд аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух эсэхээ урьдчилан мэдэгддэг байх зохицуулалтыг тусгасан болно.

Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Улсын төсвийн төсөл, тэдгээрийн биелэлт, гүйцэтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд болон хэлэлцэх дэгийг тусгайлан зохицуулсан бусад асуудлыг хэлэлцэхэд дээрх асуулт асуух хугацаа хамаарахгүй байх зохицуулалтыг тусгалаа.

Мөн дэг тогтоох олон улсын жишигт нийцсэн мэтгэлцээний зарчмыг тусгаж, нам, эвслийн бүлгээс санал, дүгнэлт гаргахдаа үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцэх шаардлагатай гэж үзсэн тохиолдолд Байнгын хорооны хуралдаанд хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх, анхны хэлэлцүүлгийн үе шатуудыг мэтгэлцэх зарчмаар явуулах зохицуулалтыг тусгав.

Хууль, тогтоолын төслийг хэлэлцэх үе шатны зохицуулалтыг боловсронгуй болгож, Чуулганы хуралдааны тов, дарааллыг тогтоох, түүнийг гишүүдэд мэдээлэхтэй холбоотой зохицуулалтыг нарийвчлан тодорхойлж, хуулийн төслийг хэлэлцэх дарааллыг тогтоохдоо түүнийг өргөн мэдүүлсэн хугацааг харгалзан үздэг байх, Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг буцаах зохицуулалтыг тусгалаа.

Түүнчлэн Улсын Их Хурлын Тамгын газраас холбогдох Байнгын хороо хууль, тогтоолын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө хууль, тогтоолын төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцэж байгаа эсэх, тухайн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдсөн эсэх, хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд шаардлагатай бүх хууль, зүйл, хэсэг, заалтыг хамааруулсан эсэх зэрэг асуудлаар хууль зүйн дүн шинжилгээ хийж дүгнэлт гаргадаг байх, Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй хуулийн төслийг тодорхой хугацааны дотор дахин өргөн мэдүүлэхгүй байх зохицуулалтыг тусгалаа.

Мөн Тамгын газар хуулийн төслийг хэлэлцэх эсэх үе шатанд холбогдох Байнгын хорооны хүсэлтээр хууль хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийж, дүгнэлт гаргадаг байхаар тусгалаа.

Улсын Их Хурлын гишүүн, нам, эвслийн бүлэг хууль, тогтоолын төсөлд зарчмын зөрүүтэй санал гаргах бол саналаа Байнгын хороонд хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас тодорхой хугацааны өмнө бичгээр урьдчилан ирүүлсэн байх, Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль хоорондын уялдааг хангуулахаар холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болох зохицуулалтыг тусгасан болно.

Мөн Байнгын хороонд хуулийг дагаж мөрдөх журмын буюу шилжилтийн үеийн зохицуулалт, хуулийг дагаж мөрдөх хугацааны талаар эцсийн хэлэлцүүлгийн шатанд санал, дүгнэлт гаргах боломжийг нээн өгч, Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хоёр болон олон талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийг нийт гишүүний олонхын саналаар эцэслэн батлах, ингэхдээ олон улсын гэрээтэй хамт бусад хууль тогтоомжид өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлсэн тохиолдолд хамтатган хэлэлцэж, олон улсын гэрээг соёрхон батлах хуулийн төсөл, бусад хууль тогтоомжийн төслийн уялдааг хангасны үндсэн дээр хамтад нь эцэслэн батлах зэрэг зохицуулалтыг тусгав.

Чуулганы хуралдааны үеэр Улсын Их Хурлын гишүүдийн сахилга, хариуцлагыг нэмэгдүүлэх, дэг сахихтай холбоотой зарим зохицуулалтыг шинэчилсэн болно.

Мөн Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн хэрэглээг ойлгомжтой болгоход чиглэсэн бүтэц, нэр томьёо, хууль зүйн техникийн шинжтэй бусад өөрчлөлтийг тусгаж, Чуулганы хуралдааныг зохион байгуулах нийтлэг журам", "Олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг хэлэлцэх, гадаад харилцаатай холбогдох асуудал" хэлэлцэх зэрэг бие даасан бүлгүүдийг нэмсэн болно. Эрдэнэсийн сангийн төсөв хэлэлцэх, Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд тангараг өргөх, Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулахтай холбоотой зарим зохицуулалтыг нэмж бүтцийн хувьд зохих өөрчлөлтийг хийлээ.

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төслийн хамт Хууль тогтоомжийн тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай, Олон улсын гэрээний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Монгол Улсын Засгийн газрын тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Нийтийн сонсголын тухай хуульд нэмэлт оруулах тухай, Төсвийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, мөн одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцох тухай хуулийн төслийг боловсруулсан болно.

--oOo--

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫ ДЭГИЙН ТУХАЙ /Шинэчилсэн найруулга/

#### НЭГДҮГЭЭР БҮЛЭГ НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

##### 1 дүгээр зүйл.Хуулийн зорилт

1.1.Энэ хуулийн зорилт нь Монгол Улсын Их Хурал /цаашид "Улсын Их Хурал" гэх/-ын чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдааныг зохион байгуулах, хуралдаанаар хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл, тодорхой асуудал хэлэлцэх, санал хураах, шийдвэр гаргахтай холбогдсон харилцааг зохицуулахад оршино.

##### 2 дугаар зүйл.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хууль тогтоомж

2.1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн хууль тогтоомж нь Монгол Улсын Үндсэн хууль<sup>1</sup>, Монгол Улсын Их Хурлын тухай хууль<sup>2</sup>, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль<sup>3</sup> болон энэ хуулиас бүрдэнэ.

##### 3 дугаар зүйл.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны үндсэн зарчим

3.1.Улсын Их Хурлын чуулганы хуралдаан хууль дээдлэх, нээлттэй, ил тод байх, асуудлыг хэлэлцэхэд чөлөөтэй, эрх тэгш оролцоог хангах, цөөнхийн эрхийг хүндэтгэх, хэлэлцүүлгийн горим ойлгомжтой, тодорхой байх, олонхын саналаар шийдвэр гаргах зарчимд үндэслэнэ.

3.2.Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэг /цаашид "хуралдааны дэг" гэх/-ээр тусгайлан зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх дэгийг Улсын Их Хурал өөрөө тогтооно.

3.3.Чуулганы хуралдааныг хүчин төгөлдөр мөрдөж байгаа хуралдааны дэгийн дагуу явуулна.

##### 4 дүгээр зүйл.Хуулийн нэр томъёоны тодорхойлолт

4.1.Энэ хуульд хэрэглэсэн дараах нэр томъёог доор дурдсан утгаар ойлгоно:

<sup>1</sup> Монгол Улсын Үндсэн хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1992 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

<sup>2</sup> Монгол Улсын Их Хурлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2020 оны 22 дугаарт нийтлэгдсэн.

<sup>3</sup> Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2022 оны 5 дугаарт нийтлэгдсэн.

4.1.1.“чуулганы хуралдаан” гэж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 15.2-т заасныг;

4.1.2.“Зөвлөл” гэж Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.3-т заасан Улсын Их Хурлын даргын дэргэд ажиллах зөвлөлийг;

4.1.3.“горимын санал” гэж Улсын Их Хурлын гишүүнээс зөвхөн хэлэлцэж байгаа асуудлаар болон тухайн асуудлыг хэлэлцэх дараалал, журмын талаар гаргасан саналыг;

4.1.4.“зарчмын зөрүүтэй санал” гэж хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөлд өөрчлөлт оруулахтай холбоотой асуудлаар Улсын Их Хурлын гишүүн, Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс үндэслэлээ тайлбарлаж бичгээр гаргасан саналыг;

4.1.5.“найруулгын санал” гэж хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийн үзэл баримтлал, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр зүйл, хэсэг, заалтыг уялдуулан дэс дараалал, бүтцэд өөрчлөлт оруулах, нэр томъёог жигдлэх, үг, өгүүлбэр, хэллэгийг монгол хэлний дүрэмд нийцүүлэхтэй холбоотой саналыг;

4.1.6.“хуулийн төслийг эцэслэн батлах” гэж хуулийн төслийг хэлэлцэх дөрөв дэх үе шатанд төслийг батлах санал хураалтыг.

## **ХОЁРДУГААР БҮЛЭГ ЧУУЛГАНЫ ХУРАЛДААНЫГ ЗОХИОН БАЙГУУЛАХ НИЙТЛЭГ ЖУРАМ**

### **5 дугаар зүйл.Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудал, түүний дарааллыг тогтоох журам**

5.1.Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл болон батлах хугацааг нь хуульд тусгайлан заасан хууль, Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төслийг оруулна.

5.2.Нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд хороо, хууль санаачлагч нь дараагийн ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын талаарх саналаа чуулган дуусахаас ажлын 10 өдрийн өмнө Төрийн байгуулалтын байнгын хороонд ирүүлсэн байна.

5.3.Нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд хороо, хууль санаачлагч нь энэ хуулийн 5.2-т заасан хугацаанд санал ирүүлээгүй бол ээлжит чуулганы хэлэлцэх асуудлын талаар тусгайлан өгөх саналгүй гэж үзнэ.

5.4.Төрийн байгуулалтын байнгын хороо дараагийн ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын талаарх нам, эвслийн бүлэг, Байнгын, дэд хороо, хууль санаачлагчийн саналыг нэгтгэн Зөвлөлд танилцуулах бөгөөд Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын бусад шийдвэрийн төсөл /цаашид “тогтоолын төсөл” гэх/-ийг боловсруулан нэгдсэн хуралдаанд оруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар тогтоолын төслийг батална.

5.5.Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлыг баталсан Улсын Их Хурлын тогтоолд заасан хууль, тогтоолын төслийн хэлэлцэх дарааллыг Зөвлөлийн санал,

өргөн мэдүүлсэн дарааллыг харгалзан Улсын Их Хурлын дарга сар бүр захирамжаар батална.

5.6.Энэ хуулийн 5.5-д заасан дарааллыг үндэслэн хэлэлцэх асуудлын цаглаврыг Байнгын хороод баталж, мөрдүүлнэ.

5.7.Ээлжит чуулганаар хэлэлцэх асуудлын жагсаалтад ороогүй хууль, тогтоолын төсөл өргөн мэдүүлснийг хэлэлцэх асуудлын дараалалд оруулах шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг Төрийн байгуулалтын байнгын хороо хэлэлцэж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна. Нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол энэ хуулийн 5.4-т заасан тогтоолд өөрчлөлт оруулна.

## **6 дугаар зүйл.Хуралдааны тов, дараалал тогтооход баримтлах журам**

6.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурлын чуулганы хуралдаанаар хэлэлцэх асуудлыг Байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Ийнхүү хэлэлцээгүй асуудлыг чуулганы нэгдсэн хуралдаанд оруулахгүй.

6.2.Нэгдсэн хуралдаан долоо хоног бүрийн Пүрэв, Баасан гарагт 10.00-13.00, 14.00-18.00 цагт хуралдана. Гишүүд өглөө 9.00 цагаас эхлэн ирцэд бүртгүүлж, хуралдаанаар асуудал хэлэлцэхэд бэлтгэнэ. Товлосон асуудлыг ажлын цагт багтаан хэлэлцэж дуусаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар хуралдааны цагийг сунгаж болно.

6.3.Ажлын зайлшгүй шаардлага гарвал Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдааныг энэ хуулийн 6.2-т зааснаас бусад ажлын өдөр зарлан хуралдуулж болно.

6.4.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам, эвслийн бүлгийн хуралдааныг долоо хоногийн Даваа гарагт, Байнгын, дэд, хянан шалгах түр хороодын хуралдааныг Мягмар, Лхагва гарагт, шаардлагатай бол энэ хуулийн 6.3-т заасныг баримтлан бусад ажлын өдөрт зохион байгуулж болно.

6.5.Байнгын хорооны хуралдааны санал хураалтыг бусад Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны санал хураалттай давхцуулахгүйгээр зохион байгуулна.

6.6.Тухайн долоо хоногт нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, ажлын хэсгийн хуралдаанаар хэлэлцэх асуудлын тов, дарааллыг энэ хуулийн 5.4, 5.5-д заасан хэлэлцэх асуудлын дарааллыг баримталж, Зөвлөлийн саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга батална.

6.7.Энэ хуулийн 6.6-д заасан хэлэлцэх асуудлын тов, дарааллыг Улсын Их Хурлын нийт гишүүдэд харилцаа холбооны хэрэгсэл ашиглан мэдэгдэж, Улсын Их Хурлын цахим хуудаст нийтэлнэ.

6.8.Нам, эвслийн бүлэг энэ хуулийн 6.6-д заасныг харгалзан тухайн долоо хоногийн хуралдааны хэлэлцэх асуудал, дарааллыг өөрсдөө тогтооно.

6.9.Нам, эвслийн бүлэг энэ хуулийн 6.6-д заасан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхээр тогтсон асуудлыг хойшлуулах, дараалал өөрчлөх, асуудал нэмэх



горимын санал гаргах бол Улсын Их Хурлын даргад нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 17.00 цагаас өмнө үндэслэлээ тодорхой бичиж ирүүлнэ.

6.10.Хуралдаан даргалагч тухайн өдрийн хуралдааныг нээж, хэлэлцэх асуудалтай холбоотой нам, эвслийн бүлгээс ирүүлсэн горимын саналыг уншиж танилцуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ. Энэ талаар хэлэлцүүлэг явуулахгүй.

6.11.Төрийн ёслол, хүндэтгэлийн үйл ажиллагаанд гишүүд оролцох, хуралдаанаар хэлэлцэх асуудалтай холбогдуулан нам, эвслийн бүлэгт саналаа зөвшилцөх боломж олгох зорилгоор хуралдаан даргалагч нэгдсэн хуралдааны эхлэх цагийг энэ хуулийн 6.2-т зааснаас өөрөөр тогтоож болно.

## **7 дугаар зүйл.Хуралдааны ирц**

7.1.Хуралдааныг гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно.

7.2.Улсын Их Хурлын гишүүн хуралдаан эхлэх цагаас өмнө суудлаа эзэлсэн байна.

7.3.Гишүүн өвчтэй буюу өвчтэй хүн асарсан, гадаад, дотоод томилолтоор явсан, түүнчлэн хурал, зөвлөгөөнд зайлшгүй оролцох шаардлагатай байсан бол хүндэтгэх шалтгаантай гэж үзэх бөгөөд хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд ирээгүй бол хуралдаан тасалсанд тооцно.

7.4.Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд хүрэлцэн ирэх боломжгүй бол хуралдаан даргалагчид энэ хуулийн 7.3-т заасан шалтгаан, үндэслэлээ бичгээр урьдчилан мэдэгдэнэ.

7.5.Монгол Улсын Үндсэн хуулийн тодорхой заалтыг илтэд зөрчсөн асуудал хэлэлцсэн, эсхүл Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулахыг эсэргүүцэхээс бусад шалтгаанаар нам, эвслийн бүлэг, гишүүн хуралдаанд оролцохгүй байх буюу түүнийг орхиж гарахыг хориглоно.

7.6.Хуралдаанд хүрэлцэн ирсэн гишүүн хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанаас түр гарах тохиолдолд хуралдаан даргалагчаас зөвшөөрөл авна.

7.7.Гишүүн хуралдааны ирцэд бүртгүүлэхдээ биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өөр идэвхжих цахим систем ашиглана.

7.8.Хуралдаан даргалагч хуралдааны ирцийг гишүүний сонгогдсон тойрог, нэрээр дараах дарааллаар танилцуулна:

7.8.1.хүрэлцэн ирсэн гишүүн;

7.8.2.хүндэтгэн үзэх шалтгаанаар хуралдаанд ирээгүй гишүүн, түүний шалтгаан, үндэслэл;

7.8.3.хуралдаан тасалсан гишүүн.

7.9.Нэгдсэн хуралдаанаар асуудал хэлэлцэхэд холбогдох Байнгын хорооны дарга, эсхүл түүнийг орлож байгаа гишүүн хуралдаанд заавал оролцоно.

## **8 дугаар зүйл.Нээлттэй, хаалттай хуралдаан**

8.1.Хуульд өөрөөр заагаагүй бол хуралдааныг нээлттэй зохион байгуулна.

8.2.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.2-т заасан асуудлыг нууцын горимоор хаалттай хуралдаанаар хэлэлцэнэ.

8.3.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.3-т заасны дагуу хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуудлыг хаалттай хуралдаанаар хэлэлцэж болно.

8.4.Энэ хуулийн 8.2-т заасан хаалттай хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, тухайн асуудлыг хариуцсан Засгийн газрын гишүүн болон холбогдох төрийн бусад байгууллагын дарга, Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга /цаашид "Ерөнхий нарийн бичгийн дарга" гэх/, Тамгын газрын нууцын асуудал хариуцсан ажилтан, түүнчлэн тухайн асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүнийг оролцуулж болно.

8.5.Шаардлагатай бол энэ хуулийн 8.4-т зааснаас бусад хүнийг хаалттай хуралдаанд оролцуулж болох бөгөөд тэднээр нууц задруулахгүй байх баталгааг урьдчилан гаргуулна.

8.6.Хаалттай хуралдаанд дуу, дүрс бичлэг хийх, гар утас, бусад хөдөлгөөнт төхөөрөмж авч орох, утсаар ярихыг хориглоно.

8.7.Хаалттай хуралдааны тэмдэглэлийг төрийн болон албаны нууцын тухай хууль тогтоомжид заасны дагуу хөтөлнө.

8.8.Энэ хуулийн 8.3-т заасан хаалттай хуралдааныг зохион байгуулахад энэ хуулийн 8.4, 8.5, 8.6, 8.7-д заасан журам үл хамаарна.

8.9.Энэ хуулийн 8.3-т заасан хаалттай хуралдаанд асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсгийн бүрэлдэхүүн, Тамгын газрын ажилтнууд оролцож болох бөгөөд хуралдааны явцыг энэ хуулийн 135.1-д заасны дагуу тэмдэглэнэ.

## **9 дүгээр зүйл.Хуралдаанд асуулт асуух, үг хэлэх журам**

9.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.22, 21.23-т зааснаар хууль, тогтоолын төслийн төрөл, онцлогийг харгалзан тухайн төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх хугацааг Зөвлөл тогтоох ба нэгдсэн хуралдаанд асуулт асуух нийт хугацааг Улсын Их Хуралд авсан суудлын тооны харьцааг харгалзан тухайн нам, эвслийн бүлэгт болон нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүдэд хувь тэнцүүлэн хуваарилна.

9.2.Тухайн нам, эвслийн бүлэг хуваарилагдсан хугацаанд багтаан асуулт асуух гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 16.00 цагаас өмнө хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн байна.

9.3.Аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүн энэ зүйлийн 9.2-т заасан журмын дагуу хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан асуулт асуух эсэхээ урьдчилан мэдэгдэнэ.

9.4.Энэ хуулийн 9.1, 9.2, 9.3-т заасан журам нь энэ хуулийн Дөрөвдүгээр бүлэгт заасан хууль, тогтоолын төслийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд хамаарна.

9.5.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол гишүүн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд асуулт асуухдаа дараах журмыг баримтална:

9.5.1.гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах;

9.5.2.хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөөгүй байхад асуулт асуухгүй байх.

9.6.Гишүүний асуултад хариулах хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл удаа тус бүр 1 минутаас илүүгүй байна.

9.7.Гишүүн хуралдаанд байр сууриа илэрхийлж үг хэлэх /цаашид “үг хэлэх” гэх/-дээ дараах журмыг баримтална:

9.7.1.үг хэлэх хугацаа 4 минутаас илүүгүй байх;

9.7.2.энэ хуулийн 9.7.1-д заасан хугацаанд багтаан үг хэлж амжаагүй тохиолдолд хэлэх үгээ бичгээр илэрхийлж, хуралдааны тэмдэглэлд хавсаргах.

9.8.Тодорхой асуудлыг хэлэлцэхэд энэ хуулийн 9.5.1, 9.6, 9.7.1-д зааснаас өөр хугацаа заасан бол тусгайлан заасан хугацааг баримтална.

9.9.Хуралдаан даргалагч урьдчилан мэдэгдэж, дараалалд орсон гишүүдийн нэрсийн дагуу асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх ба асуулт асуух, үг хэлэх гишүүдийн нэрс ирцэд бүртгэгдсэн дарааллаар эрэмбэлэгдэнэ. Хуралдаан даргалагч зөвшөөрөл өгөхийн өмнө энэ зүйлд заасан журмыг баримтлахыг сануулна.

9.10.Гишүүн зөвхөн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан хуралдаанд өөрийн үзэл бодол, байр сууриа илэрхийлж үг хэлнэ.

9.11.Гишүүн асуулт асуух, үг хэлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, гүтгэхийг хориглоно.

9.12.Гишүүн үнэн, бодитой, судалгаанд суурилсан мэдээлэлд тулгуурлаж үг хэлнэ.

9.13.Гишүүн асуулт асуух, үг хэлэх эрхээ бусад гишүүнд шилжүүлэхгүй.

9.14.Хууль, тогтоолын төсөл хэлэлцэхэд гишүүний асуултад хууль санаачлагч хариулж тайлбар хийнэ.

9.15.Хууль, тогтоолын төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орсон, түүнчлэн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдон уригдаж ирсэн хүн хуралдаан даргалагчийн зөвшөөрснөөр тайлбар хийж, асуултад хариулна.

9.16.Тайлбар хийж, асуултад хариулж байгаа албан тушаалтан үнэн зөв мэдээлэл өгөх, асуултад товч, тодорхой хариулах үүрэгтэй бөгөөд гишүүн хариултыг хангалтгүй, эргэлзээтэй гэж үзвэл тухайн асуултын хариуг 2 хоногийн дотор бичгээр өгөхийг шаардах эрхтэй.

9.17.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөө, Улсын төсвийн төсөл, тэдгээрийн биелэлт, гүйцэтгэлийг чуулганы нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд болон энэ хуульд хэлэлцэх дэгийг тусгайлан зохицуулсан бусад асуудлыг хэлэлцэх үед гишүүн бүр асуулт асууж, үг хэлэх эрхтэй.

## **10 дугаар зүйл.Санал хураалт явуулах ерөнхий журам**

10.1.Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлыг ил санал хураалтаар шийдвэрлэнэ. Монгол Улсын Үндсэн хууль, энэ хууль, бусад хуульд заасан, эсхүл хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар санал хураалтыг нууцаар явуулна.

10.2.Ил санал хураалтыг цахимаар, эсхүл гар өргөж, нууц санал хураалтыг цахимаар, эсхүл санал хураах хуудсаар явуулна.

10.3.Санал хураалтыг цахимаар явуулахад биеийн давхцахгүй өгөгдөл /гарын хурууны хээ/-өөр идэвхжих цахим систем ашиглана.

10.4.Ил санал хураалтыг явуулахад техникийн гэмтэл, саатал гарсан зэрэг санал хураалтын систем ажиллахгүй болсон тохиолдолд санал хураалтыг гар өргөж явуулна.

10.5.Гар өргөж явуулсан ил санал хураалтын дүнг хуралдаан даргалагч нэгтгэн зарлана.

10.6.Нууц санал хураалтыг санал хураах хуудсаар явуулах бол гишүүдээс бүрдсэн тооллогын комисс байгуулна. Нууц санал хураалт явуулах, дүнг гаргах журмыг тооллогын комисс боловсруулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална.

10.7.Нууц санал хураалтыг цахимаар явуулахад санал өгсөн гишүүдийн нэрс хуралдааны цахим системд хадгалагдахгүй.

10.8.Гишүүн санал хураалтад оролцохдоо “зөвшөөрсөн” буюу “татгалзсан” саналын аль нэгийг өгнө.

10.9.Санал хураалт явуулах үед гишүүн санал өгөх эрхээ зөвхөн өөрөө эдлэх бөгөөд энэхүү эрхээ бусад гишүүнд шилжүүлэх, бусад гишүүний өмнөөс санал өгөхийг хориглоно.

10.10.Гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай шууд холбоотой үйл ажиллагааны үр дүнд өөрөө болон гэр бүлийн гишүүд нь орлого олж байгаа, эсхүл бусад хэлбэрээр ашиг сонирхлын зөрчилтэй бол энэ тухай хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдэж санал хураалтад оролцохгүй.

10.11.Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд ирцэд бүртгүүлсэн гишүүн чөлөө аваагүй, хүндэтгэн үзэх болон энэ хуулийн 7.5-д заасан эсэргүүцэх шалтгаантайгаа мэдэгдэлгүй хуралдааныг орхиж гарсан, эсхүл бүртгэлээс гарсан /картаа сугалсан/ бол түүнийг хуралдааны ирцэд оруулж тухайн асуудлаар санал хураахад эсрэг санал өгсөнд тооцно.

10.12.Хуралдаан даргалагч тухайн асуудлаар санал хураалт явуулах цагийг тухай бүрд нь урьдчилан зарлаж болно.

10.13.Нууц санал хураалт явуулахад энэ хуулийн 10.11 дэх хэсэг хамаарахгүй.

## **11 дүгээр зүйл.Мэтгэлцээн явуулах ерөнхий журам**

11.1.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.21-д заасны дагуу хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн үе шатанд мэтгэлцээн явуулах тохиолдолд энэ зүйлд заасан нийтлэг журмыг баримтална.

11.2.Мэтгэлцээн явуулах талаар нам, эвслийн бүлгээс ирүүлсэн санал, дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Байнгын хороо хууль, тогтоолын төслийн хэлэлцүүлгийн дараах үе шатанд мэтгэлцээн явуулна:

11.2.1.хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх үе шатанд төслийн үзэл баримтлалын хүрээнд;

11.2.2.хууль, тогтоолын төслийн анхны хэлэлцүүлгийн үе шатанд төслийн тодорхой зүйл, хэсэг, заалтын талаар энэ хуулийн 39.14-т заасны дагуу ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хүрээнд;

11.3.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 21.20-д заасны дагуу нам, эвслийн бүлгээс нэгдсэн хуралдаанаар төслийн талаар мэтгэлцээн явуулах шаардлагатай гэсэн санал, дүгнэлт гаргасан бол нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар хууль, тогтоолын төслийн хэлэлцэх эсэх үе шатанд төслийн үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцээн явуулж болно.

11.4.Энэ хуулийн 11.2, 11.3-т заасан тохиолдолд тухайн нам, эвслийн бүлгийг төлөөлж мэтгэлцээнд илтгэх гишүүнийг тухайн нам, эвслийн бүлэг томилж, нэрийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны өмнөх өдрийн 16 цагаас өмнө хуралдаан даргалагчид ирүүлсэн байна.

11.5.Илтгэгч гишүүн мэтгэлцэх шаардлага, үндэслэлээ 10 минутанд багтаан танилцуулж, нам, эвслийн бүлгийн байр суурийг илтгэнэ.

11.6.Мэтгэлцээнд гишүүд, хууль санаачлагчаас гадна тухайн салбарын эрдэмтэн, судлаачдыг байлцуулж болох ба гишүүд, хууль санаачлагч, бусад оролцогчид баримт, нотолгоонд суурилсан, үнэн, бодитой мэдээлэлд тулгуурлаж асуулт асууж, хариулт өгч оролцоно.

11.7.Хуралдаан даргалагч мэтгэлцээний үргэлжлэх хугацааг тухайн хэлэлцэж байгаа хууль, тогтоолын төслийн цар хүрээнээс хамаарч 2 цагаас илүүгүй байхаар тогтоох бөгөөд гишүүдэд саналаа чөлөөтэй илэрхийлэх, хууль санаачлагч болон илтгэгч гишүүнээс асуулт асуух боломж олгоно. Шаардлагатай тохиолдолд хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар мэтгэлцээнийг 1 хүртэлх цагаар сунгаж болно. Мэтгэлцээн дуусмагц хуралдаан ердийн дэгээр үргэлжилнэ.

## **12 дугаар зүйл.Хуралдаанаас завсарлага авах**

12.1.Энэ хуульд өөрөөр заагаагүй бол нам, эвслийн бүлэг Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 30.1.5-д заасны дагуу завсарлага авах эрхтэй. Завсарлага авах хугацаа ажлын таваас илүүгүй өдөр байх бөгөөд шаардлагатай бол нам, эвслийн бүлгийн хүсэлтээр хуралдаан даргалагч завсарлагын хугацааг 1 удаа ажлын 3-аас илүүгүй өдрөөр сунгаж болно.

12.2.Нам, эвслийн бүлгийн дарга, түүний эзгүйд дэд дарга энэ хуулийн 12.1-д заасны дагуу завсарлага авахдаа үндэслэл, хугацааг тодорхой хэлж, энэ талаар хуралдааны тэмдэглэлд тусгуулна.

12.3.Завсарлага авсан нам, эвслийн бүлэг тухайн асуудлаар дахин завсарлага авахыг хориглоно.

12.4.Шийдвэрлэх хугацааг нь хуулиар тусгайлан заасан асуудлаар нам, эвслийн бүлэг завсарлага авах бол хуралдаан даргалагч завсарлагын хугацааг тухайн асуудлыг хуулиар тогтоосон хугацаанд шийдвэрлэх боломжтой байхаар тогтооно.

12.5.Завсарлага авсан хугацаанд тухайн асуудлыг хуралдаанаар хэлэлцэхгүй.

12.6.Завсарлага авсан нам, эвслийн бүлэг завсарлагын хугацааг уг хугацаанаас өмнө дуусгавар болгож тухайн асуудлыг хэлэлцүүлэх санал гаргаж болно.

### **13 дугаар зүйл.Хуралдаан даргалагчийн эрх, үүрэг**

13.1.Хуралдааныг зохион байгуулах талаар хуралдаан даргалагч дараах эрх, үүргийг хэрэгжүүлнэ:

13.1.1.хуралдааны бэлтгэлийг хангах;

13.1.2.хуралдааныг товлосон цагт эхлүүлж, дэгийн дагуу зохион байгуулах;

13.1.3.саналаа ирүүлсэн дарааллыг баримтлан гишүүдэд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх;

13.1.4.нам, эвслийг бүлэг, гишүүдээс гаргасан горимын саналаар санал хураалт явуулах;

13.1.5.энэ хуулийн 9.16-д заасан этгээдэд гишүүдийн асуултад хариулах, тайлбар хийх зөвшөөрөл өгөх;

13.1.6.санал хураалт явуулж, дүнг мэдээлэх;

13.1.7.хуралдааны шийдвэрийг хэлбэржүүлэх, ёсчлох ажлыг зохион байгуулах;

13.1.8.хүндэтгэн үзэх шалтгаантай гишүүнд чөлөө өгөх;

13.1.9.илтгэл, танилцуулга сонсох, асуулт, хариулт явуулах, санал, дүгнэлт танилцуулах, санал хураах цагийг тогтоох;

13.1.10.хуралдааны дэгийн биелэлтэд хяналт тавьж, гишүүдээс түүнийг биелүүлэхийг шаардах;

13.1.11.энэ хуулийн 7.6-д заасны дагуу гишүүнд хуралдааны танхимаас түр гарах зөвшөөрөл олгох;

13.1.12.хуралдааны дэг зөрчигчид энэ хуульд заасан арга хэмжээ авах;  
13.1.13.хууль тогтоомжид заасан бусад эрх, үүрэг.

13.2.Хуралдаан даргалагч горимын саналаар нэг удаа санал хураалт явуулна. Хуралдааны хэлэлцэх асуудалд ороогүй асуудлаар, мөн тухайн санал нь хуулиар тогтоосон журмыг зөрчиж байгаа бол санал хураалт явуулахыг хориглоно.

13.3.Хуралдаанаар нэг асуудлыг хэлэлцэж эхэлсэн боловч түүний хэлэлцүүлгийг горимын саналаар хойшлуулсан тохиолдолд хуралдаан даргалагч дараагийн асуудлыг хэлэлцүүлнэ.

#### **14 дүгээр зүйл.Хуралдааны дэг сахиулах**

14.1.Хуралдаан даргалагч энэ хуульд заасан хуралдааны дэгийг сахиулна.

14.2.Гишүүн хуралдааны дэг зөрчсөн, хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол хуралдаан даргалагч түүнээс уг үйлдлээ зогсоохыг шаардах эрхтэй.

14.3.Энэ хуулийн 14.2-т заасан шаардлагыг гишүүн биелүүлээгүй бол хуралдаан даргалагч түүнд энэ хуульд заасан хариуцлага хүлээлгэнэ.

14.4.Хуралдаанд оролцогч, Улсын Их Хурлын үйл ажиллагаатай урилгаар танилцаж байгаа зочид, төлөөлөгчид хуралдааны дэгийг сахин мөрдөх үүрэгтэй бөгөөд хуралдааны дэгийг зөрчсөн бол түүнийг хуралдаан даргалагчийн шийдвэрээр танхимаас гаргана.

14.5.Хуралдаан даргалагч хуралдааны танхимд хуралдааны дэг, журмыг сахиулах боломжгүй гэж үзсэн тохиолдолд тухайн өдрийн хуралдааныг түр завсарлуулах, эсхүл тухайн асуудлын хэлэлцүүлгийг хойшлуулах шийдвэр гаргана.

#### **15 дугаар зүйл.Хуралдааны дэг зөрчсөн гишүүнд хүлээлгэх хариуцлага**

15.1.Гишүүн хуралдааны дэг зөрчсөн бол дараах хариуцлага хүлээлгэнэ:

15.1.1.сануулах;

15.1.2.хуралдаанд үг хэлэх эрхийг хасах;

15.1.3.хуралдааныг орхин гарахыг үүрэг болгох;

15.1.4.хуралдаанд оролцох эрхийг хасах.

15.2.Гишүүн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй асуулт асуух, үг хэлэх, зөвшөөрөл өгөөгүй байхад үг хэлсэн бол хуралдаан даргалагч түүний үгийг тасалж, эхний удаа сануулж, дараагийн авах арга хэмжээний талаар анхааруулна.

15.3.Гишүүн эхний удаа өгсөн сануулгыг биелүүлээгүй бол хуралдаан даргалагч гишүүний үг хэлэх эрхийг хасаж, тухайн асуудлын хэлэлцүүлгийн явцад дахин үг хэлэх эрх олгохгүй.

15.4.Гишүүн бусдад саад учруулсан, асуулт асуух, үг хэлэхдээ бүдүүлэг үг хэллэг хэрэглэх, бусдыг доромжлох, нэр төрийг нь гутаах, гүтгэсэн шинжтэй үг хэлсэн бол хуралдаан даргалагч түүнд урьдчилан сануулахгүйгээр тухайн өдрийн хуралдаанд үг хэлэх эрхийг хасна.

15.5.Гишүүн хуралдаан даргалагчийн хуралдааны дэг сахихыг сануулсан шаардлагыг үл биелүүлж, бусад гишүүний асуулт асуух, үг хэлэх, саналаа өгөх эрхэд саад учруулах зэргээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулахуйц нөхцөл байдал үүсгэсэн бол түүнийг тухайн асуудлыг хэлэлцэж дуустал хуралдаанаас гаргана.

15.6.Энэ хуулийн 15.5-д заасан хариуцлага хүлээсэн гишүүн хуралдааныг нэн даруй орхин гарах үүрэгтэй бөгөөд гишүүн хуралдааны танхимыг ийнхүү орхин гараагүй нь тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхийг хасах хариуцлага оногдуулах үндэслэл болно.

15.7.Энэ хуулийн 15.6-д заасны дагуу тухайн өдрийн хуралдаанд оролцох эрхээ хасуулсан гишүүн Улсын Их Хурлын болон гишүүний нэр хүндийг гутаан доромжилсон, эмх замбараагүй байдал үүсгэсэн болон бусад хэлбэрээр хуралдааны хэвийн үйл ажиллагааг алдагдуулсан бол хуралдаан даргалагч тухайн зөрчилтэй нь холбогдуулан уг гишүүний хуралдаанд оролцох эрхийг 3 хүртэл удаа хасаж болно.

15.8.Зөрчил гаргасан гишүүнд хүлээлгэсэн хариуцлага нь нэгдсэн болон тухайн Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаанд хамаарна.

15.9.Гишүүн энэ хуулийн 15.1.4-т заасны дагуу хуралдаанд оролцох эрхээ хасуулсан тохиолдолд ирцийн бүртгэлээс хасна.

15.10.Гишүүн энэ хуулийн 15.1-д заасан зөрчлийг удаа дараа давтан гаргасан бол тухайн асуудлыг Ёс зүй, дэгийн байнгын хороо авч хэлэлцэн санал, дүгнэлт гаргана.

## **16 дугаар зүйл.Хуралдааны дэгээр зохицуулаагүй асуудлыг хэлэлцэх журам**

16.1.Тухайн асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг энэ хуулиар зохицуулаагүй бол уг асуудлыг хэлэлцэх дэгийг Ёс зүй, дэгийн байнгын хороо хэлэлцэж, саналаа нэгдсэн хуралдаанд оруулна.

16.2.Ёс зүй, дэгийн байнгын хорооноос санал болгосон тухайн асуудлыг хэлэлцэх хуралдааны дэгийг нэгдсэн хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын гишүүд /цаашид "гишүүд" гэх/-ийн олонхын саналаар батална.

16.3.Энэ хуулийн 16.1-д заасан хуралдааны дэгийг нэг удаа зөвхөн тухайн асуудлыг хэлэлцэн шийдвэрлэхэд мөрдөнө.

## **17 дугаар зүйл. Цахим хуралдааны дэг**

17.1.Онц байдал, дайн бүхий болон дайны байдал зарласан, Гамшгаас хамгаалах тухай хуульд<sup>4</sup> заасан гамшгийн онцгой нөхцөл байдалд Улсын Их Хурлын

<sup>4</sup> Гамшгаас хамгаалах тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2017 оны 7 дугаарт



хэвийн үйл ажиллагааг хангахын тулд Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн, энэ хуульд заасан зарчмыг баримтлан асуудлыг цахим хуралдааны дэгээр хэлэлцэж болно.

17.2.Чуулганы хуралдаан /цаашид “хуралдаан” гэх/-ыг энэ хуулийн 17.1-д заасны дагуу зохион байгуулах тохиолдолд хуралдааны цахим систем ашиглах бөгөөд Улсын Их Хурлын гишүүд, ажлын хэсгийн гишүүд байршлаасаа үл хамааран дүрсээ харан нэгэн зэрэг сонсох болон ярих, санал өгөх боломжтой байна.

17.3.Хуралдааны зарыг албан ёсны цахим шуудан болон харилцаа холбооны хэрэгсэл ашиглан Улсын Их Хурлын гишүүн /цаашид “гишүүн” гэх/-д мэдэгдэнэ.

17.4.Гишүүн товлосон цагт цахим хуралдааны программын ирцэд бүртгүүлэн хуралдаанд оролцох үүрэгтэй. Гишүүн хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр товлосон цагт ирцэд бүртгүүлээгүй бол энэ хуулийн 15.1-д заасан хариуцлага хүлээлгэнэ.

17.5.Хэлэлцэх асуудлын материалыг ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө албан ёсны цахим шуудангаар илгээж, Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулна.

17.6.Хуралдаанд Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.3-т заасан Зөвлөлийн гишүүд биечлэн хуралдааны танхимд, бусад гишүүд хуралдааны танхим, эсхүл албан өрөөнөөсөө, хүндэтгэн үзэх шалтгааны улмаас хуралдаан даргалагчид урьдчилан мэдэгдсэн бол тухайн байгаа газраасаа цахим хуралдааныг хэвийн явуулахад саад учруулахгүйгээр оролцоно.

17.7.Хуралдаанд тухайн хэлэлцэж байгаа асуудлыг боловсруулахад оролцсон ажлын хэсэг, Улсын Их Хурлын Тамгын газар /цаашид “Тамгын газар” гэх/-ын холбогдох ажилтан оролцож болно.

17.8.Тухайн өдрийн хуралдаан эхлэхэд цахим хуралдааны программд бүртгүүлсэн гишүүнийг хуралдаанд хүрэлцэн ирснээр тооцож, хуралдааны ирцэд бүртгэнэ.

17.9.Хуралдааны үед нам, эвслийн бүлэг тухайн хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан завсарлага авахаар бол хуралдаан даргалагч тухайн үеийн нөхцөл байдалтай ялдуулан завсарлагын хугацааг тогтооно.

17.10.Гишүүн хуралдаанд үг хэлж, байр сууриа илэрхийлэх, тайлбар хийх, асуулт асуухдаа цахим хуралдааны программын мэдээлэл солилцох хэсэгт бичвэр томъёолоор мэдэгдэн дараалалд орж хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр чанга яригч нээгдэхэд үг хэлж, асуулт асууна.

17.11.Цахим хуралдааны дэгээр хуралдаж байгаа үед асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй, хариулт, тайлбар хангалтгүй гэж үзвэл тухайн гишүүний саналаар нэг удаа 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах бөгөөд үг хэлэх хугацаа 3 минутаас илүүгүй байхаар тогтооно. Нам, эвслийн бүлэг, гишүүд шаардлагатай гэж үзвэл саналаа нэгтгэн асуулт асууж, саналаа илэрхийлж болно.

17.12.Хуралдаанаар хэлэлцэж байгаа асуудлаар ил санал хураалт явуулах бөгөөд хуралдаан даргалагч санал хураалтын цагийг урьдчилан мэдэгдэнэ.

---

нийтлэгдсэн.

17.13.Санал хураалтыг цахим хэлбэрээр, эсхүл гар өргөж явуулна. Санал хураалтын дүнг хуралдаан даргалагч нэгтгэн танилцуулна.

17.14.Нууц санал хураалтыг тусгай нууцлал бүхий программ, эсхүл санал хураах хуудсаар явуулна.

17.15.Энэ хуулийн 17.1-д заасан нөхцөлд хаалттай хуралдаан явуулах дэгийг тусгайлан зохицуулна.

17.16.Хуралдааны дэг зөрчсөн болон цахим хуралдааны программын мэдээлэл солилцох хэсэгт хэлэлцэж байгаа асуудалтай холбогдолгүй үг бичих, цахим хуралдааныг хэвийн явуулахад саад учруулсан үйлдэл гаргавал гишүүнд хуралдаан даргалагч сануулах, сануулга авсан гишүүн дахин зөрчил гаргавал түүний тухайн өдрийн хуралдааны туршид, эсхүл тухайн хэлэлцэж байгаа асуудлаар асуулт асуух, үг хэлэх эрхийг нь хасах, цахим хуралдааны программын мэдээлэл солилцох хэсэгт бичих, үг хэлэх эрхийг нь 3 цаг хүртэл хугацаагаар хасаж, энэ тухайгаа мэдэгдэнэ.

17.17.Хуралдааны явцыг дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан энэ хуульд заасны дагуу Тамгын газраас баримтжуулна.

17.18.Энэ хуульд заасны дагуу ирц, санал хураалтад оролцсон Улсын Их Хурлын гишүүний саналаа илэрхийлсэн талаарх баримтыг тухайн асуудлыг хэлэлцсэн хувийн хэрэгт хавсаргана.

## **ГУРАВДУГААР БҮЛЭГ АНХДУГААР ЧУУЛГАН**

### **18 дугаар зүйл.Улсын Их Хурлын анхдугаар чуулган**

18.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 16.1-д заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгчийн товлосон өдөр анхдугаар чуулганы үйл ажиллагаа эхэлнэ.

18.2.Анхдугаар чуулганыг нээж Монгол Улсын Ерөнхийлөгч үг хэлнэ.

18.3.Анхдугаар чуулганы хуралдааныг Улсын Их Хурлын даргыг сонгох хүртэл тухайн сонгуулиар сонгогдсон насаар хамгийн ахмад гишүүн даргална. Насаар хамгийн ахмад гишүүн даргалах боломжгүй бол хуралдаанд оролцсон насаар ахмад дараагийн гишүүн даргална.

18.4.Сонгуулийн ерөнхий хорооны дарга Улсын Их Хурлын ээлжит сонгуулийн дүн, сонгогдсон гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай илтгэл тавина.

18.5.Сонгуулийн ерөнхий хорооны дарга илтгэл тавьсны дараа насаар хамгийн ахмад гишүүн эхэлж, бусад гишүүн цагаан толгойн үсгийн дарааллын дагуу Улсын Их Хурлын гишүүний тангаргийг уншиж, Төрийн сүлдэнд мэхийн ёсолж, төрийн далбаанаас адис авч, тангаргийн бичигт гарын үсэг зурна.

18.6.Гишүүн тангараг өргөснөөр Улсын Их Хурлын гишүүдийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай тогтоол баталсанд тооцно.

18.7.Анхдугаар чуулганы хуралдааныг Улсын Их Хурлын даргыг сонгох хүртэл тухайн сонгуулиар сонгогдсон насаар хамгийн ахмад гишүүн даргална. Насаар хамгийн ахмад гишүүн даргалах боломжгүй бол хуралдаанд оролцсон насаар ахмад дараагийн гишүүн даргална.

18.8.Анхдугаар чуулганы нээлтийн хуралдаанд оролцож амжаагүй гишүүн өөрийн оролцсон анхны хуралдаанд тангараг өргөнө. Тангараг өргөхтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлэхгүй.

18.9.Нөхөн сонгогдсон гишүүний бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөхөд энэ хуулийн 18.4, 18.5, 18.6-д заасан журмыг баримтална.

### **19 дүгээр зүйл.Улсын Их Хурлын даргыг сонгох**

19.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10.1-д заасан нам, эвсэл Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ.

19.2.Аль ч нам, эвсэл олонхын суудал аваагүй бол Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 10.2-т заасан нам, эвсэл зөвшилцөн Улсын Их Хурлын даргад нэр дэвшүүлнэ.

19.3.Улсын Их Хурлын даргыг сонгоход хэлэлцүүлэг явуулахгүй бөгөөд ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.

19.4.Нэр дэвшигч хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг аваагүй бол энэ хуулийн 19.1, 19.2-т заасны дагуу өөр гишүүний нэрийг дэвшүүлж сонгоно.

### **20 дугаар зүйл.Улсын Их Хуралд нам, эвслийн бүлэг байгуулагдсан тухай мэдээлэх**

20.1.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 29.1-д заасан суудал авсан нам, эвслийн гишүүд бүлэг байгуулсан тухай шийдвэр, бүлгийн гишүүдийн нэрсийн жагсаалтыг бүлгийн дарга Улсын Их Хурлын даргад бичгээр ирүүлэх бөгөөд ийнхүү ирүүлснээр бүлэг байгуулсанд тооцно.

20.2.Улсын Их Хурлын дарга нам, эвслийн бүлэг байгуулсан тухай шийдвэр, түүний бүрэлдэхүүнд орсон гишүүдийн нэрсийг нэгдсэн хуралдаанд уншиж танилцуулна.

### **21 дүгээр зүйл.Улсын Их Хурлын дэд даргыг сонгох**

21.1.Улсын Их Хурлын дэд даргыг тухайн Улсын Их Хурлын сонгуулийн дүнд бий болсон нам, эвслийн бүлэг тус бүрээс нэр дэвшүүлэн, ил санал хураалтаар сонгоно.

21.2.Улсын Их Хурлын дэд даргыг сонгоход хэлэлцүүлэг явуулахгүй бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Улсын Их Хурлын дэд даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.

21.3.Нэр дэвшигч хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг аваагүй бол энэ хуулийн 21.1-д заасны дагуу өөр гишүүний нэрийг дэвшүүлж сонгоно.

## **22 дугаар зүйл.Байнгын болон дэд хороо байгуулах журам**

22.1.Байнгын хорооны бүрэлдэхүүнийг дараах журмаар батална:

22.1.1.гишүүн Байнгын хороонд харьяалагдах саналаа нам, эвслийн бүлэгт, бүлэгт харьяалагдаагүй гишүүн саналаа Улсын Их Хурлын даргад хүргүүлэх;

22.1.2.нам, эвслийн бүлэг Байнгын хорооны тоо, олонх, цөөнхийн харьцаа зэргийг харгалзан гишүүнийг Байнгын хороонд хуваарилах саналаа Улсын Их Хурлын даргад хүргүүлэх;

22.1.3.Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 22.1.1, 22.1.2-т заасны дагуу ирүүлсэн саналыг нэгтгэн, нам, эвслийн бүлэгтэй зөвшилцөж, Байнгын хорооны бүрэлдэхүүний талаарх саналаа нэгдсэн хуралдаанд танилцуулах;

22.1.4.нэгдсэн хуралдаан энэ хуулийн 22.1.3-т заасан саналыг үндэслэн Байнгын хорооны бүрэлдэхүүнийг тогтоолоор батлах.

22.2.Гишүүн Байнгын хорооны харьяаллаа өөрчлөх хүсэлт гаргавал энэ хуулийн 22.1-д заасан журмын дагуу шийдвэрлэнэ.

22.3.Дэд хорооны бүрэлдэхүүний тухай асуудлыг харьяалах Байнгын хорооны хуралдаанаар урьдчилан хэлэлцэх бөгөөд нэгдсэн хуралдаан Байнгын хорооны гаргасан санал, дүгнэлтийг үндэслэн дэд хорооны бүрэлдэхүүний тухай тогтоол батална.

22.4.Дэд хорооны бүрэлдэхүүнд орсон гишүүн харьяалах Байнгын хорооны бүрэлдэхүүнээс гарвал тухайн дэд хорооны бүрэлдэхүүнээс чөлөөлөх тогтоол баталсанд тооцно.

22.5.Энэ хуулийн 22.3, 22.4-т заасан тогтоолын төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж, нэгдсэн хуралдаанд оруулна.

## **23 дугаар зүйл.Байнгын болон дэд хорооны даргыг сонгох журам**

23.1.Байнгын хорооны даргад Байнгын хорооны гишүүдийн дотроос олонхын саналаар нэр дэвшүүлнэ.

23.2.Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг үндэслэн ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нэр дэвшигчийг дэмжсэн бол Байнгын хорооны даргыг сонгох тухай тогтоол баталсанд тооцно.

23.3.Нэр дэвшигчийг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол өөр гишүүнийг энэ хуулийн 23.1-д заасны дагуу нэр дэвшүүлж, энэ хуулийн 23.2-т заасны дагуу сонгоно.

23.4.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

23.5.Дэд хорооны даргыг Дэд хорооны гишүүдийн дотроос нэр дэвшүүлж, Байнгын хорооны гишүүдийн олонхын саналаар сонгоно.

## **24 дүгээр зүйл.Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцэх**

24.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох саналыг Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд оруулснаас хойш Төрийн байгуулалтын байнгын хороо ажлын 3 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

24.2.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

24.3.Нэгдсэн хуралдаан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Ерөнхий сайдыг томилох асуудлаар ил санал хураалт явуулна. Нэр дэвшигчийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Ерөнхий сайдыг томилох тухай тогтоол баталсанд тооцно.

24.4.Нэр дэвшүүлсэн хүнийг Ерөнхий сайдаар томилох Монгол Улсын Ерөнхийлөгчийн саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу дахин нэр дэвшүүлсэн хүнийг Монгол Улсын Ерөнхийлөгч 5 хоногийн дотор Улсын Их Хуралд оруулж, энэ хуулийн 24.1, 24.2, 24.3-т заасан журмаар шийдвэрлэнэ.

#### **25 дугаар зүйл.Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг хэлэлцэн батлах**

25.1.Ерөнхий сайд томилогдсоноосоо хойш ажлын 14 өдрийн дотор Засгийн газрын бүтцийн тухай болон Засгийн газрын бүрэлдэхүүний тухай хуулийн төслийг Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин есдүгээр зүйлийн 3 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

25.2.Улсын Их Хурал энэ хуулийн 25.1-д заасны дагуу өргөн мэдүүлсэн хуулийн төслийг энэ хуульд заасан хуулийн төсөл хэлэлцэх журмын дагуу хэлэлцэж батална.

#### **26 дугаар зүйл.Засгийн газрын гишүүнийг томилох тухай Ерөнхий сайдын танилцуулгыг сонсох**

26.1.Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнээр томилох асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах тухайгаа Улсын Их Хурлын даргад мэдэгдэж товыг тогтоолгоно.

26.2.Засгийн газрын гишүүнээр томилох асуудлыг нэгдсэн хуралдаанд хүн нэг бүрээр танилцуулах бөгөөд гишүүд тухайн асуудлаар Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс асуулт асууж, үг хэлж болно.

26.3.Гишүүд үг хэлж дууссанаар Засгийн газрын гишүүнийг Улсын Их Хуралд танилцуулсанд тооцох бөгөөд Улсын Их Хурлаас аливаа шийдвэр гаргахгүй.

#### **27 дугаар зүйл.Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх**

27.1.Засгийн газрын гишүүн томилогдсоноос хойш ажлын 3 өдрийн дотор Улсын Их Хуралд тангараг өргөнө.

27.2.Засгийн газрын гишүүний тангаргийг Монгол Улсын Засгийн газрын тухай хуулиар<sup>5</sup> тогтооно.

27.3.Засгийн газрын гишүүн Улсын Их Хуралд тангараг өргөх журмыг Улсын Их Хурал батална.

## **28 дугаар зүйл. Чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох**

28.1.Ёс зүй, дэгийн байнгын хороо хуралдааны дэгийг шинэчлэн батлах эсэх асуудлыг анхдугаар чуулганы хугацаанд хэлэлцэж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулна. Чуулганы хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох асуудлаар Ерөнхий нарийн бичгийн дарга саналаа гаргаж, Ёс зүй, дэгийн байнгын хороонд хүргүүлж болно.

28.2.Нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн бол өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд мөрдөж байсан хуралдааны дэгийг тухайн сонгуулийн дүнд байгуулагдсан Улсын Их Хурлын хуралдааны дэг гэж хүлээн зөвшөөрсөнд тооцно.

28.3.Нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуралдааны дэгийг шинэчлэн тогтоох нь зүйтэй гэж үзсэн бол Улсын Их Хурлын дарга хуралдааны дэгд өөрчлөлт оруулах хуулийн төсөл боловсруулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хуралд суудал бүхий нам, эвсэл болон бие даан нэр дэвшиж сонгогдсон гишүүдийн төлөөллийн бүрэлдэхүүнтэйгээр байгуулна.

28.4.Энэ хуулийн 28.3-т заасан ажлын хэсэг хуулийн төслийг Улсын Их Хурлаас тогтоосон хугацаанд төрийн ажлын уламжлал, ёс дэг, залгамж чанар, шуурхай байх зарчмыг харгалзан боловсруулах ба уг төслийг Улсын Их Хурал хэлэлцэн шийдвэрлэнэ.

## **ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ХУУЛИЙН ТӨСӨЛ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ**

### **29 дүгээр зүйл.Өргөн мэдүүлсэн төслийн талаар мэдээлэх**

29.1.Улсын Их Хурлын дарга хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх Байнгын хороог, хэрэв тухайн төсөл хэд хэдэн Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хамаарахаар бол Зөвлөлтэй зөвшилцөн холбогдох болон бусад Байнгын хороог тогтоож, нэгдсэн хуралдаанд мэдээлнэ.

### **30 дугаар зүйл.Хуулийн төслийг хэлэлцэн батлах үе шат**

30.1.Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн хуулийн төслийг дараах дөрвөн үе шаттайгаар хэлэлцэн батална:

#### **30.1.1.төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг;**

---

<sup>5</sup> Монгол Улсын Засгийн газрын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1993 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

- 30.1.2.төслийн анхны хэлэлцүүлэг;
- 30.1.3.төслийн эцсийн хэлэлцүүлэг;
- 30.1.4.төслийг эцэслэн батлах.

30.2.Энэ хуулийн 33.1-д заасан яаралтай хэлэлцүүлэх болон хуульд батлах хугацааг нь тусгайлан зааснаас бусад хуулийн төслийн хэлэлцүүлэг хоорондын хугацаа ажлын 5-аас доошгүй хоног байна.

### **31 дүгээр зүйл.Хууль санаачлагч хуулийн төслөө танилцуулах, түүнийг төлөөлөх**

31.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг Монгол Улсын Ерөнхийлөгч өөрөө, эсхүл түүний томилсноор Тамгын газрын дарга, эсхүл зөвлөх нь хийнэ.

31.2.Засгийн газраас санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг Ерөнхий сайд, эсхүл тухайн асуудлыг эрхэлсэн Засгийн газрын гишүүн, тухайн Засгийн газрын гишүүн түр эзгүй байгаа бол түүнийг орлож байгаа Засгийн газрын гишүүн хийнэ.

31.3.Энэ хуулийн 31.1, 31.2-т заасны дагуу танилцуулгыг хийх албан тушаалтныг өөрчлөх бол өмнөх өдрийн 17.30 цагаас өмнө урьдчилж мэдэгдэнэ.

31.4.Гишүүний санаачилсан хуулийн төслийн танилцуулгыг гишүүн өөрөө, хэд хэдэн гишүүн хамтран санаачилсан бол тэдгээрийг төлөөлөх гишүүн хийнэ.

31.5.Энэ хуулийн 31.1, 31.2, 31.3-т заасан этгээд төслийн хэлэлцүүлгийн бүх үе шатанд оролцох үүрэгтэй ба хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр хуралдаанд оролцоогүй бол тухайн асуудлын хэлэлцүүлгийг дараагийн хуралдаан хүртэл хойшлуулна.

31.6.Энэ хуулийн 31.1, 31.2-т заасан этгээд төслөө танилцуулах, үндэслэлээ тайлбарлахдаа төслийг боловсруулахад оролцсон холбогдох мэргэжилтэн, шинжээчдийг төслийн хэлэлцүүлгийн бүх үе шатанд байлцуулна.

### **32 дугаар зүйл.Хууль санаачлагч төслөө татан авах, хуулийн төслийг буцаах журам**

32.1.Хууль санаачлагч хэлэлцүүлгийн аль ч шатанд санаачилсан хуулийн төслөө татан авч болно.

32.2.Хэд хэдэн гишүүн хамтарч төсөл санаачилсан бол олонхын саналаар төслөө татан авна.

32.3.Энэ хуулийн 32.1, 32.2-т заасны дагуу хуулийн төслөө татан авах тохиолдолд тухайн төсөл нь хэлэлцүүлгийн аль шатанд байгаагаас үл хамааран хууль санаачлагч хуулийн төслөө татан авах тухай албан бичгийг Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанд энэ тухай танилцуулснаар хууль санаачлагч хуулийн төслөө татан авсанд тооцно.

32.4.Өмнөх Улсын Их Хурлын бүрэн эрхийн хугацаанд хэлэлцэж батлаагүй хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаасанд тооцно.

32.5.Засгийн газар хуульд батлах хугацааг нь тусгайлан зааснаас бусад хуулийн төслийг анхны ээлжит чуулганаар хэлэлцүүлэх саналаа Улсын Их Хурлын анхны ээлжит чуулган эхлэхээс ажлын 10-аас доошгүй өдрийн өмнө Улсын Их Хуралд ирүүлнэ.

### **33 дугаар зүйл.Улсын Их Хурлын чуулганаар хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэх**

33.1.Засгийн газрын хуралдааны шийдвэрийг үндэслэн Ерөнхий сайд үндэсний эдийн засгийн аюулгүй байдлыг хангахтай холбогдуулан хуулийн төслийг яаралтай хэлэлцүүлэхээр Улсын Их Хуралд бичгээр хүсэлт тавьсан бол Улсын Их Хурлын дарга төслийг чуулганаар яаралтай хэлэлцэх эсэхийг нэгдсэн хуралдаанд оруулж шийдвэрлүүлнэ.

33.2.Нэгдсэн хуралдаан хуулийн төслийг яаралтай хэлэлцэхээр шийдвэрлэсэн тохиолдолд Улсын Их Хурлын дарга тухайн хуулийн төслийг холбогдох Байнгын хороо Улсын Их Хурлын нийт гишүүнд яаралтай хүргүүлж, энэ хуулийн 30 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцүүлнэ.

### **34 дүгээр зүйл.Хууль зүйн дүгнэлт гаргах болон зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн дүн шинжилгээ хийх**

34.1.Тамгын газар энэ хуулийн 33 дугаар зүйлд зааснаас бусад хуулийн анхдагч болон шинэчилсэн найруулгын төсөл болон хамт өргөн мэдүүлсэн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг явуулахын өмнө дараах асуудлаар хууль зүйн дүн шинжилгээ хийж дүгнэлт /цаашид “хууль зүйн дүгнэлт” гэх/ гаргана:

34.1.1.тухайн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ болон бусад хуульд нийцсэн эсэх. Хэрэв тухайн төсөл Монгол Улсын Үндсэн хууль болон бусад хуульд нийцээгүй гэж хууль зүйн дүгнэлт гаргасан бол ямар хуулийн аль заалтад нийцэхгүй байгааг, түүнчлэн тэдгээрийн үндэслэлийг тайлбарлах;

34.1.2.тухайн төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт нь хоорондоо зөрчилдсөн эсэх. Хэрэв зөрчилтэй бол түүнийг тодорхойлж, залруулах аргыг санал болгох;

34.1.3.хүчингүй болгох, нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төсөлд шаардлагатай бүх хууль, зүйл, хэсэг, заалтыг хамааруулсан эсэх. Хэрэв бүрэн биш бол орхигдсон хууль, зүйл, хэсэг, заалтыг заах;

34.1.4.тухайн төсөл, эсхүл түүний зарим зүйл, хэсэг, заалтын зохицуулалтын хэрэгжих боломж, харилцан уялдаа зэргийг тооцож шинжилгээ хийх;

34.1.5.хамт өргөн мэдүүлсэн төсөл нь тухайн өргөн мэдүүлсэн хуулийн төслийн зохицуулалттай уялдсан эсэх;

34.1.6.нэмэлт, өөрчлөлт оруулж байгаа төсөл нь тухайн хуулийн зохицуулалтын зорилго, үндсэн зарчимтай нийцсэн эсэх.

34.2.Тамгын газрын Хуулийн асуудал хариуцсан нэгж энэ хуулийн 34.1-д заасан хууль зүйн дүгнэлтийг ажлын 10-15 өдрийн дотор гаргана.



34.3.Хууль зүйн дүгнэлтийг энэ хуулийн 34.2-т заасан хугацаанд гаргах боломжгүй бол Ерөнхий нарийн бичгийн дарга хугацааг сунгаж болно.

34.4.Хууль зүйн дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанд хуулийн асуудал хариуцсан нэгжээс танилцуулж, тайлбар хийнэ.

34.5.Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл төслийн тодорхой зүйл, хэсэг, заалт, гишүүний гаргасан саналын томъёоллын хүрээнд анхны болон эцсийн хэлэлцүүлэг явуулахын өмнө хууль зүйн дүгнэлт гаргуулж болно.

34.6.Тамгын газар хуулийн төслийг хэлэлцэх эсэх үе шатанд холбогдох Байнгын хорооны хүсэлтээр тэдгээрийг хэрэгжүүлэхтэй холбогдон гарах зардлын тооцоо, улсын төсөвт үзүүлэх нөлөөллийн асуудлаар дүн шинжилгээ /цаашид “төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ” гэх/ хийж болно.

34.7.Тамгын газрын Төсвийн хяналт, шинжилгээ хариуцсан нэгж энэ хуулийн 34.6-д заасан төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг ажлын 10-15 өдрийн дотор гаргана.

34.8.Төсвийн нөлөөллийн дүн шинжилгээг Байнгын хорооны хуралдаанд Төсвийн хяналт, шинжилгээний нэгжээс танилцуулж, тайлбар хийнэ.

34.9.Хууль зүйн дүгнэлт гаргах болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээ хийх журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

### **35 дугаар зүйл.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах**

35.1.Хууль санаачлагчийн өргөн мэдүүлсэн хуулийн төслийг Улсын Их Хурлын дарга холбогдох Байнгын хороонд хуваарилах бөгөөд уг Байнгын хороо төслийг хэлэлцүүлэх бэлтгэл хангах, санал, дүгнэлт гаргах, нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх бэлтгэл ажлыг хариуцна.

35.2.Энэ хуулийн 35.1-д заасны дагуу хуулийн төсөл, түүнд хавсаргасан баримт бичгийг холбогдох Байнгын хороонд хуваарилснаас хойш 3 хоногийн дотор Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлэх ба эдгээр нь олон нийтэд нээлттэй байна.

35.3.Байнгын хороо анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахын өмнө тухайн хуулийн төсөлтэй 7-оос доошгүй хоногийн хугацаанд танилцах боломжийг гишүүдэд олгоно.

35.4.Энэ хуулийн 34.1, 34.6-д заасны дагуу Тамгын газраас төсөлд хийсэн хууль зүйн дүгнэлт болон төсвийн нөлөөллийн шинжилгээг Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлсэн байна.

35.5.Нам, эвслийн бүлэг хуулийн төслийг урьдчилан хэлэлцэж чуулганаар хэлэлцэх эсэх тухай санал, дүгнэлт гаргасан бол уг санал дүгнэлтийг нам, эвслийн бүлгийн дарга, эсхүл түүнийг орлож байгаа гишүүн Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

35.6.Хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал

сонсох бөгөөд саналыг энэ хуулийн 31.2-т заасан Засгийн газрын гишүүн танилцуулна.

35.7.Нам, эвслийн бүлэг энэ хуулийн 11 дүгээр зүйлд заасны дагуу хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд мэтгэлцээн явуулах горимын санал гаргасан тохиолдолд хэлэлцүүлгийн эхэнд санал хураалт явуулж шийдвэрлэнэ. Мэтгэлцээний дараа хуралдаан ердийн дэгээр үргэлжилнэ.

35.8.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулахдаа дараах журмыг баримтална:

35.8.1.хууль санаачлагч илтгэлээ 10 минутанд багтаан танилцуулах;

35.8.2.энэ хуулийн 35.5-д заасны дагуу нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргасан бол уг санал, дүгнэлтийг 5 минутад багтаан танилцуулах;

35.8.3.энэ хуулийн 35.6-д заасны дагуу санал гаргасан бол уг саналыг 5 минутанд багтаан танилцуулах;

35.8.4.Тамгын газраас тухайн төсөлд хууль зүйн дүгнэлт болон төсвийн нөлөөллийн шинжилгээ хийсэн бол тэдгээрийг тус бүр 10 минутанд багтаан танилцуулах;

35.8.5.шаардлагатай гэж үзвэл хууль санаачлагч Тамгын газраас хуулийн төсөлд хийсэн хууль зүйн дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээтэй холбогдуулан тус бүр 5 минутад багтаан тайлбар хийх;

35.8.6.гишүүд хууль санаачлагчаас асуулт асуух;

35.8.7.шаардлагатай бол тухайн салбарын эрдэмтэн, судлаачийн саналыг сонсох;

35.8.8.гишүүд хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэх.

35.9.Хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагддаггүй гишүүн оролцож, асуулт асууж, үг хэлж болно.

35.10.Гишүүд хуралдаанд асуулт асууж, үг хэлэхдээ баримт, нотолгоонд суурилсан, үнэн, бодит мэдээлэлд тулгуурлах ба энэ журмыг зөрчсөн тохиолдолд хуралдаан даргалагч асуулт, үгийг тасалж болно.

35.11.Энэ хуулийн 35.8-д заасны дагуу хуралдааныг явуулсны дараа Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төсөл, түүнтэй хамт өргөн мэдүүлсэн төсөл тус бүрийг үзэл баримтлалын хүрээнд дэмжих эсэх асуудлаар ил санал хураалт явуулна. Хэрэв энэ хуулийн 35.7-д заасны дагуу мэтгэлцээн явуулсан тохиолдолд энэ хуулийн 35.8.1-35.8.5-д заасны дагуу хэлэлцүүлгийг явуулсны дараа ил санал хураалтыг шууд явуулж болно.

35.12.Санал хураалтын дүнгээр цөөнх болсон гишүүд үндэслэлээ тайлбарлаж дахин нэг удаа санал хураалгаж болох бөгөөд Байнгын хорооны

гишүүдийн олонхийн саналаар санал, дүгнэлт гаргаж, түүнийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.

35.13.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих боломжгүй гэж үзсэн бол хуулийн хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.

35.14.Хуулийн төслийн үзэл баримтлалыг дэмжих эсэх асуудлаар цөөнх болсон гишүүн нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.

35.15.Байнгын хороо хуулийн төслийн хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтдээ дараах зүйлийг тусгаж, нэгдсэн хуралдаанд оруулна:

35.15.1.хуулийн төслийн зардлын тооцоо;

35.15.2.хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага;

35.15.3.хууль зүйн дүгнэлт болон төсвийн нөлөөллийн дүн шинжилгээний талаарх мэдээлэл;

35.15.4.санал хураалтын дүн.

### **36 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах**

36.1.Хууль санаачлагч хуулийн төслийн үзэл баримтлалын талаар нэгдсэн хуралдаанд 10 минутад багтаан танилцуулга хийнэ.

36.2.Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд 10 минутад багтаан танилцуулна. Хэрэв энэ хуулийн 11.3-т заасны дагуу нам, эвслийн бүлгээс хууль, тогтоолын төслийн үзэл баримтлалын хүрээнд нэгдсэн хуралдаанд мэтгэлцээн явуулах санал, дүгнэлт гаргасан тохиолдолд энэ зүйлийн 36.3-36.4-т заасан дүгнэлт, саналыг сонссоны дараа мэтгэлцээн явуулна. Мэтгэлцээний дараа нэгдсэн хуралдаан ердийн дэгээр үргэлжилнэ.

36.3.Засгийн газар Хууль тогтоомжийн тухай хуулийн<sup>6</sup> 21.13-т заасны дагуу тухайн хуулийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хууль болон эрх зүйн бодлогод нийцээгүй, Хууль тогтоомжийн тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй гэсэн дүгнэлт гаргасан бол уг дүгнэлтийг хууль зүйн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нэгдсэн хуралдаанд 10 минутад багтаан танилцуулна. Засгийн газрын дүгнэлттэй холбогдуулан гишүүн асуулт асууж, үг хэлэхгүй.

36.4.Хуулийн төслийг баталснаар улсын төсвийн орлогын хэмжээ буурах, зарлагын хэмжээ нэмэгдэхээр байвал энэ тухай Засгийн газрын саналыг заавал сонсох бөгөөд хуралдаанд энэ хуулийн 31.2-т заасан Засгийн газрын гишүүн танилцуулна.

---

<sup>6</sup> Хууль тогтоомжийн тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2015 оны 25 дугаарт нийтлэгдсэн.

36.5.Хуралдаан даргалагч энэ хуулийн 9.2, 9.3-т заасны дагуу нам, эвслийн бүлгээс болон аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүнээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт, хариултыг зохион байгуулна.

36.6.Энэ хуулийн 36.5-д заасан дараалалд орсон гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлт, хууль санаачлагчийн илтгэл, хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлага, хуулийн төслийн үр нөлөө, зардлын тооцоо болон хуулийн төслийн үзэл баримтлалтай холбогдуулан асуулт асууж болно.

36.7.Нэгдсэн хуралдаанд асуулт, хариулт авах үйл ажиллагааг Зөвлөлөөс тогтоосон хугацаанд багтаан зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд хуралдаан даргалагч 1 хүртэл цагаар сунгаж болно.

36.8.Гишүүний асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.

36.9.Гишүүний асуултад хариулах хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй байна.

36.10.Хуулийн төслийн талаар Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаагаар үг хэлнэ. Гишүүд дэмжсэн, дэмжээгүй байр сууриа илэрхийлэхдээ индэрээс үг хэлнэ.

36.11.Гишүүн хуулийн төслийн үзэл баримтлалтай шууд холбогдолгүй асуудлаар үг хэлбэл хуралдаан даргалагч зогсоох эрхтэй.

36.12.Үг хэлж дууссаны дараа хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжих эсэх асуудлаар санал хураалт явуулна.

36.13.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бол тухайн хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлнэ.

36.14.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

36.15.Энэ хуулийн 36.14-т заасны дагуу үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжээгүй бол хуулийн төслийг нэг жилийн дотор дахин өргөн мэдүүлэхгүй.

### **37 дугаар зүйл.Төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулж ажиллуулах**

37.1.Холбогдох Байнгын хороо шаардлагатай бол анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 24.5-д заасны дагуу хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх, Байнгын хорооны санал, дүгнэлтийн төслийг бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурал дахь олонх, цөөнхийн харьцааг харгалзан 10 хүртэлх гишүүний бүрэлдэхүүнтэй байгуулж болно.

37.2.Шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хорооны саналаар Улсын Их Хурлын дарга хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий ажлын хэсэг байгуулж болно.

37.3.Тухайн хууль, тогтоолын төслийг хэд хэдэн Байнгын хороонд хуваарилсан бол Байнгын хороод хамтран ажлын хэсэг байгуулж болно.

37.4.Ажлын хэсгийн ахлагчид холбогдох Байнгын хорооноос нэг гишүүн нэр дэвшвэл шууд, нэгээс илүү гишүүн нэр дэвшвэл илээр санал хураалт явуулж, олонхын санал авсан гишүүнийг ахлагчаар томилно.

37.5.Энэ хуулийн 37.1-д заасан ажлын хэсэгт хууль санаачлагч орохгүй.

37.6.Ажлын хэсгийн хуралдааныг ажлын хэсгийн ахлагч товлон зарлаж хуралдуулах ба гишүүдийн олонх хүрэлцэн ирснээр хүчинтэйд тооцно. Хуралдаанаар олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

37.7.Ажлын хэсгийн хуралдаанд холбогдох салбарын мэргэжилтэн, шинжээчдийг татан оролцуулж болох ба Тамгын газрын ажилтнуудыг чиг үүргийнх нь дагуу байлцуулна.

37.8.Ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлийг энэ хуулийн 135 дугаар зүйлд заасны дагуу хөтөлж, хадгална.

37.9.Хуулийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэхтэй холбоотойгоор энэ зүйлд зааснаас өөр ажлын хэсэг, ажлын хэсгийн дор ажлын дэд хэсэг байгуулахгүй.

### **38 дугаар зүйл.Төслийн талаар олон нийтээс санал авч, хэлэлцэх журам**

38.1.Нэгдсэн хуралдаан хуулийн төслийн талаар олон нийтээс санал авахаар шийдвэрлэсэн бол холбогдох Байнгын хороо уг ажлыг анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө дараах журмаар зохион байгуулна:

38.1.1.тухайн төслийг өдөр тутмын хэвлэлд нийтлэх, сонирхлын бүлгийн хүрээнд хэлэлцүүлэг зохион байгуулах зэрэг аль нэг хэлбэрийг сонгох;

38.1.2.санал ирүүлэх хугацаа, хэлбэр, түүнийг хүлээн авах хаяг /утас, цахим шуудан/, хэлэлцүүлэг хийх өдөр зэргийг агуулсан мэдээллийг олон нийтэд хүргэх;

38.1.3.олон нийтээс ирүүлсэн саналыг судалж үзсэний үндсэн дээр холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл тухайн төсөлд санал өгсөн олон нийтийн төлөөллийг Байнгын хорооны хуралдаанд урьж ирүүлэн саналынх нь талаар тайлбар авах, асуулт асуух;

38.1.4.олон нийтээс тухайн төсөлтэй холбогдуулан бичгээр, эсхүл цахим хэлбэрээр Улсын Их Хуралд хандаж ирүүлсэн саналыг Тамгын газар ангилан нэгтгэж, холбогдох Байнгын хороонд тухайн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас өмнө хүргүүлэх.

### **39 дүгээр зүйл.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах**

39.1.Холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг явуулж, санал, дүгнэлт гаргана. Шаардлагатай гэж үзвэл Байнгын хороо нам, эвслийн бүлгээс гаргасан саналын дагуу төслийн тодорхой зүйл, хэсэг, заалтын талаар энэ хуулийн 11.2.2-т заасны дагуу урьдчилан ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хүрээнд мэтгэлцээн явуулна.

39.2.Хуулийн төслийг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед тухайн Байнгын хороонд харьяалагдсан гишүүн таслах эрхтэй оролцоно.

39.3.Нэг хуулийн төслийг хэд хэдэн Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргахаар хууль тогтоомжид заасан бол тэдгээр нь хуралдаанаа тус тусдаа зохион байгуулж, санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

39.4.Нэг хуулийн төслийг хэд хэдэн Байнгын хороогоор хэлэлцүүлэхээр хуваарилсан бол Байнгын хороод тухайн хуулийн төслийг хамтарсан хуралдаанаараа хэлэлцэж болно.

39.5.Тухайн асуудал хуваарилагдаагүй Байнгын хороо /цаашид “бусад Байнгын хороо” гэх/, нам, эвслийн бүлэг хуулийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан бол санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

39.6.Энэ хуулийн 39.3, 39.4, 39.5-д заасны дагуу санал, дүгнэлт гаргасан Байнгын хороо, нам, эвслийн бүлэг тухайн хуулийн төслийг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэхэд тэдгээрийг төлөөлөх гишүүнийг томилж, энэ тухай санал, дүгнэлтдээ тусгана.

39.7.Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч, энэ хуулийн 39.6-д заасан Байнгын хороо, нам, эвслийн бүлгийг төлөөлөх гишүүн, ажлын хэсгийн гишүүн, холбогдох бусад албан тушаалтан оролцоно.

39.8.Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч хуулийн төслийн талаар тодруулга, тайлбар хийж болно.

39.9.Хэрэв тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулсан бол тухайн ажлын хэсэг хуулийн төслийн талаарх тусгайлсан саналаа танилцуулна.

39.10.Байнгын хороо хуулийн төслийг зүйл бүрээр хэлэлцэнэ. Хэрэв төслийн зүйлээр хуульд шинээр бүлэг, дэд бүлэг нэмэх, бүлэг, дэд бүлгийг бүхэлд нь өөрчлөх бол тухайн бүлгийн зүйл бүрээр хэлэлцэнэ.

39.11.Гишүүн хуулийн төслийн тухайн зүйлтэй холбогдуулан хууль санаачлагчаас болон бусад оролцогчоос асуулт асууж болно.

39.12.Гишүүний асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 2 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.

39.13.Гишүүний асуултад хариулах хугацаа 3 минутаас илүүгүй, нэмэлт тайлбар өгөх хугацаа 2 хүртэл удаа тус бүр 2 минутаас илүүгүй байна.

39.14.Гишүүн, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 39.17-д заасан зарчмын зөрүүтэй саналаа хууль, тогтоолын төслийг яаралтай горимоор хэлэлцэж байгаагаас бусад тохиолдолд холбогдох Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулахаас ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө бичгээр урьдчилан ирүүлсэн байна.

39.15.Гишүүн, бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг хуулийн төсөлтэй холбогдуулан зарчмын зөрүүтэй санал гаргасан бол түүнийхээ үндэслэлийг 5 минутаас илүүгүй хугацаанд тайлбарлаж болно.

39.16.Гишүүн холбогдох Байнгын хороонд харьяалагддаг эсэхээс үл хамааран тухайн хэлэлцэж байгаа хуулийн төсөлд энэ хуулийн 4.1.4-т заасан шаардлагыг хангасан зарчмын зөрүүтэй санал ирүүлж болох бөгөөд санал гаргасан гишүүн хуралдаанд оролцсон эсэхээс үл хамааран гаргасан саналыг нь хэлэлцэж санал хураалт явуулна.

39.17.Байнгын хороо гишүүн, нам, эвслийн бүлгээс урьдчилсан ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулах бөгөөд энэ тохиолдолд хуулийн төслийн томъёолол хажуугийн саналд тооцогдоно.

39.18.Гишүүн, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 4.1.4-т заасны дагуу санал хураалгах болсон үндэслэлээ тайлбарлаагүй бол уг зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүй.

39.19.Энэ хуулийн 39.16-д заасан зарчмын зөрүүтэй саналын нэг томъёоллоор 3 хүртэл удаа санал хурааж болох бөгөөд 2 удаа олонхын дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны саналд тооцон нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд цөөнх болсон нам, эвслийн бүлгийг төлөөлөх гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтэд тэмдэглүүлж нэгдсэн хуралдаанд үг хэлж саналаа тайлбарлан санал хураалгаж болно.

39.20.Төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр 2 ба түүнээс дээш зарчмын зөрүүтэй саналын томъёолол гарсан тохиолдолд хамгийн эхэнд ирүүлсэн саналаар санал хураалт явуулахдаа бусад саналыг танилцуулж санал хураалгах бөгөөд уг санал дэмжигдвэл бусад санал дэмжигдээгүйд тооцож тэдгээр саналаар санал хураалт явуулахгүй. Энэ хуулийн 39.9-д заасны дагуу ажлын хэсэг байгуулсан бол ажлын хэсгийн саналаар эхэлж санал хураалт явуулна.

39.21.Байнгын хорооны санал хураалтаар санал нь дэмжигдээгүй цөөнх болсон нам, эвслийн бүлгийг төлөөлөх гишүүн Байнгын хорооны санал, дүгнэлтэд тэмдэглүүлж, нэгдсэн хуралдаанд үг хэлж саналаа тайлбарлан санал хураалгаж болно.

39.22.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 39.3, 39.4, 39.5-д заасны дагуу бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс ирүүлсэн, тухайн Байнгын хорооны гишүүний гаргасан зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг нэг бүрчлэн хэлэлцэн санал хураалт явуулж олонхын санал авсан, аваагүйгээр нь бүлэглэн нэгдсэн хуралдаанд танилцуулж санал хураалгана.

39.23.Хуулийн төслийн талаар гаргасан зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан төслийн бусад зүйл, хэсэг, заалтад нэг ижил нэр томъёоны, эсхүл

найруулгыг жигдлэх өөрчлөлт орохоор бол багцлан нэг санал хураалт явуулж болно.

39.24.Хуулийн төслийн талаар зарчмын зөрүүтэй саналын томъёолол гараагүй бол хуулийн төслийг анхны хэлэлцүүлгээс эцэслэн батлах үе шат руу шилжүүлэх горимын саналыг нэгдсэн хуралдаанд гаргаж болно.

39.25.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хуулийн төслийг хуульд заасан шаардлага хангаагүй гэж үзвэл хууль санаачлагчид буцаах тухай тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулна.

39.26.Нэг асуудлаар 2 ба түүнээс дээш хуулийн төсөл өргөн мэдүүлсэн бөгөөд хууль санаачлагчид нь нэгтгэн хэлэлцэхийг зөвшөөрсөн бол Байнгын хороо тэдгээрийг анхны хэлэлцүүлгийн шатанд нэгтгэн 1 төсөл болгож Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамтаар, хэрэв ийнхүү нэгтгэхийг зөвшөөрөөгүй бол тус тусад нь санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

39.27.Холбогдох Байнгын хороо хэлэлцэж байгаа төсөл болон тухайн төслийн талаар гаргасан санал нь улсын болон орон нутгийн төсөв, түүнчлэн санхүү, хөрөнгө оруулалт, бизнесийн орчинд шууд ба шууд бус байдлаар сөргөөр нөлөөлж болзошгүй гэж үзвэл олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулж болно.

39.28.Тухайн хуулийн төсөлтэй холбогдуулан иргэн, байгууллагаас бичгээр болон цахим хэлбэрээр санал ирүүлсэн, Байнгын хорооноос олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулсан бол энэ тухай мэдээллийг сонсоно.

39.29.Байнгын хороо хэлэлцэж байгаа төсөл болон тухайн төслийн талаар гаргасан саналтай холбогдуулан тусгайлан судалгаа, үр нөлөөний үнэлгээ хийлгэсэн, хууль зүйн дүгнэлт гаргуулсан бол тэдгээрийг Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

39.30.Тамгын газар энэ хуулийн 39.28, 39.29-т заасан санал, судалгаа, хууль зүйн дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаан болохоос 3-аас доошгүй хоногийн өмнө гишүүдэд тараасан байна.

39.31.Энэ хуулийн 39.28, 39.29-д заасны дагуу тусгайлан судалгаа, үр нөлөөний үнэлгээ хийлгэх, хууль зүйн дүгнэлт гаргуулах, олон нийтийн хэлэлцүүлэг, нийтийн сонсгол зохион байгуулах бол анхны хэлэлцүүлгийг түр хугацаагаар хойшлуулж болно.

39.32.Гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналаа Байнгын хорооны хуралдааны анхны хэлэлцүүлгийн явцад татан авч болно.

39.33.Байнгын хороо хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулсан талаарх санал, дүгнэлтдээ дараах зүйлийг тусгаж, нэгдсэн хуралдаанд оруулна:

39.33.1.зарчмын зөрүүтэй саналын үндэслэл, шаардлага;

39.33.2.хууль зүйн дүгнэлт гаргуулсан бол түүний талаарх мэдээлэл.

**40 дүгээр зүйл.Байнгын хороо хуулийн төслийн талаар санал, дүгнэлт**



## гаргах хүрээ хязгаар

40.1.Байнгын хороо анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийг хэлэлцэхдээ шинэ бүлэг, зүйл, хэсэг, заалт нэмэх, эсхүл өргөн мэдүүлсэн хуулийн төслөөс холбогдох бүлэг, зүйл, хэсэг, заалтыг хасах, бүтэц, найруулга, үг хэллэгийг өөрчлөх, засварлах тухай санал, дүгнэлт гаргана.

40.2.Энэ хуулийн 40.1-д заасан хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийн талаар санал, дүгнэлт гаргахад энэ хуулийн 40.3-т заасан хүрээ хязгаар хамаарахгүй.

40.3.Хуульд өөрчлөлт оруулах хуулийн төслийг хэлэлцэхдээ хуулийг дагаж мөрдөх журмын буюу шилжилтийн үеийн зохицуулалт, хуулийг дагаж мөрдөх хугацааны талаар өөрчлөлт оруулахаас бусад тохиолдолд дараах санал, дүгнэлт гаргахыг хориглоно:

40.3.1.хууль санаачлагчийн өргөн мэдүүлээгүй хуульд өөрчлөлт оруулах;

40.3.2.хуулийн төсөлд хөндөгдөөгүй зүйл, хэсэг, заалт, дэд заалтад өөрчлөлт оруулах;

40.3.3.хуулийн төсөлд найруулгын саналаас бусад зүйл, хэсэг, заалт, дэд заалт нэмэх.

40.4.Энэ хуулийн 40.1-д заасан Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлтийг хууль санаачлагч эс зөвшөөрвөл хуулийн төслөө татан авч болно.

### **41 дүгээр зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах**

41.1.Нэгдсэн хуралдаанаар зөвхөн холбогдох Байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан хуулийн төслийг хэлэлцэнэ.

41.2.Байнгын хороо, нам, эвслийн бүлэг санал, дүгнэлтээ танилцуулах хугацаа 10 минутаас илүүгүй байна.

41.3.Нэгдсэн хуралдаанд асуулт, хариулт авах үйл ажиллагааг Зөвлөлөөс тогтоосон хугацаанд багтаан зохион байгуулах ба шаардлагатай тохиолдолд хуралдаан даргалагч нэг хүртэл цагаар сунгаж болно.

41.4.Хуралдаан даргалагч энэ хуулийн 9.2, 9.3-т заасны дагуу нам, эвслийн бүлгээс болон аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй гишүүнээс урьдчилан ирүүлсэн нэрсийн дагуу асуулт, хариултыг зохион байгуулна.

41.5.Асуулт, хариулт дууссаны дараа Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томъёолол тус бүрээр дараах журмаар санал хураалт явуулна:

41.5.1.хуулийн төслийн талаар Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүдээс гаргасан зарчмын зөрүүтэй саналыг тайлбарлаж, түүнийг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй

тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаанд үг хэлсний дараа санал хураалт явуулах;

41.5.2.хуралдаан даргалагч зарчмын зөрүүтэй санал тус бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэх.

41.6.Хуралдаан даргалагч санал хураалт явуулах цагийг урьдчилан товлон зарлах бөгөөд санал хураалт явуулахаас 5 минутын өмнө тусгайлан дохио өгч гишүүдэд мэдэгдэнэ.

41.7.Гишүүн, нам, эвслийн бүлэг гаргасан зарчмын зөрүүтэй саналаа нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгийн явцад татан авч болно.

41.8.Санал хураалт явуулж дууссаны дараа хуралдаан даргалагч хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлэх ба энэ талаар санал хураалт явуулахгүй.

41.9.Хуулийн төслийг нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх хугацааг төслийн хэмжээ, цар хүрээг харгалзан хуралдаан даргалагч тогтоож болно.

41.10.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах үед хуулийн төслийн анхны хэлэлцүүлгийг дахин явуулах шаардлагатай гэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх үзсэн бол хуулийн төслийг Байнгын хороонд буцаана.

41.11.Энэ хуулийн 39.24-т заасан горимын саналыг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуулийн төслийг эцэслэн батлах үе шатанд шилжүүлнэ.

41.12.Байнгын хороо энэ хуулийн 39.25-д заасан үндэслэлээр хуулийн төслийг буцаах нь зүйтэй гэсэн санал, дүгнэлт гаргасныг нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

## **42 дугаар зүйл.Байнгын хорооны хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах**

42.1.Хуулийн төслийг холбогдох Байнгын хороо дараах журмаар нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэнэ:

42.1.1.нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг хуулийн төсөлд нэмж тусган эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төсөл болон хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулга бэлтгэх;

42.1.2.энэ хуулийн 42.1.1-д заасан төсөл болон танилцуулгыг Байнгын хорооны гишүүдэд урьдчилан тараан танилцуулсны үндсэн дээр хуралдаанаар хэлэлцэх;

42.1.3.энэ хуулийн 42.1.1-д заасан танилцуулгатай холбогдуулан гишүүд асуулт асуух.

42.2.Холбогдох Байнгын хороо эцсийн хэлэлцүүлэг явуулахдаа дараах тохиолдолд санал хураалт явуулж болно:

42.2.1.нэгдсэн хуралдаанаар анхны хэлэлцүүлэг явуулах үед тухайн зарчмын зөрүүтэй саналын томъёоллоор санал хураалт явуулахгүйгээр уг асуудлыг гүйцээн боловсруулж, хуулийн төслийн холбогдох зүйл, хэсэг, заалттай уялдуулахаар Байнгын хороонд шилжүүлсэн;

42.2.2.анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй санал болон хуулийн төслийн зүйл, хэсэг, заалт нь өөр хоорондоо, эсхүл бусад хуультай зөрчилдсөн талаарх энэ хуулийн 34.1-д заасан хууль зүйн дүгнэлтийг Хууль зүйн байнгын хороо дэмжиж санал, дүгнэлт гаргасан;

42.2.3.нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр санал хурааж дэмжигдсэн боловч уг саналаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн.

42.3.Энэ хуулийн 42.2-т зааснаас бусад үндэслэлээр нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргахыг хориглоно.

42.4.Байнгын хороогоор хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг хийсэн дүнд үндэслэн эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн төслийг бэлтгэж, танилцуулга, санал хураалгах томъёоллын хамт Улсын Их Хурлын нийт гишүүнд тараана.

42.5.Анхдагч болон хуулийн шинэчилсэн найруулгын төслийн анхны хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан Байнгын хороо төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэхдээ хууль тогтоомжийн хоорондын уялдааг хангах зорилгоор холбогдох бусад хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах хуулийн төслийг боловсруулан хамтад нь хэлэлцүүлж болно.

42.6.Энэ хуулийн 42.5-д заасан төсөл нь бусад Байнгын хорооны эрхлэх асуудалд хамааралтай бол тухайн Байнгын хороо уг төслийг хэлэлцэж, санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороонд хүргүүлсэн байна.

42.7.Төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэх болон энэ хуулийн 42.5-д заасан төслийг боловсруулах ажлыг холбогдох Байнгын хороо хариуцан гүйцэтгэнэ.

42.8.Энэ хуулийн 42.5-д заасны дагуу боловсруулсан төслийг энэ хуулийн 39, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн батална.

### **43 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах**

43.1.Байнгын хорооноос томилогдсон гишүүн хуулийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг нэгдсэн хуралдаанд 10 минутад багтаан танилцуулна.

43.2.Гишүүн энэ хуулийн 9.2, 9.3-т заасан журмын дагуу танилцуулгатай холбогдуулан асуулт асууж болно.

43.3.Байнгын хороо энэ хуулийн 42.4-т заасны дагуу санал хураалгах томьёолол оруулсан бол уг саналыг дэмжсэн, эсрэг байр суурьтай бүлгийг төлөөлж, мөн аль нэг нам, эвслийн бүлэгт харьяалагдаагүй тус бүр 2 хүртэл гишүүн 4 минутаас илүүгүй хугацаанд үг хэлсний дараа хуралдаан даргалагч саналын томьёолол тус бүрийг уншиж сонсгон санал хураалт явуулна.

43.4.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 43.3-т заасны дагуу санал хураалт явуулж дууссаны дараа тухайн хуулийн төслийг эцэслэн батлуулах бэлтгэл хангуулахаар холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ.

#### **44 дүгээр зүйл.Хуулийн төслийг эцэслэн батлах**

44.1.Байнгын хороо хуулийн төслийн эцсийн хэлэлцүүлгийн санал хураалтын дүнд үндэслэн эцэслэн батлуулах төслийн хувилбарыг бэлтгэж, нэгдсэн хуралдаан эхлэхээс өмнө гишүүдэд тараасан байна.

44.2.Нэгдсэн хуралдаанд хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол эцэслэн баталсанд тооцно.

44.3.Долоо хоногийн Баасан гарагийн 10.00 цагт нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалт явуулна. Хуралдааны ирц хуулийн төсөл эцэслэн батлах шаардлага хангахаар бол бусад өдөр, цагт хуулийн төслийг эцэслэн батлах санал хураалтыг явуулж болно.

44.4.Энэ хуулийн 44.2-т зааснаар хуулийн төслийг эцэслэн батлах саналыг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжээгүй бол түүнийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

44.5.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хуулийг хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол, уг хуулийг дагаж мөрдөх журмын тухай хуулийн төслийг энэ хуулийн 39, 40, 41, 42, 43, 44 дүгээр зүйлд заасны дагуу хэлэлцэн баталж болно.

44.6.Баталсан хуулийн эцсийн найруулгыг бэлтгэх хугацааг тухайн хуулийн хэмжээ, цар хүрээ холбогдох Байнгын хорооны саналыг харгалзан Улсын Их Хурлын дарга тогтооно.

#### **45 дугаар зүйл.Тогтоолын төслийг хэлэлцэх**

45.1.Улсын Их Хурал энэ хуулийн Арван нэгдүгээр бүлэгт зааснаас бусад асуудлаарх тогтоолын төслийг хэлэлцэх эсэх, анхны болон эцсийн хэлэлцүүлгийн үе шаттайгаар хэлэлцэн шийдвэрлэх бөгөөд энэ хуульд заасан хуулийн төслийг хэлэлцэх журмыг баримтална.

45.2.Энэ хуулийн 45.1-д зааснаас бусад асуудлаар Улсын Их Хурал шийдвэр гаргахаар хууль тогтоомжид тухайлан заасан болон хууль хэрэгжүүлэхтэй холбогдсон зохион байгуулалтын шинжтэй асуудлын талаар хариуцсан байгууллага, эрх бүхий албан тушаалтан саналаа холбогдох хуульд заасны дагуу ирүүлсэн бол холбогдох Байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

45.3.Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн холбогдох шийдвэрийг гаргана.

45.4.Нэгдсэн хуралдаан шаардлагатай гэж үзвэл уг асуудлыг дахин хэлэлцүүлэхээр холбогдох Байнгын хороонд буцааж болно.

45.5.Байнгын хороо боловсруулан Улсын Их Хуралд оруулах асуудлыг энэ хуулийн 45.2, 45.3, 45.4-т заасан журмын дагуу хэлэлцэнэ.

## **ТАВДУГААР БҮЛЭГ ХУУЛЬ, ТОГТООЛЫН ЭЦСИЙН НАЙРУУЛГА ХИЙХ, ЁСЧЛОХ**

### **46 дугаар зүйл.Хууль, тогтоолын эцсийн найруулгыг Улсын Их Хуралд танилцуулах, ёсчлох**

46.1.Энэ хуульд заасны дагуу баталсан хууль, тогтоолын эцсийн найруулга хийх, ёсчлох ажиллагааг дараах журмаар гүйцэтгэнэ:

46.1.1.холбогдох Байнгын хороо, Тамгын газрын эцсийн найруулга хийсэн хууль, тогтоолыг Ерөнхий нарийн бичгийн дарга хянаж, Улсын Их Хурлын даргад эцсийн хувилбарыг танилцуулах;

46.1.2.Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 46.1.1-д заасны дагуу ирүүлсэн хууль, тогтоолын эцсийн найруулгыг хянаж, Улсын Их Хуралд танилцуулахыг зөвшөөрөх;

46.1.3.Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.2-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцаж ёсчлохыг зөвшөөрөх;

46.1.4.Улсын Их Хурал энэ хуулийн 46.1.3-т заасан хууль, тогтоолын эцсийн найруулгатай танилцах үед гишүүний гаргасан найруулгын саналыг хуралдаан даргалагчийн зөвшөөрлөөр тусгах.

46.2.Улсын Их Хурлын дарга болон Ерөнхий нарийн бичгийн дарга энэ хуулийн 46.1.1, 46.1.2-т заасны дагуу эцсийн найруулгыг хянахдаа зөвхөн найруулгын шинжтэй засвар хийж болно.

46.3.Хуулийн эцсийн найруулгыг энэ хуулийн 46.1.3-т заасны дагуу Улсын Их Хуралд танилцуулснаас хойш Улсын Их Хурлын дарга ажлын 3 өдрийн дотор түүнд гарын үсэг зурж ёсчилно.

46.4.Энэ хуулийн 46.3-т заасны дагуу ёсчилсон хуулийг Тамгын газар ажлын 2 өдрийн дотор Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газарт илгээнэ.

46.5.Энэ хуулийн 46.4-т заасны дагуу илгээсэн хуулийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газар хүлээж авсан өдрөөс хойш ажлын 5 өдөрт багтаан Монгол Улсын Ерөнхийлөгч тухайн хууль, тогтоолыг бүхэлд нь буюу түүний зарим хэсэгт хориг тавих эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

46.6.Монгол Улсын Ерөнхийлөгч энэ хуулийн 46.5-д заасны дагуу хориг тавьсан бол Улсын Их Хурал түүнийг хүлээж авснаас хойш дараалал харгалзахгүйгээр тэргүүн ээлжид, ажлын 14 өдрийн дотор нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёр буюу 66.6 хувь нь хоригийг хүлээн аваагүй бол тухайн хууль, тогтоол хүчин

төгөлдөр хэвээр үлдэнэ.

46.7.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы чөлөө цагт хууль, тогтоолд хориг тавьсан бол уг хоригийг ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш энэ хуулийн 46.6-д заасан хугацаанд хэлэлцэн шийдвэрлэнэ.

46.8.Монгол Улсын Үндсэн хуульд заасан онцгой нөхцөл байдал үүссэн, эсхүл Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулганы хугацаа өндөрлөхтэй холбогдуулан Улсын Их Хурал Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг тавих хугацааг энэ хуулийн 46.5-д зааснаас өөрөөр тогтоож болно.

46.9.Хууль, тогтоолыг “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд цаасан болон цахим хэлбэрээр албан ёсоор нийтэлнэ.

## **ЗУРГАДУГААР БҮЛЭГ МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТӨСӨЛ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ**

### **47 дугаар зүйл.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэн шийдвэрлэх**

47.1.Монгол Улсын Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл /цаашид “Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл” гэх/-ийг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль<sup>7</sup> болон энэ хуульд заасан журмаар хэлэлцэнэ.

47.2.Байнгын хорооны хуралдаанд тухайн Байнгын хороонд харьяалагддаг нийт гишүүний олонх хүрэлцэн ирсэн бол түүнийг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд хүчин төгөлдөр ирцтэй гэж үзнэ.

47.3.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэхэд энэ хуулийн 5.1, 5.3 дахь хэсэг хамаарахгүй.

47.4.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүний асуулт асуух хугацаа 8 минутаас илүүгүй, нэмэлт асуулт асуух хугацаа 2 минутаас илүүгүй, гишүүний асуултад хариулах хугацаа 8 минутаас илүүгүй, нэмэлт хариулт, тайлбар өгөх хугацаа 1 минутаас илүүгүй, гишүүн үг хэлэх хугацаа 10 минутаас илүүгүй, Байнгын хороо, нам, эвслийн бүлэг санал, дүгнэлтээ танилцуулах хугацаа 20 минутаас илүүгүй байна.

47.5.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 11.3.5-д заасны дагуу нууцаар санал хураахаар шийдвэрлэснээс бусад тохиолдолд ил санал хураалт явуулна.

47.6.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, хэлэлцүүлэгтэй холбоотой мэдээллийг нийтэд зарлан мэдээлэх, төслийг нийтэлж санал авах, түүнийг нэгтгэн судлах, хэлэлцүүлгийн явцад ирсэн саналыг нэгтгэн танилцуулах

---

<sup>7</sup> Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2011 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

үйл ажиллагааг Төрийн байгуулалтын байнгын хороо болон Тамгын газар хариуцан зохион байгуулна.

47.7.Хуулиар Улсын Их Хурлаас батлах хугацааг нь тусгайлан заасан асуудлыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хэлэлцүүлгийн дундуур хэлэлцэн шийдвэрлэж болно.

#### **48 дугаар зүйл.Нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэх**

48.1.Төрийн байгуулалтын байнгын хороо Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэнэ.

48.2.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хууль санаачлагчийн илтгэлийг сонсоно.

48.3.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар хууль санаачлагчийн илтгэлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болох бөгөөд хэлэлцэх эсэх асуудлаар цөөнх болсон гишүүн нэгдсэн хуралдаанд үг хэлэх хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.

48.4.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх эсэх талаар санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар уг төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх эсэх тухай санал, дүгнэлт гаргаж, түүнийг илтгэх гишүүнийг томилно.

#### **49 дүгээр зүйл.Нэг дэх хэлэлцүүлэг явуулах**

49.1.Нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12 дугаар зүйлд заасан журмын дагуу төслийн нэг дэх хэлэлцүүлгийг явуулж, хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлнэ.

49.2.Нэгдсэн хуралдаанаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 12.2-т заасны дагуу гишүүд дэмжээгүй бол төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

49.3.Төрийн байгуулалтын байнгын хороо санал гаргасан бол төслийг хоёр, гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх үүрэг бүхий Ажлын хэсгийг гишүүдийн олонхын саналаар байгуулна.

#### **50 дугаар зүйл.Хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэх**

50.1.Байнгын хороод Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 13 дугаар зүйлд заасны дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэж санал, дүгнэлтээ гаргана.

50.2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчаас асуулт асууж, саналаа урьдчилан бичгээр томъёолж хуралдаан даргалагчид өгсний үндсэн дээр түүнийхээ үндэслэлийг тайлбарлан 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж санал хураалгах эрхтэй. Гишүүн хуралдаанд өөрөө оролцоогүй бол түүний гаргасан саналыг нь хэлэлцэж санал хураалт явуулна.

50.3.Энэ хуулийн 50.2-т заасан санал нь Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй бол гишүүн Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанд зарчмын зөрүүтэй саналаа тайлбарлан үг хэлж, санал хураалгах хүсэлтээ Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгуулж болно.

50.4.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг холбогдох Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх үед тухайн Байнгын хороонд харьяалагдсан гишүүд таслах эрхтэй оролцоно.

50.5.Саналын 1 томьёоллоор 3 хүртэл удаа санал хурааж болох бөгөөд 2 удаа Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны дэмжсэн санал гэж тооцон нэгдсэн хуралдаанд оруулна.

50.6.Байнгын хороо санал, дүгнэлтдээ дараах зүйлийг тусгана:

50.6.1.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаарх мэдээлэл;

50.6.2.Байнгын хороо дэмжсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол, үндэслэл, шаардлага;

50.6.3.санал хураалтын дүн.

50.7.Байнгын хороод санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

50.8.Төрийн байгуулалтын байнгын хороо холбогдох Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс ирүүлсэн зарчмын зөрүүтэй саналын үндэслэлийг санал тус бүрээр 5 минутаас илүүгүй хугацаанд тайлбарлан санал хураалгах бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан саналыг нэгдсэн хуралдаанд оруулна.

50.9.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй бол зарчмын зөрүүтэй саналыг төсөлд тусгах шаардлагагүй санал гэж үзсэн үндэслэл, шалтгаанаа Байнгын хороо санал, дүгнэлтдээ тусгана.

50.10.Зарчмын зөрүүтэй саналаар санал хураахдаа төслийн зүйл, хэсэг, заалт тус бүрээр хамтатган санал хураана.

50.11.Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдаанаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах тухай санал хураалт явуулж, Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн талаар санал, дүгнэлт гаргана.

50.12.Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14.5-д заасан тогтоолын төслийг боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулна.



## **51 дүгээр зүйл.Хоёр дахь хэлэлцүүлэг явуулах**

51.1.Нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан журмын дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг явуулна.

51.2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн талаар Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналаа 10 минутад багтаан тайлбарлаж, саналыг дэмжсэн болон эсрэг байр суурьтай 10 хүртэл гишүүн тус бүр 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлсний дараа санал хураалт явуулна.

51.3.Нэгдсэн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлгийг явуулахдаа Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14.3, 14.4-т заасныг баримтлан шаардлагатай бол саналын 1 томьёоллоор 3 хүртэл удаа санал хурааж болох бөгөөд 2 удаа Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан саналыг дэмжигдсэн санал гэж үзнэ.

51.4.Энэ хуулийн 51.3-т заасан санал хураалтаар шийдвэрлэгдсэн санал нь Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтын утга агуулга, ач холбогдлыг алдагдуулах, зөрчилдөхөд хүргэвэл Төрийн байгуулалтын байнгын хороо гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ өргөн мэдүүлсэн төслийн зүйл, хэсэг, заалтыг баримтлан зөрчлийг арилгах санал, дүгнэлт гаргана.

## **52 дугаар зүйл.Гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэх**

52.1.Төрийн байгуулалтын байнгын хороо дараах журмаар Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг нэгдсэн хуралдааны гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэнэ:

52.1.1.нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан саналыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд нэмж тусган эцсийн хувилбар болон гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай санал, дүгнэлт гаргах;

52.1.2.энэ хуулийн 52.1.1-д заасан Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөл, санал, дүгнэлтийг Байнгын хорооны гишүүдэд 3-аас доошгүй хоногийн өмнө урьдчилан тарааж, хуралдаанаар хэлэлцэх;

52.1.3.энэ хуулийн 52.2-т заасан үндэслэлээр Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтыг баримтлан санал хураалт явуулах бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг авсан саналыг Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусгах.

52.2.Байнгын хороо энэ хуулийн 53.1-д заасан гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэхдээ дараах тохиолдолд санал хураалт явуулж болох бөгөөд Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэж, шийдвэрлэнэ:

52.2.1.нэгдсэн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед төслийн зарим зүйл, хэсэг, заалтыг гүйцээн боловсруулах чиглэл хуралдаан даргалагчаас өгсөн;

52.2.2.энэ хуулийн 51.4-т заасан санал, дүгнэлт;

52.2.3.нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр санал хурааж шийдвэрлэсэн боловч уг асуудлаар Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүй нь дахин санал хураалгах шаардлагатай гэж үзсэн;

52.2.4.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтад найруулгын засвар хийсэн.

52.3.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёроос доошгүйн дэмжлэг аваагүй бол зарчмын зөрүүтэй саналыг төсөлд тусгах шаардлагагүй гэж үзсэн үндэслэл, шалтгаанаа Байнгын хороо санал, дүгнэлтдээ тусгана.

52.4.Энэ хуулийн 52.1.3, 52.2-т зааснаас бусад үндэслэлээр нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргахыг хориглоно.

### **53 дугаар зүйл.Гурав дахь хэлэлцүүлэг явуулах**

53.1.Нэгдсэн хуралдаанаар Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15 дугаар зүйлд заасан журмын дагуу Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн гурав дахь хэлэлцүүлгийг явуулна.

53.2.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонссоны дараа гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж болно.

53.3.Төрийн байгуулалтын байнгын хорооноос энэ хуулийн 50.2-т заасан саналын томьёолол тус бүрийг 10 минутад багтаан тайлбарлаж, саналын томьёолол бүрийг дэмжсэн, дэмжээгүй байр суурьтай 10 хүртэл гишүүн тус бүр 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлж болно.

53.4.Саналын томьёолол тус бүрээр санал хураалт явуулах бөгөөд Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүй нь дэмжсэн бол саналыг Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төсөлд тусгана.

53.5.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 15.7-д заасан санал хураалтыг 2 удаа явуулахад Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн санал авч эс чадвал Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

53.6.Улсын Их Хурал шаардлагатай гэж үзвэл хууль хэрэгжүүлэх арга хэмжээний тухай тогтоол, дагаж мөрдөх журмын тухай хууль болон холбогдох бусад хууль тогтоомжид нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг энэ хуулийн 38, 39, 40, 41, 42,43 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн баталж болно.

### **54 дүгээр зүйл.Ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг хэлэлцэн шийдвэрлэх**

54.1.Ард нийтийн санал асуулгаар Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлыг Ард нийтийн санал асуулгын тухай хууль<sup>8</sup>, Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 17 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэнэ.

54.2.Төрийн байгуулалтын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоолын төслийг хэлэлцэж, Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар батална.

54.3.Төрийн байгуулалтын байнгын хороо Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналыг өөрчлөх буюу хүчингүй болгох санал, дүгнэлт гаргах, гишүүн, цөөнх хоёр дахь хэлэлцүүлгээр батлагдсан саналаасаа зөрүүтэй болон өөр зүйл, хэсэг, заалт нэмэх санал гаргахыг тус тус хориглоно.

54.4.Төрийн байгуулалтын байнгын хороо ард нийтийн санал асуулгад оруулах төслийг дараах журмаар нэгдсэн хуралдааны нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэнэ:

54.4.1.Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 14 дүгээр зүйлд заасан нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын нийт гишүүний дөрөвний гурваас доошгүйн дэмжлэг авсан саналыг төсөлд нэмж тусган ард нийтийн санал асуулгад оруулах төсөл болон нэг дэх хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай санал, дүгнэлт гаргах;

54.4.2.энэ хуулийн 54.4.1-д заасан төсөл, санал, дүгнэлтийг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх;

54.4.3.ард нийтийн санал асуулгад оруулах төсөлд найруулгын засвар хийх саналын томъёоллыг Байнгын хорооны нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэн шийдвэрлэх.

54.5.Нэгдсэн хуралдаанаар ард нийтийн санал асуулгад оруулах төслийн нэг дэх хэлэлцүүлгийг дараах журмаар явуулна:

54.5.1.Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсох;

54.5.2.санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, тайлбар авах;

54.5.3.Төрийн байгуулалтын байнгын хорооноос Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтад найруулгын засвар хийсэн бол найруулгын томъёолол тус бүрийг 10 минутад багтаан тайлбарлаж, найруулгын томъёолол бүрийг дэмжсэн, дэмжээгүй байр суурьтай 10 хүртэл гишүүн тус бүр 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх;

---

<sup>8</sup> Ард нийтийн санал асуулгын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2016 оны 9 дугаарт нийтлэгдсэн.

54.5.4.Үндсэн хуульд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийн зүйл, хэсэг, заалтад найруулгын засвар хийх саналын томьёолол тус бүрийг Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар хэлэлцэж, шийдвэрлэх;

54.5.5.ард нийтийн санал асуулгад оруулах төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төрийн байгуулалтын байнгын хороонд шилжүүлэх.

54.6.Төрийн байгуулалтын байнгын хороо ард нийтийн санал асуулгад оруулах төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт дараах журмаар бэлтгэнэ:

54.6.1.нэгдсэн хуралдааны нэг дэх хэлэлцүүлгээр Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн найруулгын томьёоллыг тусгасан ард нийтийн санал асуулгад оруулах төслийг бэлтгэх;

54.6.2.гишүүд төсөлтэй холбогдуулж асуулт асууж, үг хэлэх;

54.6.3.ард нийтийн санал асуулгад оруулах төслийг нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлэгт оруулах талаар санал, дүгнэлт гаргах.

54.7.Нэгдсэн хуралдаанаар ард нийтийн санал асуулгад оруулах төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг дараах журмаар явуулна:

54.7.1.Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсох;

54.7.2.гишүүд ард нийтийн санал асуулгад оруулах төсөлтэй холбогдуулан асуулт асууж, тайлбар авах, үг хэлэх;

54.7.3.ард нийтийн санал асуулгад оруулах эхийг батлах.

54.8.Улсын Их Хурлын нийт гишүүний гурваас доошгүйн саналаар ард нийтийн санал асуулгад оруулах эхийг батлах санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн нэмэлт, өөрчлөлтийн эхийг батлах тухай тогтоол баталсанд тооцно.

## **55 дугаар зүйл.Ард нийтийн санал асуулгын дүнг Улсын Их Хуралд танилцуулах**

55.1.Нэгдсэн хуралдаанаар ард нийтийн санал асуулгын дүнгийн тухай Сонгуулийн ерөнхий хорооны даргын илтгэл, Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг сонсоно.

55.2.Гишүүд Сонгуулийн ерөнхий хорооны даргын илтгэл, Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

55.3.Ард нийтийн санал асуулгаар Монгол Улсын Үндсэн хуулийн эхийг сонгуулийн эрх бүхий иргэдийн олонх нь оролцож, тэдгээрийн олонх нь уг хуулийг “зөвшөөрнө” гэсэн санал өгсөн бол Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль баталсанд тооцож, хуралдаан даргалагч зүйл, хэсэг, заалт нэг бүрээр уншиж сонсгосноор хүчин төгөлдөр болно.

55.4.Ард нийтийн санал асуулгаар баталсан хуулийг хүчин төгөлдөр болсонд тооцсоноос хойш ажлын 2 өдрийн дотор Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид биечлэн хүргэж танилцуулна.

55.5.Ард нийтийн санал асуулгаар баталсан хуулийн уг эхийг нотлох, хадгалах, албан ёсны эхийг нийтлэхэд Монгол Улсын Үндсэн хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах журмын тухай хуулийн 16.3, 16.4-т заасныг баримтална.

## **ДОЛДУГААР БҮЛЭГ ХӨГЖЛИЙН БОДЛОГО, ТӨЛӨВЛӨЛТИЙН БАРИМТ БИЧГИЙН ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭН БАТЛАХ**

### **56 дугаар зүйл.Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэх үе шат, хэлэлцүүлгийн ерөнхий журам**

56.1.Засгийн газраас өргөн мэдүүлсэн хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл /цаашид “бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл” гэх/-ийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг, анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг гэсэн үе шаттайгаар хэлэлцэнэ.

56.2.Энэ хуулийн 56.1-д заасан бодлого, төлөвлөлтийн баримт бичигт Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль<sup>9</sup> болон бусад хуульд Улсын Их Хурал хэлэлцэн батлахаар заасан урт, дунд, богино хугацааны хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг хамааруулна.

56.3.Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн хэлэлцүүлэгтэй холбоотой энэ бүлэгт тусгайлан заагаагүй бусад асуудлыг зохицуулахад энэ хуульд заасан хуулийн төсөл хэлэлцэх журмыг баримтална.

### **57 дугаар зүйл.Байнгын хорооны хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах**

57.1.Хууль санаачлагч бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн үзэл баримтлалын талаар холбогдох Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

57.2.Гишүүн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн талаар асуулт асууж, үг хэлж болно.

57.3.Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулж, дараах асуудлыг санал, дүгнэлтдээ тусгаж, нэгдсэн хуралдаанд оруулна:

57.3.1.бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөл Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчим, шаардлагад нийцсэн байдал;

57.3.2.өмнөх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийн үр дүнг үнэлсэн эсэх;

57.3.3.бодлого, төлөвлөлтийн бусад баримт бичигтэй нийцсэн эсэх;

---

<sup>9</sup> Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2020 оны 21 дугаарт нийтлэгдсэн.

57.3.4.хөгжлийн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийг шинээр батлах, өөрчлөлт оруулах хэрэгцээ, шаардлага байгаа эсэх.

57.4.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг дэмжээгүй бол Байнгын хороо тухайн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг тогтоолын төсөлд буцаах үндэслэлийг тусгасан байна.

**58 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг явуулах**

58.1.Хууль санаачлагч бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн үзэл баримтлалын талаар нэгдсэн хуралдаанд 20 минутад багтаан танилцуулга хийнэ.

58.2.Холбогдох Байнгын хороо санал, дүгнэлтээ, нам, эвслийн бүлэг тухайн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг урьдчилан хэлэлцсэн бол санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд 10 минутад багтаан танилцуулна.

58.3.Гишүүн хууль санаачлагчийн илтгэл, холбогдох Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

58.4.Гишүүн үг хэлсний дараа бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэх эсэх асуудлаар холбогдох Байнгын хорооны саналаар санал хураалт явуулна.

58.5.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг үзэл баримтлалын хүрээнд хэлэлцэхийг дэмжсэн бол төслийн анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох болон бусад Байнгын хороонд шилжүүлнэ.

58.6.Санал хураалтад оролцсон гишүүдийн олонх бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн үзэл баримтлалыг дэмжээгүй бол тухайн бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хууль санаачлагчид нь буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

**59 дүгээр зүйл.Байнгын хорооны хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах**

59.1.Холбогдох Байнгын хороо бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

59.2.Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан бол санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

59.3.Холбогдох Байнгын хороо гишүүд, бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн зарчмын зөрүүтэй саналыг нэгтгэн нэгдсэн хуралдаанд оруулна.

59.4.Бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлтэй холбогдуулан гаргах санал нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчим, шаардлагад нийцсэн байна.

59.5.Байнгын хорооны хуралдаанд хууль санаачлагч бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн талаар тайлбар хийж болно.

59.6.Байнгын хороо бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлэгт бэлтгэхдээ энэ хуульд заасан хуралдааны нийтлэг журмыг баримтална.

#### **60 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн анхны хэлэлцүүлэг явуулах**

60.1.Холбогдох Байнгын хороо, нам, эвслийн бүлэг санал, дүгнэлтээ 10 минутад багтаан танилцуулна.

60.2.Гишүүн Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, тайлбар авч болно.

60.3.Асуулт, хариулт дууссаны дараа Байнгын хорооноос санал хураалгахаар бэлтгэсэн зарчмын зөрүүтэй саналын томьёолол тус бүрээр санал хураалт явуулна.

60.4.Санал хураалт явуулахаас өмнө зарчмын зөрүүтэй саналтай холбогдуулан хууль санаачлагчийн саналыг сонсож болно.

60.5.Санал хураалт явуулж дууссаны дараа хуралдаан даргалагч бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлэх ба энэ талаар санал хураалт явуулахгүй.

#### **61 дүгээр зүйл.Байнгын хорооны хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах**

61.1.Холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдааны анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн зарчмын зөрүүтэй саналыг бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төсөлд тусган, эцсийн хувилбарын төслийг бэлтгэж, танилцуулгын хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

61.2.Байнгын хороо бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг энэ хуулийн 42 дугаар зүйлд заасан журмын дагуу явуулна.

#### **62 дугаар зүйл.Нэгдсэн хуралдаанаар бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн эцсийн хэлэлцүүлэг явуулах**

62.1.Нэгдсэн хуралдаан холбогдох Байнгын хорооны танилцуулгыг сонсож, төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална.

62.2.Нэгдсэн хуралдаан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг энэ хуулийн 43.1, 43.2, 43.3, 43.4-т заасан журмын дагуу явуулна.

### **63 дугаар зүйл. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр хэлэлцэх**

63.1. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хэлэлцэх эсэх хэлэлцүүлэг, анхны хэлэлцүүлэг, эцсийн хэлэлцүүлэг гэсэн гурван үе шаттайгаар хэлэлцэн батална.

63.2. Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш ажлын 10 өдрийн дотор холбогдох Байнгын хороогоор хэлэлцэх эсэх хэлэлцүүлгийг хийнэ.

63.3. Ерөнхий сайд Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг 20 минутад багтаан танилцуулна.

63.4. Байнгын хорооны хуралдаанд гишүүд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

63.5. Асуулт асууж, үг хэлж дууссаны дараа Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хэлэлцэх эсэх асуудлаар санал хураалт явуулж, Байнгын хороо санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулна. Санал, дүгнэлтэд төсөл нь Монгол Улсын Үндсэн хууль, Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуульд заасан зарчим, шаардлагад нийцсэн эсэх талаар тусгана.

63.6. Нэгдсэн хуралдаанд Байнгын хороо санал, дүгнэлтээ танилцуулна. Нам, эвслийн бүлэг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг урьдчилан хэлэлцсэн бол санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна.

63.7. Нэгдсэн хуралдаанд гишүүд хууль санаачлагчаас болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

63.8. Хуралдаан даргалагч Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороодод шилжүүлнэ. Энэ талаар санал хураалт явуулахгүй.

63.9. Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хуралдаанаараа хэлэлцэх бөгөөд ийнхүү хэлэлцэхдээ хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн эсэхийг нягталж, холбогдох Байнгын хороонд санал, дүгнэлтээ хүргүүлнэ.

63.10. Нам, эвслийн бүлэг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн талаарх санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

63.11. Холбогдох Байнгын хороо нь гишүүн, бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгээс гаргасан зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, зарчмын зөрүүтэй саналуудыг олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн, нэгдсэн хуралдаанд оруулна.

63.12. Гишүүн Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд болон холбогдох бусад албан тушаалтнаас, түүнчлэн Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

63.13. Нэгдсэн хуралдаан Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн талаарх Байнгын хороодын санал, дүгнэлтийг хэлэлцэн санал хураалт явуулна.



63.14.Хуралдаан даргалагч Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг эцсийн хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ.

63.15.Холбогдох Байнгын хороо анхны хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналуудыг Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төсөлд тусгаж эцсийн хэлэлцүүлгийг хийж, уг төслийг батлуулахаар нэгдсэн хуралдаанд оруулна.

63.16.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийн эцсийн хэлэлцүүлгийг энэ хуулийн 42 дугаар зүйл, 43.1, 43.2, 43.3, 43.4-т заасан журмын дагуу явуулна.

63.17.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална.

**НАЙМДУГААР БҮЛЭГ  
ТӨСВИЙН ХҮРЭЭНИЙ МЭДЭГДЭЛ,  
УЛСЫН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ, МӨНГӨНИЙ  
БОДЛОГО, ЭРДЭНЭСИЙН САНГИЙН ТӨСӨВ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ**

**64 дүгээр зүйл.Төсвийн хүрээний мэдэгдлийг хэлэлцэх**

64.1.Улсын Их Хурал төсвийн хүрээний мэдэгдлийг жил бүрийн 6 дугаар сарын 01-ний дотор энэ хуульд заасан хуулийн төсөл хэлэлцэх журмын дагуу хэлэлцэж эцэслэн батална.

64.2.Тухайн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн талаар нэгдсэн хуралдаанд илтгэхдээ төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажилласан, гарсан үр дүнг хэрхэн тусгасан талаар танилцуулна.

64.3.Олон нийтийн хэлэлцүүлгээс гарсан санал, түүнийг дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төсөлд тусгасан байдалд Тамгын газар дүн шинжилгээ хийж, танилцуулгыг гишүүдэд тараана.

**65 дугаар зүйл.Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төслийн  
нэг дэх хэлэлцүүлэг явуулах**

65.1.Улсын Их Хурал улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний төсөл /цаашид "жилийн төлөвлөгөөний төсөл" гэх/-ийг Улсын Их Хурлын хаврын ээлжит чуулганаар улсын төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй уялдуулан хэлэлцэнэ.

65.2.Ерөнхий сайд, эсхүл түүний томилсон Засгийн газрын гишүүн Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд жилийн төлөвлөгөөний төслийг 10 минутад багтаан танилцуулна.

65.3.Байнгын хорооны хуралдаанаар жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцэж, санал, дүгнэлт гарган, түүнийг нэгдсэн хуралдаанд илтгэх гишүүнийг томилно.

65.4.Нам, эвслийн бүлэг жилийн төлөвлөгөөний төслийн талаар санал, дүгнэлт гаргасан бол нэгдсэн хуралдаанд 5 минутад багтаан танилцуулна.

65.5.Гишүүн жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүний асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, тодруулах асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.

65.6.Улсын Их Хурал энэ зүйлд заасны дагуу жилийн төлөвлөгөөний төслийн нэг дэх хэлэлцүүлгийг хийж жилийн төлөвлөгөөний төсөл Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хуулийн 6.10-т заасан шаардлага хангасан эсэх талаар санал хураалт явуулна.

65.7.Энэ хуулийн 65.6-д заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол жилийн төлөвлөгөөний төслийг ажлын гурван өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгч Засгийн газарт буцаана.

65.8.Хуралдаан даргалагч жилийн төлөвлөгөөний төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ. Энэ талаар санал хураалт явуулахгүй.

#### **66 дугаар зүйл.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар жилийн төлөвлөгөөний төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулах**

66.1.Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг жилийн төлөвлөгөөний төслийг хэлэлцсэн бол санал, дүгнэлтээ зарчмын зөрүүтэй саналын томьёоллын хамт холбогдох Байнгын хороонд хүргүүлнэ.

66.2.Жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан ажлын хэсэг байгуулсан бол тухайн ажлын хэсэг төслийн талаарх саналаа холбогдох Байнгын хорооны хуралдаанд танилцуулна.

66.3.Гишүүд энэ хуулийн 66.2-т заасан ажлын хэсгийн саналтай холбогдуулан асуулт асууж болно.

66.4.Холбогдох Байнгын хороо жилийн төлөвлөгөөний төсөлтэй холбогдуулан гишүүн, бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, ажлын хэсгээс гаргасан зарчмын зөрүүтэй санал тус бүрээр санал хураалт явуулж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулна.

66.5.Гишүүн гаргасан зарчмын зөрүүтэй саналынхаа үндэслэлийг 4 минутаас илүүгүй хугацаанд тайлбарлаж болно.

66.6.Нэгдсэн хуралдаан холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн, зарчмын зөрүүтэй саналын томьёоллоор санал хураалт явуулна.

66.7.Хуралдаан даргалагч жилийн төлөвлөгөөний төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ.

#### **67 дугаар зүйл.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар жилийн төлөвлөгөөний төслийн гурав дахь хэлэлцүүлэг явуулах**

67.1.Холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр дэмжигдсэн саналуудыг жилийн төлөвлөгөөний төсөлд тусгасан эцсийн хувилбарын

төслийг Байнгын хорооны гишүүдэд урьдчилан тараан танилцуулсны үндсэн дээр Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэнэ.

67.2.Энэ хуулийн 67.1-д заасан эцсийн хувилбарын төсөлтэй холбогдуулан гишүүн асуулт асууж болно.

67.3.Холбогдох Байнгын хороо жилийн төлөвлөгөөний төслийг гурав дахь хэлэлцүүлэгт бэлтгэсэн тухай танилцуулгыг эцсийн хувилбарын төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

67.4.Нэгдсэн хуралдаанд холбогдох Байнгын хорооны танилцуулгыг сонсож, жилийн төлөвлөгөөний төслийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар батална.

67.5.Жилийн төлөвлөгөөний төслийн хэлэлцүүлэгтэй холбоотой энэ бүлгээр зохицуулаагүй бусад асуудлыг зохицуулахад хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмыг баримтална.

#### **68 дугаар зүйл.Мөнгөний бодлого, Монголбанкны Эрдэнэсийн сангийн төсвийн төслийг хэлэлцэх**

68.1.Улсын Их Хурал Мөнгөний бодлогын төсөл, Эрдэнэсийн сангийн төсвийн төслийг энэ хуулийн 45.2-т заасныг баримтлан тухай бүр хэлэлцэж, эцэслэн батална.

68.2.Монголбанкны Ерөнхийлөгч байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд мөнгөний бодлогын үндсэн чиглэлийн тайлан, Эрдэнэсийн сангийн орлого, зарлагын тайланг 10 минутад багтаан танилцуулна.

68.3.Байнгын хорооны хуралдаанаар тухайн тайланг хэлэлцэж, санал, дүгнэлтээ шийдвэрийн төслийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

68.4.Нам, эвслийн бүлэг төслийн талаар санал, дүгнэлт гаргасан бол нэгдсэн хуралдаанд 5 минутад багтаан танилцуулна.

68.5.Гишүүн тайлан, шийдвэрийн төсөлтэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүний асуулт асуух хугацаа 4 минутаас илүүгүй, тодруулах асуулт асуух хугацаа 1 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авч болно.

#### **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ УЛСЫН ТӨСӨВ, ТҮҮНИЙ ГҮЙЦЭТГЭЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ**

##### **69 дүгээр зүйл.Улсын төсвийн төслийг хэлэлцэх үе шат**

69.1.Улсын төсөв /цаашид "төсөв" гэх/-ийн төслийг Улсын Их Хурал 10 дугаар сарын эхний 7 хоногт хэлэлцэж эхлэх ба 11 дүгээр сарын 15-ны өдрийн дотор дараах дөрвөн үе шаттайгаар хэлэлцэн батална:

69.1.1.төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулах;

69.1.2.төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төсөлд өөрчлөлт оруулах санал, дүгнэлт гаргах;

69.1.3.төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг буюу төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн үр дүнг танилцуулах;

69.1.4.төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг буюу төсвийн төслийг эцэслэн батлах.

69.2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27 дугаар зүйлд заасны дагуу төсвийн төсөлд хяналтын сонсгол явуулах бол хоёр дахь хэлэлцүүлгийн өмнө төсвийн төслийн цаглаварт нийцүүлэн Төсвийн байнгын хороо сонсгол зохион байгуулж болно.

69.3.Улсын Их Хурал Нийгмийн даатгалын сан, Эрүүл мэндийн даатгалын сангийн тухайн жилийн төсвийг батлахдаа энэ бүлэгт заасан Улсын төсвийг хэлэлцэн батлах журмыг баримтална.

## **70 дугаар зүйл.Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэг**

70.1.Төсвийн төслийн нэг дэх хэлэлцүүлэгт төсвийн төслийн талаарх илтгэлийг Ерөнхий сайд, тухайн төсөл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 23.1-д заасан шаардлагыг хангасан эсэх талаарх төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дүгнэлтийг тус Зөвлөлийн дарга тус тус танилцуулна. Ерөнхий сайдын илтгэлд төсвийн төслийг боловсруулахад олон нийтийн оролцоог хангаж ажилласан байдал, гарсан үр дүнг төсвийн төсөлд тусгасан талаар танилцуулна.

70.2.Төсвийн төсөлтэй холбогдуулан Төрийн аудитын төв байгууллага болон Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс хийсэн дүгнэлтийг гишүүдэд тараана.

70.3.Нэг дэх хэлэлцүүлэгт Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын дарга болон Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дарга, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга, Шүүхийн сахилгын хорооны дарга, Улсын ерөнхий прокурор, Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн дарга, Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын газрын дарга, Монгол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга, Үндэсний аюулгүй байдлын зөвлөлийн нарийн бичгийн дарга нар оролцоно.

70.4.Гишүүд энэ хуулийн 70.1-д заасан илтгэлтэй холбогдуулан Ерөнхий сайдаас, дүгнэлттэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхий аудитор, Төсвийн тогтвортой байдлын зөвлөлийн даргаас энэ хуулийн 70.2-т заасан дүгнэлттэй холбогдуулан, төсвийн төсөлтэй холбогдуулан энэ хуулийн 70.3-т заасан төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, үг хэлнэ.

70.5.Улсын Их Хурал энэ зүйлд заасны дагуу асуулт асууж, үг хэлсний дараа төсвийн төсөл нь Төсвийн тухай болон Төсвийн тогтвортой байдлын тухай хуульд заасан шалгуур, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тусгай шаардлага, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөнд нийцсэн эсэх талаар санал хураалт явуулна.

70.6.Энэ хуулийн 70.5-д заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол төсвийн төслийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд шилжүүлнэ.

70.7.Энэ хуулийн 70.5-д заасан санал хураалтад оролцсон гишүүдийн олонх дэмжээгүй бол төсвийн төслийг ажлын гурван өдрийн дотор хуульд нийцүүлэн өргөн мэдүүлэх чиглэл өгч Засгийн газарт буцаана.

#### **71 дүгээр зүйл.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг**

71.1.Төсвийн болон бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо эрхлэх асуудлынхаа хүрээнд, нам, эвслийн бүлэг төсвийн төслийг хэлэлцэнэ.

71.2.Санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн төсвийн төслийн танилцуулгыг, Монгол Улсын Ерөнхий аудитор төсвийн төслийн талаарх аудитын дүгнэлтийг Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанд танилцуулна.

71.3.Байнгын болон дэд хорооны хуралдаанд гишүүд Байнгын, дэд хорооны эрхлэх асуудлын хүрээнд хууль санаачлагч, Монгол Улсын Ерөнхий аудитор болон төсвийн ерөнхийлөн захирагч нараас асуулт асууж, гаргасан саналынхаа үндэслэлийг тайлбарлаж үг хэлж болно.

71.4.Бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо төрийн аудитын төв байгууллагын дүгнэлтийг хуульд заасан эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж болно.

71.5.Бусад Байнгын хороо, Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны хуралдаанд гишүүн, нам, эвслийн бүлэг, төрийн аудитын төв байгууллага саналаа зарчмын зөрүүтэй саналын томъёоллын хамт гаргана.

71.6.Бусад Байнгын хороод, Төсвийн зарлагын хяналтын дэд хороо энэ хуулийн 71.5-д заасан санал тус бүрээр санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томъёолж, зарчмын зөрүүтэй саналын томъёоллыг санал, дүгнэлтийн хамт Төсвийн байнгын хороонд хүргүүлнэ.

71.7.Байнгын болон дэд хороо, нам, эвслийн бүлгийн хуралдаанаар төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага, нам, эвслийн бүлгийн гаргасан санал дараах шаардлагыг хангасан байна:

71.7.1.хөгжлийн болон үндэсний аюулгүй байдлын бодлогод нийцсэн байх;

71.7.2.Засгийн газраас өргөн мэдүүлсэн төсвийн зарлагын болон алдагдлын дүнг нэмэгдүүлээгүй байх;

71.7.3.Төсвийн тухай хуулийн<sup>10</sup> 6.2.6, 29.3, 29.4-т нийцсэн байх.

71.8.Нам, эвслийн бүлэг, гишүүн, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага тодорхой төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардал

<sup>10</sup> Төсвийн тухай хууль “Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн 2012 оны 3 дугаарт нийтлэгдсэн.

нэмэгдүүлэх санал гаргасан бол бусад төсөл, хөтөлбөр, арга хэмжээний зардлыг мөн хэмжээгээр бууруулах, түүнчлэн татвар бууруулах санал гаргасан бол мөн хэмжээгээр зардал бууруулах саналыг хамтад нь гаргаж, нэг санал болгон санал хураалт явуулах бөгөөд саналуудыг багцлан хурааж болно. Санал хураалт явуулахын өмнө тухайн саналтай холбогдуулан Засгийн газрын тайлбарыг сонсож болно.

71.9.Төсвийн байнгын хороо энэ хуулийн 71.6-д заасан болон Төсвийн байнгын хорооны гишүүд, түүнчлэн төсөвтэй холбогдуулан Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага, нам, эвслийн бүлгээс гаргасан санал нэг бүрийг хэлэлцэж ил санал хураалт явуулж олонхын дэмжлэг авсан, аваагүйгээр нь бүлэглэн томьёолж, энэ хуулийн 71.13-т заасан дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна.

71.10.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийн шатанд гарсан төсвийн санал энэ хуульд заасан шаардлагыг хангаагүй, эсхүл хууль тогтоомж зөрчсөн гэж үзвэл энэ талаар Засгийн газар нэгдсэн хуралдаанд мэдэгдэл хийж болно.

71.11.Нэгдсэн хуралдаанаар төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед Байнгын хороо, нам, эвслийн бүлэг, гишүүд, Монгол Улсын Ерөнхийлөгч, төрийн аудитын төв байгууллага гаргасан саналаа тайлбарлан үг хэлж болно.

71.12.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 71.9-д заасан санал тус бүрээр ил санал хураалт явуулна.

71.13.Төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан төсвийн санал нь энэ хуулийн 71.7.2, 71.7.3-т заасан шаардлагыг хангасан эсэх талаар Тамгын газрын төсвийн хяналт, шинжилгээний асуудал хариуцсан нэгж дүн шинжилгээ хийж, дүгнэлтийг нэгжийн дарга нэгдсэн хуралдаанд танилцуулна.

71.14.Нэгдсэн хуралдаанаас төсвийн төслийн хоёр дахь хэлэлцүүлгийг тодорхой асуудлын хүрээнд дахин явуулах шаардлагатай гэж үзвэл Төсвийн байнгын хороонд чиглэл өгч буцааж болно.

## **72 дугаар зүйл.Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлэг**

72.1.Төсвийн төслийн гурав дахь хэлэлцүүлгээр Төсвийн байнгын хороо нэгдсэн хуралдааны хоёр дахь хэлэлцүүлгээр олонхын дэмжлэг авсан саналыг төсвийн төсөлд нэмж тусган, шаардлагатай бол гишүүнээс гаргасан саналын дагуу хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төсөвт өртөг, санхүүжих дүнг өөрчлөхгүй, агуулга, зарчмыг алдагдуулахгүйгээр арга хэмжээний нэр, хүчин чадал, байршилтай холбоотой залруулгыг хийж, төсвийн төслийн эцсийн хувилбарыг танилцуулгын хамтаар нэгдсэн хуралдаанд оруулна.

72.2.Нэгдсэн хуралдаанаар гурав дахь хэлэлцүүлэг явуулахад зөвхөн Төсвийн байнгын хорооноос гаргасан танилцуулгын талаар гишүүд тайлбар хийх, түүнтэй холбогдуулан асуулт асууж болох бөгөөд санал хураалт явуулахгүй.

72.3.Хуралдаан даргалагч төсвийн төслийг дөрөв дэх хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн байнгын хороонд шилжүүлнэ.

72.4.Төсвийн төслийн гурав, дөрөв дэх хэлэлцүүлгийг хамтатган явуулж болно.

### **73 дугаар зүйл.Төсвийн төслийн дөрөв дэх хэлэлцүүлэг**

73.1.Нэгдсэн хуралдаан даргалагч Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуулийн төслийн зүйл, заалт бүрийг уншин сонсгож, зүйл тус бүрээр нь санал хураалт явуулж батлуулна.

73.2.Шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хууль баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолыг энэ хуульд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмын дагуу хэлэлцэн баталж болно.

73.3.Монгол Улсын тухайн жилийн төсвийн тухай хуульд тодотгол хийх асуудлыг энэ хуулийн 69-73 дугаар зүйлд заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

73.4.Төсвийн төслийн хэлэлцүүлэгтэй холбоотой энэ бүлгээр зохицуулаагүй бусад асуудлыг энэ хуульд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмыг баримтална.

### **74 дүгээр зүйл.Төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайланг хэлэлцэх**

74.1.Засгийн газар Улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоолын төслийг нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлан /цаашид “төсвийн гүйцэтгэл” гэх/-ийн хамт Төсвийн тухай хуулийн 8.10.3-т заасан хугацаанд Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

74.2.Төсвийн гүйцэтгэлийн талаарх танилцуулгад төсвийн орлого, зарлагыг эдийн засгийн ангиллаар, төсвийн ерөнхийлөн захирагч бүрээр гаргаж, баталсан төсвөөс зөрүүтэй бол түүний шалтгааныг тайлбарласан дэлгэрэнгүй мэдээллийг хавсаргасан байна.

74.3.Төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхэд Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүд, төсвийн ерөнхийлөн захирагч нар, Монгол Улсын Ерөнхий аудитор байлцана.

74.4.Төсвийн гүйцэтгэлийг дараах хоёр үе шаттайгаар хэлэлцэнэ:

74.4.1.нэг дэх хэлэлцүүлэгт төсвийн гүйцэтгэлийн талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний гишүүн илтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар сонсох;

74.4.2.хоёр дахь хэлэлцүүлгээр Байнгын хороод, нам, эвслийн бүлэг төсвийн гүйцэтгэлийг хэлэлцэхдээ төсвийн гүйцэтгэлийн талаар санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүний илтгэл, нэгдсэн төсвийн гүйцэтгэл, Засгийн газрын санхүүгийн нэгтгэсэн тайлангийн талаарх аудитын дүгнэлтийг сонсож, санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн, төсвийн ерөнхийлөн захирагч нараас төсвийн гүйцэтгэл, санхүүгийн нэгтгэсэн тайлантай холбоотой асуулт асууж, үг хэлж, санал дүгнэлт гаргах;

74.4.3.Байнгын хороод, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 74.4.2-т заасан санал, дүгнэлтээ Төсвийн зарлагын хяналтын дэд хороонд өгөх ба тус дэд хороо эдгээр санал, дүгнэлтийг хэлэлцэн нэгтгэн гаргасан санал, дүгнэлтээ нэгдсэн

хуралдаанд оруулна.

74.5.Нэгдсэн хуралдаанаар нэг дэх хэлэлцүүлэг явуулах үед гишүүд энэ хуулийн 74.4.1-д заасан илтгэл болон аудитын дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн энэ хуулийн 74.3-т заасан албан тушаалтнаас асуулт асууж, үг хэлж болох бөгөөд үүний дараа төсвийн гүйцэтгэлийг хоёр дахь хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр Төсвийн зарлагын хяналтын дэд хороо болон Байнгын хороодод шилжүүлнэ.

74.6.Нэгдсэн хуралдаанаар хоёр дахь хэлэлцүүлэг явуулах үед Төсвийн зарлагын хяналтын дэд хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан гишүүд асуулт асууж, хариулт авсны дараа улсын төсвийн орлого, зарлагын нийт дүнг тусгасан Улсын төсвийн гүйцэтгэл батлах тухай тогтоол батална.

74.7.Шаардлагатай гэж үзвэл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо Улсын төсвийн гүйцэтгэл баталсантай холбогдуулан авах арга хэмжээний тухай тогтоолын төсөл боловсруулж нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

## **АРАВДУГААР БҮЛЭГ**

### **ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ БАЙГУУЛАХ САНАЛ, ГЭРЭЭНИЙ ТӨСЛИЙГ ХЭЛЭЛЦЭХ, ГАДААД ХАРИЛЦААТАЙ ХОЛБОГДОХ АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ**

#### **75 дугаар зүйл.Хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг зөвшилцөх**

75.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар Улсын Их Хурал соёрхон батлах хоёр болон олон талт олон улсын гэрээ байгуулах бол уг олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний эцэслэн тохиролцсон, эсхүл үзэглэсэн төсөл, эсхүл баталсан буюу жинхэлсэн эх бичвэрийн хуулбар, боломжтой бол баталгаат хуулбар, тэдгээрийн орчуулга, олон улсын гэрээнд нэгдэн орсноор Монгол Улсад үзүүлэх үр нөлөө, үр дагаврын талаарх дүн шинжилгээний хамт тухайн олон улсын гэрээнд гарын үсэг зурахаас өмнө Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлнэ.

75.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэр, холбогдох баримт бичгийг хэлэлцэхээс 3 хоногийн өмнө гишүүдэд тараана.

75.3.Дараах олон улсын гэрээний тухайд олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг дараах байнгын хороо тус тусдаа урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ:

75.3.1.чөлөөт худалдаа, давхар татвар, хөрөнгө оруулалттай холбогдсон олон улсын гэрээний төслийг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороо;

75.3.2.Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн олон улсын гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээний төслийг Хууль зүйн байнгын хороо;

75.3.3.хүний салшгүй эрх, эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээний төслийг Хууль зүйн байнгын хороо.



75.4.Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг хэлэлцэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлж болно.

75.5.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэр, холбогдох баримт бичиг, Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороодын, эсхүл бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэнэ.

75.6.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн танилцуулна.

75.7.Олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эх бичвэртэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

75.8.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийн талаар ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах санал, дүгнэлтийн аль нэгийг гаргана:

75.8.1.олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг бүхэлд нь зөвшөөрч, олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт олгох;

75.8.2.баталсан буюу жинхэлсэн олон талт гэрээний эх бичвэрээс бусад олон улсын гэрээний төсөлтэй холбогдуулан зарчмын шинжтэй тодорхой засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлэх;

75.8.3.олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг дэмжээгүй бол шалтгааныг тайлбарласан санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлэх.

75.9.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын санал, эсхүл олон улсын гэрээний агуулга, ач холбогдлыг харгалзан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гишүүдийн олонхын саналаар олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэж болно.

75.10.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар энэ хуулийн 75.8.2-т заасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтийн дагуу олон улсын гэрээний төсөлд засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар олон улсын гэрээний нөгөө тал, эсхүл бусад талтай хэлэлцээ хийж, хэлэлцээний үр дүнг олон улсын гэрээний шинэчилсэн төслийн хамт Улсын Их Хуралд зөвшилцөхөөр дахин ирүүлнэ.

75.11.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар энэ хуулийн 75.8.3-т заасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтэд дурдсан шалтгааныг арилгасан бол олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний шинэчилсэн төслийг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлж болно.

75.12. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо нь Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороодын санал, дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл энэ тухай санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

75.13. Энэ хуулийн 75.9, 75.12-т заасны дагуу хэлэлцүүлсэн олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн гишүүдийн олонхын саналаар энэ хуулийн 75.8.1, 75.8.2, 75.8.3-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.

#### **76 дугаар зүйл. Зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээ байгуулах санал, гэрээний төслийг урьдчилан зөвшилцөх**

76.1. Гадаад улс, олон улсын байгууллага, гадаад улсын болон олон улсын банк, санхүүгийн байгууллагаас авах зээлийн ерөнхий нөхцөлийн талаарх олон улсын гэрээний тухайд гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг Эдийн засгийн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

76.2. Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаар олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэр, холбогдох баримт бичгийг Төсвийн тогтвортой байдлын тухай, Өрийн удирдлагын тухай хуульд заасан төсвийн тусгай шаардлагад нийцүүлэн хэлэлцэнэ.

76.3. Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаар олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрт дараах нөхцөлийг тусгасан эсэхийг хянан хэлэлцэнэ:

76.3.1. тухайн зээлийн зориулалтыг тодорхой тусгасан эсэх;

76.3.2. зээлийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь Монгол Улсын урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичигт тусгагдсан хөгжлийн зорилтот хөтөлбөртэй уялдсан, тэргүүлэх ач холбогдлоор эрэмбэлэгдсэн төсөл, хөтөлбөр байх;

76.3.3. улс орны нийгэм, эдийн засгийн өсөлтийг дэмжсэн, импортыг орлох болон экспортлох бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн салбарт болон зөвхөн үр ашигтай төслүүдийг санхүүжүүлэхэд чиглэгдсэн байх;

76.3.4. тухайн зээлийн хэмжээ төсвийн тусгай шаардлагын тогтоосон хэмжээнд нөлөөлөхгүй, гадаад валютын нөөцийг нэмэгдүүлэхэд чиглэгдсэн байх.

76.4. Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанд олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн танилцуулна.

76.5. Олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эх бичвэртэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

76.6. Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаар олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний

төсөл, эсхүл эх бичвэрийн талаар ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах санал, дүгнэлтийн аль нэгийг гаргана:

76.6.1.олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг бүхэлд нь зөвшөөрч, олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт олгох;

76.6.2.баталсан буюу жинхэлсэн олон талт гэрээний эх бичвэрээс бусад олон улсын гэрээний төсөлтэй холбогдуулан зарчмын шинжтэй тодорхой засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлэх;

76.6.3.олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг дэмжээгүй бол шалтгааныг тайлбарласан санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлэх.

76.7.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газрын санал, эсхүл олон улсын гэрээний агуулга, ач холбогдлыг харгалзан Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэн зөвшилцөхөөр шийдвэрлэж болно.

76.8.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар энэ хуулийн 76.6.2-т заасан Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтийн дагуу олон улсын гэрээний төсөлд засвар, нэмэлт, өөрчлөлт оруулах асуудлаар олон улсын гэрээний нөгөө тал, эсхүл бусад талтай хэлэлцээ хийж, хэлэлцээний үр дүнг олон улсын гэрээний шинэчилсэн төслийн хамт Улсын Их Хуралд зөвшилцөхөөр дахин ирүүлнэ.

76.9.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар энэ хуулийн 76.6.3-т заасан Төсвийн болон Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хамтарсан хуралдаанаас гаргасан санал, дүгнэлтэд дурдсан шалтгааныг арилгасан бол олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний шинэчилсэн төслийг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлж болно.

76.10.Энэ хуулийн 76.7-д заасны дагуу хэлэлцүүлсэн олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээний төсөл, эсхүл эх бичвэрийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн гишүүдийн олонхын саналаар энэ хуулийн 76.6.1, 76.6.2, 76.6.3-т заасан шийдвэрийн аль нэгийг гаргана.

## **77 дугаар зүйл.Олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох санал, гэрээг урьдчилан зөвшилцөх, хэлэлцүүлэх**

77.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар Улсын Их Хурал соёрхон батлах хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээний эх бичвэрийн хуулбар, боломжтой бол баталгаат хуулбар, шаардлагатай бол түүний орчуулга, гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй олон улсын гэрээний тухайд тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төслийг Улсын Их Хуралд зөвшилцөх, хэлэлцүүлэхээр ирүүлнэ.

77.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээ, хуулийн төсөл, холбогдох баримт бичгийг хэлэлцэхээс 3 хоногийн өмнө гишүүдэд тараана.

77.3.Чөлөөт худалдаа, давхар татвар, хөрөнгө оруулалттай холбогдсон олон улсын гэрээний тухайд олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээг Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороод тус тусдаа урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

77.4.Дараах олон улсын гэрээний тухайд олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээг Хууль зүйн байнгын хороо урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ:

77.4.1.Монгол Улсын хуульд зааснаас өөр журам тогтоож байгаа, эсхүл тухайн олон улсын гэрээг байгуулснаар, нэгдсэнээр, эсхүл хэрэгжүүлснээр Монгол Улсын хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах, эсхүл хууль шинээр батлах шаардлагатай олон улсын гэрээ;

77.4.2.хүний салшгүй эрх, эрх зүйн туслалцаа үзүүлэх, гэмт этгээд болон ялтан шилжүүлэхтэй холбогдсон олон улсын гэрээ.

77.5.Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээ болон хуулийн төслийг хэлэлцэн санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлж болно.

77.6.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төсөл, баримт бичиг, Төсвийн, Эдийн засгийн болон Хууль зүйн байнгын хороонд, эсхүл бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлтийг нэгтгэн хэлэлцэнэ.

77.7.Байнгын хорооны хуралдаанд олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээ болон хуулийн төслийг Монгол Улсын Ерөнхийлөгчийн итгэмжлэгдсэн төлөөлөгч, эсхүл тухайн олон улсын гэрээгээр зохицуулах асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн танилцуулна.

77.8.Олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөлтэй холбогдуулан гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

77.9.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төслийн талаар ил санал хураалт явуулж, гишүүдийн олонхын саналаар дараах санал, дүгнэлтийн аль нэгийг гаргана:

77.9.1.олон улсын гэрээнд нэгдэн орохыг зөвшөөрч, тухайн олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт олгох;

77.9.2.гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй олон улсын гэрээний тухайд тухайн олон улсын гэрээнд нэгдэн орохыг зөвшөөрч, гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх;

77.9.3.олон улсын гэрээнд нэгдэн орох санал, олон улсын гэрээг дэмжээгүй бол шалтгааныг тайлбарласан санал, дүгнэлтийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт хүргүүлэх.

77.10.Энэ хуулийн 77.9.2-т заасан шийдвэр гаргахдаа тухайн олон улсын гэрээг соёрхон батлахдаа тайлбар хийхээр Засгийн газраас санал болгосон бол тайлбар хийх шаардлагатай эсэх талаарх Байнгын хорооны санал, дүгнэлтийг хамтад нь гаргана.

77.11.Энэ хуулийн 77.9.2-т заасан гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй хүчин төгөлдөр олон талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг холбогдох Байнгын хороо Засгийн газарт буцаахгүйгээр нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлнэ.

77.12.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газар энэ хуулийн 77.9.3-т заасан Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны санал, дүгнэлтэд дурдсан шалтгааныг арилгасан бол олон улсын гэрээнд нэгдэн орох саналыг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр ирүүлж болно.

77.13.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Төсвийн болон Эдийн засгийн байнгын хороодын, эсхүл Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг зөвшөөрөх боломжгүй гэж үзвэл энэ тухай санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж шийдвэрлүүлнэ.

77.14.Энэ хуулийн 77.9.2, 77.13-т заасны дагуу хэлэлцүүлэх олон улсын гэрээ байгуулах санал, олон улсын гэрээ болон хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төслийг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар дараах шийдвэрийн аль нэгийг гаргана:

77.14.1.олон улсын гэрээнд нэгдэн орохыг зөвшөөрч, олон улсын гэрээнд гарын үсэг зурах эрхийг Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газарт олгох;

77.14.2.гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй олон улсын гэрээний тухайд тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай хууль батлах;

77.14.3.гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй олон улсын гэрээнд нэгдэн орохыг зөвшөөрч, тухайн олон улсын гэрээг соёрхон батлах тухай болон холбогдох бусад хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох бусад хуулийн төсөл эрхлэх асуудалд нь хамаарах Байнгын хороонд шилжүүлэх.

77.15.Гарын үсэг зурах боломжит хугацаа нь дууссан, эсхүл гарын үсэг зурах шаардлагагүй олон улсын гэрээнээс бусад олон талт олон улсын гэрээнд Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, гадаад харилцааны асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн гарын үсэг зурахаас өмнө энэ хуульд заасны дагуу Улсын Их Хуралтай зөвшилцөнө.

## **78 дугаар зүйл.Хоёр талт олон улсын гэрээг соёрхон батлах асуудлыг хэлэлцэх**

78.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас өргөн мэдүүлсэн хоёр талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад

бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж дараах санал, дүгнэлтийн аль нэгийг гаргаж нэгдсэн хуралдаанд танилцуулна:

78.1.1. олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлах;

78.1.2. олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах.

78.2. Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 78.1-д заасан олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлсэн бол тус Байнгын хороо тэдгээрийг хэлэлцэж санал, дүгнэлт гаргахдаа харгалзан үзэж болно.

78.3. Нэгдсэн хуралдаан хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Байнгын хорооноос оруулсан саналын томъёоллоор ил санал хураалт явуулж Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол соёрхон батлах тухай хууль эцэслэн баталсанд тооцно.

78.4. Улсын Их Хурлын нийт гишүүний олонх олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

78.5. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

#### **79 дүгээр зүйл. Олон талт олон улсын гэрээг соёрхон батлах асуудлыг хэлэлцэх**

79.1. Монгол Улсын Ерөнхийлөгч, Засгийн газраас өргөн мэдүүлсэн олон талт олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төслийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэж дараах санал, дүгнэлтийн аль нэгийг гаргаж нэгдсэн хуралдаанд танилцуулна:

79.1.1. олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг батлах;

79.1.2. олон улсын гэрээг тайлбартайгаар соёрхон батлах;

79.1.3. олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцэх эсэх асуудлыг хэлэлцүүлэх;

79.1.4. олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах.

79.2. Бусад Байнгын хороо, нам, эвслийн бүлэг энэ хуулийн 79.1-д заасан олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төсөл, шаардлагатай бол холбогдох бусад хуулийн төслийг хэлэлцэж санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд ирүүлсэн бол тус Байнгын хороо тэдгээрийг хэлэлцэж санал, дүгнэлт гаргахдаа харгалзан үзэж болно.

79.3.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хуулийн төслийг хэлэлцэх үед гишүүд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

79.4.Энэ хуулийн 79.1.1-д заасан олон улсын гэрээний тухайд нэгдсэн хуралдаан хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, Байнгын хорооноос оруулсан саналын томъёоллоор ил санал хураалт явуулж, Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол соёрхон батлах тухай хууль эцэслэн баталсанд тооцно.

79.5.Энэ хуулийн 79.1.2-т заасны дагуу Байнгын хороо олон улсын гэрээг тайлбартайгаар батлах санал гаргасан бол уг тайлбар, мэдэгдлийн төслийг гэрээний хамт нэгдсэн хуралдаанд оруулж тусад нь санал хураалгаж батлуулна.

79.6.Энэ хуулийн 79.1.3-т заасны дагуу нэгдсэн хуралдаанаас хэлэлцэх нь зүйтэй гэж үзсэн олон улсын гэрээ соёрхон батлах тухай болон холбогдох бусад хуулийн төслийг анхны хэлэлцүүлэгт бэлтгүүлэхээр холбогдох бусад хуулийн төсөл эрхлэх асуудалд нь хамаарах Байнгын хороонд шилжүүлж, энэ хуульд заасан хуулийн төсөл хэлэлцэх журмаар хамтад нь хэлэлцэнэ.

79.7. Улсын Их Хурлын нийт гишүүний олонх олон улсын гэрээг соёрхон батлах тухай хуулийн төслийг дэмжээгүй бол хуулийн төслийг хууль санаачлагчид буцаах тухай тогтоол баталсанд тооцно.

#### **80 дугаар зүйл.Гадаад улсыг хүлээн зөвшөөрөх, түүнтэй дипломат харилцаа тогтоох, цуцлах тухай асуудлыг хэлэлцэх**

80.1.Засгийн газар гадаад улсыг хүлээн зөвшөөрөх тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаан ил санал хураалт явуулж гишүүдийн олонхын саналаар асуудлыг шийдвэрлэнэ.

80.2.Засгийн газар гадаад улстай дипломат харилцаа шинээр буюу сэргээн тогтоохоор төлөвлөж байгаа бол энэ тухай саналаа танилцуулгын хамтаар Улсын Их Хуралд ирүүлнэ.

80.3.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо энэ хуулийн 80.2-т заасны дагуу Засгийн газраас ирүүлсэн санал, танилцуулгыг хуралдаанаараа хэлэлцэж ил санал хураалт явуулж гишүүдийн олонх дэмжсэн бол саналыг дэмжиж байгаагаа Засгийн газарт хариу мэдэгдэх ба ингэхдээ уг асуудлыг эцэслэн шийдвэрлэхэд анхаарвал зохих асуудлаар гишүүдийн гаргасан саналыг хавсаргана.

80.4.Засгийн газар гадаад улстай дипломат харилцаа тогтоох, эсхүл цуцлах асуудлаар тогтоолын төсөл өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг энэ хуулийн 80.1-д заасан журмын дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

#### **81 дүгээр зүйл.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг нь тогтоох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх**

81.1.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг тогтоох саналыг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр

ирүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо 7 хоногийн дотор хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

81.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Засгийн газраас зөвшилцөхөөр ирүүлсэн санал, танилцуулгыг хуралдаанаараа хэлэлцэж ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол саналыг дэмжиж байгаагаа Засгийн газарт хариу мэдэгдэх ба ингэхдээ уг асуудлыг эцэслэн шийдвэрлэхэд анхаарвал зохих асуудлаар гишүүдийн гаргасан саналыг хавсаргана.

**82 дугаар зүйл.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг нь тогтоох тухай тогтоолын төсөл хэлэлцэх**

82.1.Хилийн чанадад ажиллах Дипломат төлөөлөгчийн газрыг шинээр нээн ажиллуулах, түвшин, байршлыг тогтоох тухай тогтоолын төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж, нэгдсэн хуралдаан ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэр гаргах бөгөөд энэ асуудлаар Улсын Их Хурал тогтоол батална.

**АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
БУСАД АСУУДАЛ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ**

**83 дугаар зүйл.Ард нийтийн санал асуулга явуулах саналыг хэлэлцэх**

83.1.Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоолын төслийг Төрийн байгуулалтын болон Хууль зүйн байнгын хороод урьдчилан хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

83.2.Нэгдсэн хуралдаанаар хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хороодын санал, дүгнэлтийг сонсож ил санал хураалт явуулж, Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь дэмжсэн бол Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоол баталсанд тооцно.

83.3.Энэ хуулийн 83.2-т заасан тогтоолын төсөлд шийдвэрлэх асуудлын агуулгыг илэрхийлсэн асуулт, түүнд өгөх эсрэг утга бүхий хариултын хувилбарыг тусгана.

83.4.Ард нийтийн санал асуулга явуулах тухай тогтоолын төслийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд гишүүд хууль санаачлагчийн илтгэл, Байнгын хороодын санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

**84 дүгээр зүйл.Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дүгнэлтийг хэлэлцэх журам**

84.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан маргаантай асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэц /цаашид "Цэц" гэх/ дүгнэлт гаргасан бол түүнийг ёсчилсноос хойш 24 цагийн дотор Улсын Их Хуралд ирүүлнэ.

84.2.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь



хэсгийн 1, 2-т заасан маргаантай асуудлаар Цэц дүгнэлтээ Улсын Их Хуралд оруулсан бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:

84.2.1.Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөөт цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон холбогдох Байнгын хороо хэлэлцэж бүхэлд нь, эсхүл зарим хэсгийг нь /хэсэгчлэн/ хүлээн зөвшөөрөх, эс зөвшөөрөх асуудлаар санал, дүгнэлт гаргах;

84.2.2.энэ хуулийн 84.2.1-д заасны дагуу Байнгын хороод Цэцийн дүгнэлтийг хэлэлцэн санал, дүгнэлт гаргахдаа холбогдох хууль, тогтоолын Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн зүйл, хэсэг, заалт бүрээр, хэрэв Монгол Улсын Үндсэн хуулийн хэд хэдэн заалтыг зөрчсөн бол Монгол Улсын Үндсэн хуулийн холбогдох заалт бүрээр тус тусад нь санал хураалт явуулах;

84.2.3.нэгдсэн хуралдаан энэ хуулийн 84.2.2-т заасны дагуу Байнгын хорооноос гаргасан санал, дүгнэлт тус бүрээр ил санал хураалт явуулж, хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх талаар тогтоол баталсанд тооцох бөгөөд уг тогтоолд зөвшөөрсөн, эс зөвшөөрсөн заалтыг тус тусад нь заах;

84.2.4.Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль зүйн болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл нэгдсэн хуралдаанд Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтээр эхэлж санал хураалгах бөгөөд энэ санал дэмжигдээгүй бол холбогдох Байнгын хорооны санал дэмжигдсэн гэж үзэх;

84.2.5.хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрөөгүй бол энэ тухай тогтоолыг Цэцэд хүргүүлэх.

84.3.Хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол ажлын 15 өдрийн дотор тухайн болон холбогдох бусад хууль, шийдвэрт зохих нэмэлт, өөрчлөлт оруулах.

84.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг, Засгийн газрын тогтоол, бусад шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ, сонгуулийн төв байгууллагын гаргасан шийдвэр Монгол Улсын Үндсэн хуульд нийцээгүй гэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хүлээн зөвшөөрсөн бол Цэцийн шийдвэрт хүчингүй болгох хугацааг тусгайлан заасан тохиолдолд тус хугацаанд, хугацаа тусгаагүй бол эдгээр шийдвэр хүчингүй болсонд тооцох.

84.5.Энэ хуулийн 84.4-т заасан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж, нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй.

84.6.Цэц Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1, 2-т заасан маргаантай асуудлаар Монгол Улсын Үндсэн хуульд нийцсэн гэсэн дүгнэлт гаргасан бол уг дүгнэлтийг Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр нэгдсэн хуралдаанд шууд танилцуулах бөгөөд санал хурааж шийдвэр гаргахгүй. Цэцийн дүгнэлттэй холбогдуулан гишүүд тухайн асуудалд томилогдсон итгэмжлэгдсэн төлөөлөгчөөс асуулт асууж, үг хэлж болно.

84.7.Онц болон дайны байдал зарласан, цэрэг хөдөлгөх тухай, гамшгаас хамгаалах өндөржүүлсэн эсхүл бүх нийтийн бэлэн байдалд шилжүүлсэн эрх бүхий байгууллага, албан тушаалтны шийдвэр нь Үндсэн хуульд нийцсэн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн Цэцийн дүгнэлтийг Улсын Их Хурал хойшлуулшгүй хэлэлцэнэ.

### **85 дугаар зүйл. Албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх**

85.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3-т заасан асуудлаар Цэц дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд ирүүлсэн бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:

85.1.1. Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороод хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

85.1.2. Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, гишүүн, Ерөнхий сайд, Засгийн газрын гишүүн, Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Монгол Улсын Үндсэн хууль зөрчөөгүй гэсэн дүгнэлт гаргасан бол энэ тухай дүгнэлтийг Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр нэгдсэн хуралдаанд шууд танилцуулах бөгөөд энэ тохиолдолд асуулт, хариулт, санал шүүмжлэл, санал хураалт явуулахгүй;

85.1.3. Улсын дээд шүүхийн Ерөнхий шүүгч, Улсын ерөнхий прокурор Монгол Улсын Үндсэн хууль зөрчөөгүй тухай дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулсан тухай Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид албан бичгээр мэдэгдэх;

85.1.4. нэгдсэн хуралдаан энэ хуулийн 85.1.2-т заасан албан тушаалтан Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэх;

85.1.5. нэгдсэн хуралдаанд гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх;

85.1.6. Монгол Улсын Үндсэн хуулийн зөрчилд холбогдсон албан тушаалтан санал хураахын өмнө Байнгын хорооны хуралдаанд 5 минутаас илүүгүй хугацаанд, нэгдсэн хуралдаанд 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх;

85.1.7. энэ хуулийн 85.1.4-т заасны дагуу гаргасан Байнгын хорооны саналаар ил санал хураалт явуулах бөгөөд хуралдаанд оролцсон гишүүдийн олонх Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрсөн бол тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах, эсхүл бусад хариуцлага хүлээлгэх асуудлыг энэ хууль болон холбогдох хуульд заасны дагуу шийдвэрлэх;

85.1.8. Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй бол Улсын Их Хурлаас шийдвэр гаргахгүй.

85.2. Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн гэсэн Цэцийн дүгнэлт гарсан бол нэгдсэн хуралдааныг олонхын бүлгээс сонгогдсон дэд дарга, бусад тохиолдолд Улсын Их Хурлын дарга даргалан хуралдуулна.

**86 дугаар зүйл. Албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах эсэх асуудлаар гаргасан Цэцийн дүгнэлтийг хэлэлцэх**

86.1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 4-т заасны дагуу Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэл байгаа эсэх асуудлаар Монгол Улсын Үндсэн хуулийн Цэц дүгнэлт гаргаж ирүүлсэн бол Улсын Их Хурал дараах журмаар хэлэлцэнэ:

86.1.1. Цэцийн дүгнэлтийг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороод хэлэлцэж санал, дүгнэлт гаргах;

86.1.2. Цэц энэ хуулийн 86.1-д заасан холбогдох албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах үндэслэлгүй гэсэн дүгнэлт гаргасан бол энэ тухай дүгнэлтийг Байнгын хороодын хуралдаанаар хэлэлцүүлэхгүйгээр нэгдсэн хуралдаанд шууд танилцуулах бөгөөд энэ тохиолдолд асуулт, хариулт, санал шүүмжлэл, санал хураалт явуулахгүй;

86.1.3. Цэц Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурлын дарга, Ерөнхий сайдыг огцруулах, Улсын Их Хурлын гишүүнийг эгүүлэн татах үндэслэлтэй гэсэн дүгнэлт гаргасан бол Улсын Их Хурлын нэгдсэн хуралдаанд Цэцийн дүгнэлттэй танилцсаны дараа дүгнэлтийг зөвшөөрөх эсэх асуудлаар Хууль зүйн болон Төрийн байгуулалтын байнгын хороодын гаргасан санал, дүгнэлтийг хэлэлцэх;

86.1.4. нэгдсэн хуралдаанд гишүүд Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлэх;

86.1.5. энэ хуулийн 86.1-д заасан албан тушаалтан санал хураахын өмнө Байнгын хорооны хуралдаанд 5 минутаас илүүгүй хугацаанд, нэгдсэн хуралдаанд 10 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх;

86.1.6. энэ хуулийн 86.1.3-т заасны дагуу гаргасан Байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэж, ил санал хураалт явуулах бөгөөд Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөхийг хуульд өөрөөр заагаагүй бол хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол тухайн албан тушаалтныг огцруулах, эгүүлэн татах тухай хууль эсхүл тогтоолыг хуульд өөрөөр заагаагүй бол ил санал хураалтаар батлах;

86.1.7. Цэцийн дүгнэлтийг хүлээн зөвшөөрөөгүй бол Улсын Их Хурлаас шийдвэр гаргахгүй.

86.2. Улсын Их Хурлын даргыг огцруулах үндэслэлтэй гэсэн Цэцийн дүгнэлт гарсан бол нэгдсэн хуралдааныг олонхын бүлгээс сонгогдсон дэд дарга даргалан хуралдуулна.

**87 дугаар зүйл. Монгол Улсын Үндсэн хуулийн Цэцийн тогтоолоор хууль, тогтоолын зарим зүйл, хэсэг, заалт хүчингүй болсонтой холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэх журам**

87.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу Цэцийн тогтоолоор хууль, тогтоолын зарим зүйл, хэсэг, заалтыг хүчингүй болгосон бол Улсын Их Хурал хууль, тогтоолд зохих нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг шийдвэрлэнэ.

87.2.Цэцийн тогтоолыг чуулганы үеэр хүлээн авсан бол ажлын 15 өдрийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш ажлын 15 өдрийн дотор холбогдох Байнгын хороо Цэцийн тогтоолтой холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах эсэх асуудлыг хэлэлцэнэ.

87.3.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах нь зүйтэй гэж үзвэл Байнгын хороо хууль, тогтоолд оруулах нэмэлт, өөрчлөлтийн төслийг боловсруулж, Байнгын хорооны санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд оруулна. Тухайн төслийн талаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй.

87.4.Нэгдсэн хуралдаанаар хууль, тогтоолын төсөлд нэмэлт, өөрчлөлт оруулах төслийг энэ хуульд заасан хууль, тогтоолын төслийг хэлэлцэх журмаар хэлэлцэж батална.

#### **88 дугаар зүйл.Цэцэд хүсэлт гаргах**

88.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар гишүүн Улсын Их Хурлаас Цэцэд хүсэлт гаргах саналыг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлбэл уг асуудлыг Хууль зүйн байнгын хороо ажлын 14 өдрийн дотор хуралдаанаараа хэлэлцэж саналд дурдсан асуудал нэг бүрээр санал хураан нэгдсэн хуралдаанд санал, дүгнэлтээ оруулна.

88.2.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 88.1-д заасан санал, дүгнэлт гарснаас хойш ажлын 7 өдрийн дотор хуралдаж асуудал нэг бүрээр Байнгын хорооны саналаар санал хураалт явуулах бөгөөд санал хураалтаар олонхын дэмжлэг авсан асуудлаар Цэцэд хүсэлт гаргахыг зөвшөөрсөн гэж үзнэ.

88.3.Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 88.2-т заасан асуудлаар хүсэлт гаргах тухай албан бичгийг Цэцэд хүргүүлнэ.

#### **89 дүгээр зүйл.Цэцийн хуралдаанд оролцох итгэмжлэгдсэн төлөөлөгч томилох, тайлбар гаргах**

89.1.Хууль, тогтоол Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн эсэх асуудлыг шийдвэрлэх хуралдаанд тайлбар авахаар ирүүлсэн Цэцийн албан бичгийг Улсын Их Хурлын дарга холбогдох Байнгын хороонд шилжүүлнэ.

89.2.Холбогдох Байнгын хорооны дарга Цэцийн хуралдаанд итгэмжлэгдсэн төлөөлөгчөөр оролцох гишүүний талаарх саналаа Улсын Их Хурлын даргад оруулна.

89.3.Улсын Их Хурлын дарга захирамж гаргаж итгэмжлэгдсэн төлөөлөгчийг томилно.

89.4.Итгэмжлэгдсэн төлөөлөгч тухайн маргаантай асуудлаар Цэцэд өгөх тайлбарыг бэлтгэхэд Байнгын хорооны дарга шаардлагатай гэж үзвэл энэ талаар Байнгын хорооны гишүүдийн саналыг авах, эсхүл Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцүүлж чиглэл өгч болно.

## **90 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг хэлэлцэх**

90.1.Хууль, тогтоолд Монгол Улсын Ерөнхийлөгч хориг тавьсан бол Улсын Их Хурал хоригийг чуулганы үеэр ажлын 14 өдрийн дотор, чуулганы чөлөө цагт хориг тавьсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 10 хоногийн дотор хэлэлцэн шийдвэрлэж тогтоол батална.

90.2.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг тухайн асуудлыг анх хэлэлцэж санал, дүгнэлт гаргасан холбогдох Байнгын хороо болон Хууль зүйн байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

90.3.Нэгдсэн хуралдаанд хоригийг Монгол Улсын Ерөнхийлөгч, эсхүл түүний итгэмжлэгдсэн төлөөлөгч танилцуулсны дараа энэ хуулийн 90.2-т заасан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсоно.

90.4.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Монгол Улсын Ерөнхийлөгчийн хориг болон Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

90.5.Гишүүд энэ хуулийн 90.4-т заасны дагуу үг хэлсний дараа Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авах эсэх асуудлаар ил санал хураалт явуулах бөгөөд хэрэв хууль, тогтоолын зарим хэсэгт хориг тавьсан бол тухайн зүйл, хэсэг, заалт нэг бүрээр санал хураалт явуулж дүнг танилцуулах бөгөөд хоригийг шийдвэрлэсэн талаарх Улсын Их Хурлын тогтоол баталсанд тооцно.

90.6.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн гуравны хоёр буюу 66.6 хувь нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж аваагүй бол хууль, тогтоол хүчин төгөлдөр үлдэнэ.

90.7.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийн талаар Хууль зүйн болон холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлт зөрвөл холбогдох Байнгын хорооны саналаар эхэлж санал хураалт явуулна.

90.8.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээн авсан бол хууль, тогтоолыг бүхэлд нь буюу зарим хэсгийг нь хүчингүй болгох, шаардлагатай гэж үзвэл зохих нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хууль, тогтоолын төслийг хэлэлцэн баталж болно.

90.9.Монгол Улсын Ерөнхийлөгчийн хоригийг хүлээж авсантай холбогдуулан хууль, тогтоолд нэмэлт, өөрчлөлт оруулах бол тухайн шийдвэрийн төслийг холбогдох Байнгын хороо боловсруулж нэгдсэн хуралдаанд оруулах бөгөөд уг төслийн талаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагаас санал авахыг шаардахгүй.

## **91 дүгээр зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн үйл ажиллагааны танилцуулгыг сонсох**

91.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Гучин тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд ажлаа хариуцна.

91.2.Монгол Улсын Ерөнхийлөгч үйл ажиллагааныхаа талаарх танилцуулгыг жил бүрийн нэгдүгээр улиралд багтаан Улсын Их Хуралд ирүүлэх бөгөөд уг танилцуулгыг ээлжит чуулган эхэлснээс хойш нэгдсэн хуралдаанаар 1 сарын дотор сонсоно.

91.3.Монгол Улсын Ерөнхийлөгчийн танилцуулгатай холбогдуулж гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

## **92 дугаар зүйл.Онц болон дайны байдал зарлах, цуцлах тухай асуудлыг хэлэлцэх**

92.1.Онц болон дайны байдал зарлах тухай асуудлыг Онц байдлын тухай хуулийн<sup>11</sup> 5, 6, 7 дугаар зүйл, Дайны байдлын тухай хуулийн<sup>12</sup> 5, 6 дугаар зүйлд заасныг тус тус баримтлан нэгдсэн хуралдаанаар хэлэлцэнэ.

92.2.Улсын Их Хурлын ээлжит болон ээлжит бус чуулган хуралдаж байх үед онц болон дайны байдал зарлах онцгой нөхцөл үүсвэл тухайн чуулганаар хэлэлцэх асуудлын дарааллыг үл харгалзан онц болон дайны байдал зарлах тухай асуудлыг эхний ээлжид хэлэлцэн шийдвэрлэнэ.

92.3.Онц болон дайны байдал зарлах тухай Монгол Улсын Ерөнхийлөгчийн зарлиг батлах, эсхүл хүчингүй болгох асуудлыг хэлэлцэхэд уг асуудлыг нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгч танилцуулна.

92.4.Онц байдал зарлах тухай хуулийн төслийг Улсын Их Хурлын нийт гишүүдийн дөрөвний нэгээс доошгүй гишүүд санаачлан Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол уг асуудлыг нэгдсэн хуралдаанд хууль санаачилсан гишүүн танилцуулж, энэ хуулийн 92.1-д заасан дэгийн дагуу хэлэлцэнэ.

## **93 дугаар зүйл.Улсын Их Хурал тарах асуудлыг хэлэлцэх**

93.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Хорин хоёрдугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэж Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь, эсхүл мөнхүү шалтгаанаар Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлын даргатай зөвшилцөж, Улсын Их Хурал нэгэн бүрэн эрхийн хугацаанаасаа өмнө тарах саналыг Улсын Их Хуралд өргөн мэдүүлнэ.

93.2.Энэ хуулийн 93.1-д заасан саналыг ээлжит чуулганы үеэр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол ажлын 3 өдрийн дотор Халдашгүй байдлын дэд хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо тус тус хуралдаж хэлэлцэнэ.

93.3.Халдашгүй байдлын дэд хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд оруулж хэлэлцүүлнэ.

<sup>11</sup> Онц байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1996 оны 2 дугаарт нийтлэгдсэн.

<sup>12</sup> Дайны байдлын тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 1998 оны 6 дугаарт нийтлэгдсэн.

93.4.Нэгдсэн, Байнгын, дэд хорооны хуралдаанд энэ хуулийн 93.1-д заасан саналыг гаргасан аль нэг гишүүн, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч саналаа 10 минутад багтаан танилцуулна.

93.5.Нам, эвслийн бүлэг энэ асуудлаар санал, дүгнэлт гаргасан бол нэгдсэн хуралдаанд 5 минутад багтаан танилцуулна.

93.6.Гишүүн өргөн мэдүүлсэн санал болон нам, эвслийн бүлгийн санал, дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

93.7.Асуулт асуух, түүнд хариулах, үг хэлэх хугацаа тус бүр 5 минутаас илүүгүй байна.

93.8.Гишүүд үг хэлж дууссаны дараа Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэсэн саналаар ил санал хураалт явуулна.

93.9.Улсын Их Хурлын нийт гишүүний гуравны хоёроос доошгүй нь Улсын Их Хурал бүрэн эрхээ хэрэгжүүлэх боломжгүй гэсэн саналыг дэмжсэн бол Улсын Их Хурал өөрөө тарах тухай тогтоол баталсанд тооцно.

93.10.Энэ хуулийн 93.1-д заасан саналыг ээлжит чуулганы чөлөө цагт Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн бол Улсын Их Хурлын дарга тухайн саналыг өргөн мэдүүлснээс хойш 3 хоногийн дотор ээлжит бус чуулганыг товлон зарлаж энэ хуульд заасны дагуу хэлэлцүүлнэ.

#### **94 дүгээр зүйл.Ээлжит бус сонгууль товлон зарлах**

94.1.Улсын Их Хурал өөрөө тарах шийдвэр гаргасан, эсхүл Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлыг тараах тухай шийдвэр гаргаснаас хойш 10 хоногийн дотор ээлжит бус сонгуулийг товлон зарлана.

94.2.Улсын Их Хурлын дарга энэ хуулийн 93.1-д заасан Улсын Их Хурал тарах, эсхүл Улсын Их Хурлыг тараах шийдвэр гарснаас хойш 1 хоногийн дотор ээлжит бус сонгуулийг товлон зарлах асуудлыг хэлэлцэх Байнгын хорооны болон нэгдсэн хуралдааны товыг тогтоож захирамж гаргана.

94.3.Төрийн байгуулалтын байнгын хороо ээлжит бус сонгууль товлон зарлах, сонгуулийн зардал, санал хураах өдрийг тус тус хэлэлцэж, тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд оруулна.

94.4.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 94.3-т заасан асуудлыг хэлэлцэж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар шийдвэрлэнэ.

#### **95 дугаар зүйл.Нийтийн ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар гаргасан иргэдийн өргөдлийг хэлэлцэх**

95.1.Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39 дүгээр зүйлд заасны дагуу нийтийн ашиг сонирхлыг хөндсөн тодорхой асуудлаар гаргасан иргэдийн өргөдөл /цаашид "нийтийн өргөдөл" гэх/-ийг Улсын Их Хурлаас тусгайлан ажиллуулсан санал хүлээн авах цахим системд 30 хоногийн хугацаатай байршуулна.

95.2.Цахим системд байршуулсан нийтийн өргөдлийг Монгол Улсын 18 насанд хүрсэн иргэдийн дэмжсэн санал Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 39.4-т заасан тоонд хүрсэн тохиолдолд Улсын Их Хурал авч хэлэлцэнэ.

95.3.Нийтийн өргөдлийг дэмжсэн иргэдийн санал энэ хуулийн 90.2-т заасан тоонд хүрмэгц Улсын Их Хурлын дарга саналыг хэлэлцүүлж шийдвэрлүүлэхээр холбогдох Байнгын хороонд ажлын таван өдрийн дотор хуваарилж, нэгдсэн хуралдаанд танилцуулна.

95.4.Холбогдох Байнгын хороо саналыг чуулганы үеэр хүлээн авсан бол 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 7 хоногийн дотор хэлэлцэж эхэлнэ.

95.5.Байнгын хороо тухайн саналыг хэлэлцэж эхэлснээс хойш 3 сарын дотор дараах байдлаар шийдвэрлэж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд танилцуулна:

95.5.1.холбогдох бодлогын баримт бичиг, хууль, тогтоолын төсөл боловсруулах асуудлаар Засгийн газарт чиглэл өгөх;

95.5.2.хууль, тогтоолын хэрэгжилтийг хангуулах, зөрчлийг арилгуулах асуудлаар Засгийн газар, холбогдох бусад байгууллагад чиглэл өгөх;

95.5.3.Байнгын хорооны эрхлэх асуудлын хүрээнд хяналт шалгалт явуулах;

95.5.4.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 13.1.11-д заасан асуудлаар санал гаргах;

95.5.5.олон нийтийн хэлэлцүүлэг, Улсын Их Хурлын хяналтын сонсгол зохион байгуулах.

95.6.Шаардлагатай тохиолдолд энэ хуулийн 95.1-д заасан асуудлаар санал гаргасан иргэдийн төлөөлөл болон холбогдох салбарын мэргэжилтнүүдийг Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд байлцуулж болно.

95.7.Гишүүн нийтийн өргөдөлд хамаарах асуудлаар холбогдох хуулийн төсөл санаачилж болох ба Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан хүрээ, хязгаарыг баримтална.

95.8.Энэ хуулийн 95.5-д заасан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсох ажиллагааг сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар энэ хуулийн 112.1-д заасан Ерөнхий сайдын мэдээллийн дараа нэг цагийн хугацаанд багтаан зохион байгуулна.

95.9.Энэ хуулийн 95.7-д заасны дагуу Байнгын хорооны санал, дүгнэлттэй танилцсаны дараа гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

**АРВАН ХОЁРДУГААР БҮЛЭГ  
АЛБАН ТУШААЛТНЫ БҮРЭН ЭРХИЙГ ХҮЛЭЭН  
ЗӨВШӨӨРӨХ, ТОМИЛОХ, ЧӨЛӨӨЛӨХ, ОГЦРУУЛАХ,  
ЭГҮҮЛЭН ТАТАХ АСУУДЛЫГ ХЭЛЭЛЦЭХ ЖУРАМ**

**96 дугаар зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн**



## **зөвшөөрөх тухай асуудлыг хэлэлцэх**

96.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрүүлэх тухай асуудлыг Сонгуулийн ерөнхий хорооны дарга Улсын Их Хуралд өргөн мэдүүлснээс хойш ажлын 5 өдрийн дотор Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлаар дүгнэлт гаргана.

96.2.Нэгдсэн хуралдаан Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлт гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор хэлэлцэж, Монгол Улсын Ерөнхийлөгчийн бүрэн эрхийг хүлээн зөвшөөрөх тухай хуулийг дараах журмаар гаргана:

96.2.1.Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуулийн дүнгийн тухай Сонгуулийн ерөнхий хорооны даргын илтгэлийг сонсох;

96.2.2.Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлтийг сонсох;

96.2.3.Төрийн байгуулалтын байнгын хорооны саналаар ил санал хураалт явуулах;

96.2.4.Монгол Улсын Ерөнхийлөгчийн анхан шатны сонгуульд оролцсон нийт сонгогчийн олонхын санал авсан нэр дэвшигчийг Монгол Улсын Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн тухай хууль гаргах.

96.3.Төрийн байгуулалтын байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Сонгуулийн ерөнхий хорооны даргын илтгэл, Төрийн байгуулалтын байнгын хорооны дүгнэлттэй холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

## **97 дугаар зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хуралд тангараг өргөх**

97.1.Шинээр сонгогдсон Ерөнхийлөгч нь Улсын Их Хурал Ерөнхийлөгчөөр сонгогдсон гэж үзэж бүрэн эрхийг нь хүлээн зөвшөөрсөн хууль гаргаснаас хойш 30 хоногийн дотор Улсын Их Хуралд тангараг өргөнө.

97.2.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын Их Хурлаас товлосон өдөр, цагт Монгол Улсын Үндсэн хуульд заасны дагуу Улсын Их Хуралд тангараг өргөнө.

97.3.Тангараг өргөх ёслолын ажиллагааг Төрийн ордонд зохион байгуулна.

97.4.Ерөнхийлөгчийн тангараг өргөх ёслолын ажиллагааны бэлтгэл ажлыг ханган зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг Улсын Их Хурлын даргын захирамжаар байгуулна.

## **98 дугаар зүйл.Монгол Улсын Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, огцруулах асуудлыг хэлэлцэх**

98.1.Монгол Улсын Ерөнхийлөгч эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхийн хугацаанаасаа өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ Улсын Их Хуралд гаргасан бол Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг ажлын 5 өдрийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд танилцуулна.

98.2.Нэгдсэн хуралдаанаар Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлтийг ажлын 5 өдрийн дотор хэлэлцэн ил санал хураалт явуулж, чөлөөлөгдөх хүсэлтийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонх дэмжсэн бол Монгол Улсын Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай хууль баталсанд тооцно.

98.3.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Ерөнхийлөгчийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх шалтгаан, үндэслэлийн талаар гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

98.4.Монгол Улсын Ерөнхийлөгч Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн, эсхүл огцруулах үндэслэлтэй байна гэсэн Цэцийн дүгнэлтийг үндэслэн Монгол Улсын Ерөнхийлөгчийг огцруулах эсэх асуудлыг энэ хуулийн 86, 87 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

98.5.Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны саналаар ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон Улсын Их Хурлын нийт гишүүний дийлэнх олонх дэмжсэн бол Монгол Улсын Ерөнхийлөгчийг огцруулах тухай хууль баталсанд тооцно.

98.6.Нэгдсэн хуралдаанд оролцсон нийт гишүүний дийлэнх олонх Монгол Улсын Ерөнхийлөгчийг огцруулах саналыг дэмжээгүй бол уг асуудлаар шийдвэр гарахгүй.

#### **99 дүгээр зүйл.Ерөнхий сайдыг томилох асуудлыг хэлэлцэх**

99.1.Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэг, Дөчин дөрөвдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулсан, эсхүл огцорсонд тооцсон бол шинэ Ерөнхий сайдыг томилох асуудлыг энэ хуулийн 26 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

#### **100 дугаар зүйл.Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх асуудлыг хэлэлцэх**

100.1.Ерөнхий сайд эрүүл мэндийн болон хүндэтгэн үзэх бусад шалтгаанаар бүрэн эрхийн хугацаанаас өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ өөрөө гаргасан бол Төрийн байгуулалтын байнгын хороо уг асуудлыг 7 хоногийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргана.

100.2.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 100.1-д заасан хүсэлтийг Төрийн байгуулалтын байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш 7 хоногийн дотор хэлэлцэн ил санал хураалт явуулах бөгөөд чөлөөлөгдөх хүсэлтийг нь хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Ерөнхий сайдыг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай тогтоол баталсанд тооцно.

100.3.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайдаас чөлөөлөгдөх шалтгаан, үндэслэлийн талаар гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

#### **101 дүгээр зүйл.Ерөнхий сайдыг огцруулах асуудлыг хэлэлцэх**

101.1.Гишүүд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин гуравдугаар зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу Ерөнхий сайдыг огцруулах саналыг Улсын Их Хуралд албан ёсоор тавьсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

101.2.Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхий сайдыг огцруулах саналыг хуралдаанаараа хэлэлцэж санал, дүгнэлт гарган нэгдсэн хуралдаанд танилцуулна.

101.3.Нэгдсэн хуралдаан Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, ил санал хураалт явуулна.

101.4.Улсын Их Хурлын нийт гишүүний олонх Ерөнхий сайдыг огцруулах саналыг дэмжсэн бол Ерөнхий сайдыг огцруулах тухай тогтоол баталсанд тооцно. Ерөнхий сайдыг огцруулах саналыг дэмжээгүй бол уг асуудлаар шийдвэр гарахгүй.

101.5.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

101.6.Нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргасан бол 5 минутад багтаан нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

101.7.Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд үг хэлж болно.

101.8.Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хууль зөрчсөн, эсхүл Ерөнхий сайдыг огцруулах үндэслэлтэй гэж Цэц дүгнэлт гаргасан бол энэ хуулийн 85, 86 дугаар зүйлд заасны дагуу хэлэлцэн шийдвэрлэнэ.

## **102 дугаар зүйл.Ерөнхий сайдад тодорхой асуудлаар итгэл хүлээлгэх эсэх асуудлыг хэлэлцэх**

102.1.Ерөнхий сайд Монгол Улсын Үндсэн хуулийн Дөчин дөрөвдүгээр зүйлд заасны дагуу өөрт нь итгэл хүлээлгэх тогтоолын төслийг оруулсан бол Улсын Их Хурал уг асуудлыг 7 хоногийн дараа хэлэлцэж эхлэн түүнээс хойш 10 хоногийн дотор шийдвэрлэнэ.

102.2.Холбогдох Байнгын хороо, Төрийн байгуулалтын байнгын хороо Ерөнхий сайдад итгэл хүлээлгэх тогтоолын төслийг хуралдаанаараа хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна.

102.3.Энэ хуулийн 102.1-д заасан тогтоолын төслийг Улсын Их Хурлын нийт гишүүний олонхын саналаар баталсан бол Ерөнхий сайдад итгэл үзүүлж, тухайн асуудлыг дэмжсэнд тооцно. Тогтоолын төслийг батлаагүй бол Ерөнхий сайдыг огцорсонд тооцож, энэ тухай тогтоол баталсанд тооцно.

102.4.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

102.5.Нам, эвслийн бүлэг санал, дүгнэлт гаргасан бол 5 минутад багтаан нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

102.6.Монгол Улсын Ерөнхийлөгч, Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд үг хэлж болно.

102.7.Ерөнхий сайдад итгэл үзүүлэх тогтоолыг баталсантай холбогдуулан шаардлагатай бол уг тогтоолд нийцүүлэн зохих хууль, бодлого, төлөвлөлтийн

баримт бичгийн төсөлд өөрчлөлт оруулах асуудлыг Улсын Их Хурал энэ хуульд заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

### **103 дугаар зүйл.Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, огцруулах, томилох талаар Улсын Их Хуралд танилцуулах журам**

103.1.Ерөнхий сайд Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, огцруулах, түүнтэй холбогдуулан шинээр томилох асуудлыг Улсын Их Хуралд танилцуулах тухайгаа Улсын Их Хурлын даргад мэдэгдэж товыг тогтоолгоно.

103.2.Засгийн газрын гишүүнийг чөлөөлөх, огцруулах, томилох асуудлыг нэгдсэн хуралдаанд танилцуулах бөгөөд гишүүд Ерөнхий сайд болон томилогдох этгээдээс асуулт асууж, үг хэлж болно.

103.3.Энэ хуулийн 103.1-д заасан асуудлаар Улсын Их Хурлаас аливаа шийдвэр гаргахгүй.

### **104 дүгээр зүйл.Цэцийн гишүүнийг томилох асуудлыг хэлэлцэх журам**

104.1.Монгол Улсын Ерөнхийлөгч, Улсын Их Хурал, Улсын дээд шүүхээс Цэцийн гишүүнээр томилуулахаар нэр дэвшүүлсэн саналыг хүлээн авснаас хойш энэ хуульд заасан журмын дагуу нэр дэвшигчийн сонгол зохион байгуулна. Хууль зүйн байнгын хороо нэр дэвшигчийн сонголын тайлан гарснаас хойш ажлын таван өдрийн дотор тухайн тайлан, эрх бүхий этгээдийн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

104.2.Нэгдсэн хуралдаан Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлт гарснаас хойш ажлын 5 өдрийн дотор хуралдаж нэр дэвшүүлсэн байгууллагын танилцуулга, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож нэр дэвшигч тус бүрээр ил санал хураалт явуулж олонхын санал авсан нэр дэвшигчийг Цэцийн гишүүнээр томилох тухай тогтоол баталсанд тооцно.

104.3.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд нэр дэвшүүлсэн байгууллага болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

### **105 дугаар зүйл.Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх, эгүүлэн татах асуудлыг хэлэлцэх**

105.1.Цэцийн гишүүн бүрэн эрхийн хугацаа дуусахаасаа өмнө чөлөөлөгдөх хүсэлтээ анх илгээсэн байгууллагаар уламжлан гаргасныг, эсхүл Төрийн албаны тухай хуульд<sup>13</sup> заасан төрийн алба хаах насны дээд хязгаарт хүрсэнтэй холбогдуулж гишүүнийг чөлөөлүүлэх саналыг анх илгээсэн байгууллага Улсын Их Хуралд ирүүлсэн бол Хууль зүйн байнгын хороо энэ асуудлыг 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор хэлэлцэн санал, дүгнэлт гаргаж нэгдсэн хуралдаанд оруулна.

105.2.Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанаар 7 хоногийн дотор хэлэлцэн ил санал хураалт явуулах бөгөөд чөлөөлөх асуудлыг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх тухай тогтоол баталсанд тооцно.

<sup>13</sup> Төрийн албаны тухай хууль "Төрийн мэдээлэл" эмхэтгэлийн 2018 оны 1 дугаарт нийтлэгдсэн.

105.3.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд Цэцийн гишүүнийг үүрэгт ажлаас нь чөлөөлөх шалтгаан, үндэслэлийн талаар гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

105.4.Цэцийн гишүүнийг эгүүлэн татах бол энэ талаар гарсан Цэцийн шийдвэр, анх нэр дэвшүүлсэн байгууллагын саналыг энэ хуульд заасан журмаар хэлэлцэн шийдвэрлэнэ.

#### **106 дугаар зүйл.Улсын дээд шүүхийн шүүгчид нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулах журам**

106.1.Улсын дээд шүүхийн шүүгчийн сонгон шалгаруулалтад тэнцсэн нэр дэвшигчийн танилцуулгыг Шүүхийн ерөнхий зөвлөл Улсын Их Хуралд ирүүлнэ.

106.2.Танилцуулгыг ирүүлснээс хойш 7 хоногийн дотор, чуулганы чөлөө цагт ирүүлсэн бол ээлжит болон ээлжит бус чуулган эхэлснээс хойш 5 хоногийн дотор нэр дэвшигчийг Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд танилцуулна.

106.3.Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын дарга нэр дэвшигчийг Улсын Их Хуралд танилцуулсан талаар Шүүхийн ерөнхий зөвлөлд албан бичгээр мэдэгдэнэ.

106.4.Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Шүүхийн ерөнхий зөвлөлийн дарга болон нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

106.5.Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд нэр дэвшигчийн талаар санал хураалт явуулахгүй.

#### **107 дугаар зүйл.Улсын ерөнхий прокурор, түүний орлогчийг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх**

107.1.Монгол Улсын Ерөнхийлөгч Улсын ерөнхий прокурор, түүний орлогч нарыг томилохын өмнө зөвшилцөхөөр Улсын Их Хуралд саналаа ирүүлнэ.

107.2.Холбогдох байнгын хороо энэ хуульд заасан журмын дагуу явуулсан нэр дэвшигчийн сонсголын тайлан гарснаас хойш ажлын таван өдрийн дотор тухайн тайлан, Ерөнхийлөгчийн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана.

107.3.Нэгдсэн хуралдаан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг хэлэлцэн ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.

107.4.Нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тухайн нэр дэвшигчийг дэмжээгүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч өөр хүнийг нэр дэвшүүлэхээр санал болгоно.

107.5.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулж, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

**108 дугаар зүйл.Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг хэлэлцэх журам**

108.1.Улсын Их Хурал Шүүхийн ерөнхий зөвлөл, Шүүхийн сахилгын хорооны гишүүнийг нэр дэвшүүлж, томилох, чөлөөлөх, огцруулах асуудлыг Монгол Улсын шүүхийн тухай хуульд заасан журмыг баримтлан хэлэлцэнэ.

108.2.Хууль зүйн байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигч болон холбогдох бусад этгээдээс асуулт асууж, үг хэлж болно.

108.3.Нэгдсэн хуралдаан Хууль зүйн байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, ил санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх, огцруулах саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.

108.4.Хууль зүйн байнгын хороо хуульд заасны дагуу санал болгосон нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно.

**109 дүгээр зүйл.Гадаад улсад суух бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх**

109.1.Монгол Улсын Ерөнхийлөгч гадаад улсад суух элчин сайд, бүрэн эрхт төлөөлөгчийн газрын тэргүүнийг томилох, эгүүлэн татах саналыг Улсын Их Хуралд зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол тухайн саналыг ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлнэ.

109.2.Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо энэ хуулийн 109.1-д заасан саналыг Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлснээс хойш ажлын гурван өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Хэрэв нэр дэвшигчийн сонсгол явуулах санал гарсан бол сонсголын тайлан гаргаснаас хойш ажлын таван өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Санал, дүгнэлтэд сонсголын тайланг хавсаргана.

109.3.Нэгдсэн хуралдаан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож, ил санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.

109.4.Нэр дэвшигч нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг авч чадаагүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

109.5.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

109.6.Энэ хуулийн 109.1-д заасан нэр дэвшигчийн сонсгол явуулахаар бол Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо Нийтийн сонсголын тухай хуулийн 6.3-т заасан үндэслэлээр сонсголыг хаалттай явуулж болно.

## **110 дугаар зүйл.Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөх**

110.1.Монгол Улсын Ерөнхийлөгч Зэвсэгт хүчний жанжин штабын даргыг томилох саналыг Улсын Их Хуралтай зөвшилцөхөөр өргөн мэдүүлсэн бол тухайн саналыг 72 цагийн дотор гишүүдэд хүргүүлнэ. Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороо ийнхүү хүргүүлснээс хойш ажлын гурван өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж, санал, дүгнэлт гаргана. Хэрэв нэр дэвшигчийн сонсгол явуулах санал гарсан бол сонсголын тайлан гаргаснаас хойш ажлын таван өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Санал, дүгнэлтэд сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.

110.2.Нэгдсэн хуралдаан Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсон нууц санал хураалт явуулж, дүнг Улсын Их Хурлын дарга Монгол Улсын Ерөнхийлөгчид бичгээр мэдэгдэнэ.

110.3.Нэр дэвшигч нэгдсэн хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг авч чадаагүй бол Монгол Улсын Ерөнхийлөгч өөр хүний нэрийг дэвшүүлнэ.

110.4.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд Монгол Улсын Ерөнхийлөгчийн санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

## **111 дүгээр зүйл.Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх асуудлыг хэлэлцэх журам**

111.1.Хууль тогтоомжоор эрх олгогдсон этгээд Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын эрх бүхий албан тушаалтныг томилох, чөлөөлөх санал гаргасан бол тухайн саналыг 72 цагийн дотор Улсын Их Хурлын гишүүдэд хүргүүлнэ. Холбогдох Байнгын хороо ийнхүү хүргүүлснээс хойш ажлын гурван өдрийн дараа тухайн саналыг хэлэлцэж санал, дүгнэлт гаргана. Хуульд заасны дагуу, эсхүл гишүүдийн саналаар нэр дэвшигчийн сонсгол явуулсан бол сонсголын тайлан гаргаснаас хойш ажлын таван өдрийн дотор Байнгын хороо хэлэлцэж санал, дүгнэлтдээ тухайн тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр тусгана.

111.2.Нэгдсэн хуралдаан эрх бүхий албан тушаалтны санал, холбогдох Байнгын хорооны санал, дүгнэлтийг сонсож нууц санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонх томилох, чөлөөлөх саналыг дэмжсэн бол энэ тухай тогтоол баталсанд тооцно.

111.3.Томилогдох нэр дэвшигч хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын дэмжлэг авч чадаагүй бол эрх бүхий албан тушаалтан өөр хүнийг нэр дэвшүүлэхээр санал болгох бөгөөд чөлөөлөх саналыг дэмжээгүй бол уг саналыг дахин оруулж болно.

111.4.Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанд гишүүд эрх бүхий албан тушаалтны санал, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан, түүнчлэн нэр дэвшигчээс асуулт асууж, үг хэлж болно.

111.5.Хуульд заасны дагуу албан тушаалд томилуулах саналыг Улсын Их Хурал, Байнгын хороо, Улсын Их Хурлын дарга гаргах, нэр дэвшүүлэх бол холбогдох хуульд заасан журам, шаардлага, шалгуурыг үндэслэнэ.

111.6.Байнгын хороо хуульд заасны дагуу албан тушаалд томилуулахаар нэр дэвшүүлэхдээ гишүүдээс санал болгосон нэр дэвшигч нэг бүрээр санал хураалт явуулж хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар нэр дэвшүүлэхийг дэмжсэнд тооцно.

## **АРВАН ГУРАВДУГААР БҮЛЭГ ЕРӨНХИЙ САЙДЫН МЭДЭЭЛЭЛ, ГИШҮҮНИЙ АСУУЛГА, АСУУЛТЫН ХАРИУГ СОНСОХ**

### **112 дугаар зүйл.Ерөнхий сайд нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх**

112.1.Хууль тогтоомж, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, тухайн жилийн төсөв, жилийн төлөвлөгөөний хэрэгжилт, улс орны эдийн засаг, нийгэм, санхүүгийн төлөв байдал болон бусад асуудлаар Ерөнхий сайд сар бүрийн сүүлийн долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанд мэдээлэл хийх буюу Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдийн асуултад хариулна.

112.2.Ээлжит чуулганы хугацаанд Ерөнхий сайдын хийх мэдээллийн нэгдсэн сэдвийн жагсаалтыг тухайн ээлжит чуулган эхлэхээс 7-оос доошгүй хоногийн өмнө Улсын Их Хурлын даргад, Ерөнхий сайдын хийх мэдээллийг нэгдсэн хуралдаанаар сонсохоос 7 хоногийн өмнө Улсын Их Хурал дахь цөөнхийн гишүүдэд тус тус бичгээр ирүүлнэ.

112.3.Ерөнхий сайдын мэдээллийг Байнгын хороодын хуралдаанаар урьдчилан хэлэлцэхгүй.

112.4.Ерөнхий сайдын мэдээллийг нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд өөрөө хийх ба холбогдох Засгийн газрын гишүүдийг байлцуулна.

112.5.Нэгдсэн хуралдаанд Ерөнхий сайд 25 минутад багтаан мэдээлэл хийх бөгөөд Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан цөөнхийн төлөөлөл 25 минутад багтаан үг хэлнэ.

112.6.Энэ хуулийн 112.5-д заасны дагуу Ерөнхий сайд мэдээлэл хийж, цөөнхийн төлөөлөл үг хэлсний дараа цөөнхийн төлөөлөл тус бүр Ерөнхий сайдаас асуулт асууж, үг хэлж болох бөгөөд асуулт асууж, үг хэлэх хугацаа 3 минутаас, хариулт өгөх хугацаа 5 минутаас тус тус хэтрэхгүй.

112.7.Ерөнхий сайдын мэдээлэлтэй холбогдуулан асуулт асууж, хариулт авах, үг хэлэх нийт хугацаа 1 цаг 30 минутаас хэтрэхгүй.

112.8.Цаг үеийн шинжтэй тулгамдсан асуудлаар Ерөнхий сайд мэдээлэл хийх шаардлагатай гэж үзвэл энэ зүйлд зааснаас өөр цаг, өдөрт хийж болно.

112.9.Энэ хуулийн 112.2-т заасан мэдээллийг ирүүлмэгц сэдвийг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст тав хоногийн хугацаанд иргэдээс асуулт асуухаар байршуулна.

112.10.Энэ хуулийн 112.9-д заасан цахим хуудаст иргэдээс ирүүлсэн асуултыг Тамгын газар нэгтгэж нам, эвслийн бүлгүүдэд хүргүүлнэ.



112.11.Энэ хуулийн 112.10-т заасан асуултыг нам, эвслийн бүлэг ангилан багцалж, нам, эвслийн бүлэг тус бүрээс нэг гишүүн төлөөлж Ерөнхий сайдаас асуулт асууж, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно. Асуулт, хариултыг цөөнхийн төлөөлөл эхлүүлнэ.

112.12.Энэ хуулийн 112.11-д заасан хугацаа нь энэ хуулийн 112.7-д заасан хугацаанд хамаарахгүй.

112.13.Иргэдийн асуултад Ерөнхий сайд энэ хуулийн 112.11-д заасан хугацаанд багтааж хариулт өгөөгүй бол хариултыг 3 хоногийн дотор Улсын Их Хурлын Тамгын газарт бичгээр ирүүлнэ. Тамгын газар бичгээр ирүүлсэн хариуг энэ хуулийн 112.10-т заасан цахим хуудсанд байршуулна.

### **113 дугаар зүйл.Гишүүний асуулгын хариуг хэлэлцэх**

113.1.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуулгын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд дараах журмыг баримтална:

113.1.1.Байнгын хорооны хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 3 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух;

113.1.2.холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулга тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, асуулгатай холбоотой өөр асуулт асуух.

113.2.Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж болно.

113.3.Гишүүний асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэхэд дараах журмыг баримтална:

113.3.1.Улсын Их Хурлын дарга нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлэх тов, дарааллыг Зөвлөлийн саналыг харгалзан тогтоох;

113.3.2.асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэхэд тухайн асуудлыг хариуцан хэлэлцүүлэх Засгийн газрын гишүүнийг Ерөнхий сайд Улсын Их Хурлын даргад урьдчилан мэдэгдэх;

113.3.3.нэгдсэн хуралдаанд асуулгын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах ба гишүүд асуулгын хариутай холбогдуулж асуулт асуух хугацаа 3 минутаас илүүгүй байх бөгөөд хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, түүнд хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байх;

113.3.4.асуулгад хариулт өгсний дараа асуулга тавьсан гишүүн 1 удаа 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх.

113.4.Асуулгын хариуг ээлжит чуулганы үеэр сар бүрийн 2, 4 дэх долоо хоногийн Баасан гарагийн үдээс хойших нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх бөгөөд шаардлагатай бол Баасан гарагийн үдээс өмнөх хуралдаанд хэлэлцэж болно.

113.5.Гишүүний тавьсан асуулгын хариуг нэгдсэн хуралдаанаар хэлэлцэх үед ижил сэдвийн хүрээнд тавигдсан бусад асуулгын хариуг нэгтгэн хэлэлцүүлж болно.

113.6.Нэгдсэн хуралдаан асуулгын хариуг хэлэлцээд Улсын Их Хурлаас тодорхой шийдвэр гаргах шаардлагатай гэж үзвэл холбогдох Байнгын хороонд энэ талаар чиглэл өгнө.

113.7.Холбогдох Байнгын хороо энэ хуулийн 113.6-д зааснаар нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу хууль, тогтоолын төсөл боловсруулж, санал, дүгнэлтээ нэгдсэн хуралдаанд оруулна.

#### **114 дүгээр зүйл.Гишүүний асуултын хариуг хэлэлцэх**

114.1.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар асуултын хариуг хэлэлцүүлэхээр бичгээр саналаа ирүүлснээс хойш 10 хоногийн дотор Байнгын хороо хуралдаанаар хэлэлцүүлэх бөгөөд дараах журмыг баримтална:

114.1.1.Байнгын хорооны хуралдаанд асуултын хариуг холбогдох албан тушаалтан 5 минутаас илүүгүй хугацаанд танилцуулах бөгөөд гишүүд 3 минутаас илүүгүй хугацаанд асуулт асуух, хариулт, тайлбар хангалтгүй гэж тухайн гишүүн үзвэл 1 минутаас илүүгүй хугацаагаар нэмэлт асуулт асууж, тайлбар авах, хариулах хугацаа 1 минутаас илүүгүй байх;

114.1.2.холбогдох албан тушаалтан асуултад хариулсны дараа асуулт тавьсан гишүүн 5 минутаас илүүгүй хугацаанд үг хэлэх, тавьсан асуулттайгаа холбоотой өөр асуулт асуух.

114.2.Гишүүний асуултын хариуг хэлэлцэх ажиллагааг олон нийтэд мэдээлнэ.

### **АРВАН ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ ЗАСГИЙН ГАЗАР, ХОЛБОГДОХ БУСАД БАЙГУУЛЛАГЫН ТАЙЛАН, МЭДЭЭЛЭЛ, ИЛТГЭЛИЙГ СОНСОХ, ХЭЛЭЛЦЭХ**

#### **115 дугаар зүйл.Хуулиар тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээллийг сонсох, хэлэлцэх**

115.1.Улсын Их Хурлаар хэлэлцэхээр хуульд тусгайлан заасан тайлан, илтгэл, мэдээллийг эрх бүхий байгууллага хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлнэ.

115.2.Дараах тайлан, илтгэл, мэдээллийг Байнгын хороо доор дурдсан харьяаллаар хэлэлцэнэ:

115.2.1.Төрийн аудитын байгууллагын үйл ажиллагааны тайланг Төсвийн байнгын хороо жил бүр;

115.2.2.төрийн санхүү, төсвийн хараат бус хяналтыг хэрэгжүүлэх хүрээнд Төрийн аудитын тухай хуулийн 33.2-т заасны дагуу төрийн аудитын байгууллагаас гүйцэтгэсэн аудитын тайлангийн дүгнэлт, зөвлөмж, түүний биелэлтийн талаарх тайланг Төсвийн байнгын хороо тухай бүр;

115.2.3.Монгол Улс дахь хүний эрх, эрх чөлөөний байдлын талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэлийг Хууль зүйн байнгын хороо болон холбогдох бусад Байнгын хороо хаврын ээлжит чуулганы хугацаанд;

115.2.4.Монголбанкны санхүүгийн тайлан, түүнд холбогдох аудитын санал, дүгнэлт болон Хяналтын зөвлөлийн санал, зөвлөмжийг Эдийн засгийн байнгын хороо жил бүр;

115.2.5.төрийн мөнгөний бодлого, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилт, мөнгө, зээлийн байдлын талаарх Монголбанкны мэдээллийг Эдийн засгийн байнгын хороо шаардлагатай тохиолдолд;

115.2.6.хууль тогтоомжоор хүлээсэн чиг үүргээ хэрэгжүүлсэн талаарх Төрийн албаны зөвлөлийн тайланг жил бүр Төрийн байгуулалтын байнгын хороо;

115.2.7.Хүний эрхийн Үндэсний Комиссын эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх асуудал эрхэлсэн гишүүний Эрүү шүүлтээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагааны тайланг Хууль зүйн байнгын хороо жил бүрийн эхний улиралд;

115.2.8.жендэрийн эрх тэгш байдлыг хангах, талаарх хууль тогтоомжийн хэрэгжилтийн төлөв байдал, жендэрийн ялгаварлан гадуурхалттай холбоотой гомдлын хянан шийдвэрлэлтийн талаарх Хүний эрхийн Үндэсний Комиссын илтгэл болон жендэрийн эрх тэгш байдлыг хангах хууль тогтоомжийн хэрэгжилт, үр дүнгийн талаарх Засгийн газрын тайланг Нийгмийн бодлогын байнгын хороо болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хоёр жил тутам;

115.2.9.банкны үйл ажиллагаанаас бусад санхүүгийн үйлчилгээг зохицуулах, хянахтай холбогдсон хууль тогтоомжийн биелэлтийн талаарх Санхүүгийн зохицуулах хорооны тайланг Эдийн засгийн байнгын хороо жил бүр;

115.2.10.Үндэсний статистикийн хорооны үйл ажиллагааны тайланг Эдийн засгийн байнгын хороо жил бүр;

115.2.11.Олон нийтийн радио, телевизийн Үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо жил бүр;

115.2.12.Нийгмийн даатгалын үндэсний зөвлөл болон Эрүүл мэндийн даатгалын үндэсний зөвлөлийн үйл ажиллагааны тайланг Нийгмийн бодлогын байнгын хороо жил бүр;

115.2.13.Засгийн газрын өрийн удирдлагын дунд хугацааны стратегийн баримт бичгийн хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайлан, өрийн удирдлагын тухай хууль тогтоомжийн хэрэгжилтийг Төсвийн байнгын хороо жил бүр;

115.2.14.төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хууль тогтоомжийн хэрэгжилт, төрийн албан хаагчийн ёс зүйн зөрчлийн нэгдсэн дүн, төлөв байдлын талаарх Ёс зүйн хорооны тайланг Ёс зүй, дэгийн байнгын хороо жил бүр;

115.2.15.Олон улсын гэрээний тухай хуулийн 8.1.1-д заасан олон улсын гэрээний хэрэгжилтийн талаарх Засгийн газрын тайланг Аюулгүй байдал, гадаад бодлогын болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар хоёр жил тутам;

115.2.16.Эмэгтэйчүүдийг алагчилах бүх хэлбэрийг устгах тухай конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын ээлжит тайланг Нийгмийн бодлогын болон Хууль зүйн байнгын хорооны хамтарсан хуралдаанаар тухай бүр;

115.2.17.Засгийн газар дахь хяналт шалгалтын ажлын ерөнхий дүнг Төрийн байгуулалтын байнгын хороо жил бүр.

115.3.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 15.2-т заасан тайланг холбогдох Байнгын хороо шаардлагатай гэж үзвэл хэлэлцэнэ.

115.4.Энэ хуулийн 115.2, 115.3-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг Улсын Их Хурал хүлээн авснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын мэдээллийн нэгдсэн санд байршуулна.

115.5.Энэ хуулийн 115.2.3, 115.2.15-д заасан илтгэл, тайланг холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанд заавал танилцуулах бөгөөд бусад тайлан, илтгэл, мэдээллийг холбогдох Байнгын хороо хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

115.6.Энэ хуулийн 115.2-т заасан Засгийн газрын тайлан, илтгэлийг Ерөнхий сайд, холбогдох байгууллагын тайлан, илтгэл, мэдээллийг тухайн байгууллагын дарга Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Байнгын хорооны болон нэгдсэн хуралдаанаар хэлэлцүүлж байгаа тайлан, илтгэл, мэдээлэл, Байнгын хорооны санал, дүгнэлттэй холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн асуулт асууж, үг хэлж болно.

115.7.Байнгын хороо энэ хуулийн 115.2-т заасан тайлан, илтгэл, мэдээллийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл холбогдох хууль тогтоомжийн төсөл боловсруулж, холбогдох санал, дүгнэлтийн хамт нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

115.8.Улсын Их Хурал Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 14.1.1-д заасан Ерөнхийлөгчийн хаалттай мэдээллийг жил бүрийн 01 дүгээр сарын гурав дахь долоо хоногт багтаан нэгдсэн хуралдаанаараа сонсоно. Нэгдсэн хуралдааны үеэр гишүүд танилцуулгатай холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

## **116 дугаар зүйл.Байнгын хорооны хуралдаанаар мэдээлэл сонсох**

116.1.Хуульд заасны дагуу, эсхүл Байнгын хороо эрхлэх асуудлын хүрээнд өөрийн санаачилгаар Засгийн газрын гишүүд, Улсын Их Хуралд ажлаа шууд хариуцан тайлагнадаг байгууллагын болон бусад байгууллагын мэдээллийг хуралдаанаараа хэлэлцэж болно.

116.2.Гишүүн Байнгын хорооны хуралдаанаар энэ хуулийн 116.1-д заасан мэдээллийг хэлэлцэхэд асуулт асууж, үг хэлж болно.

116.3.Байнгын хороо энэ хуулийн 116.1-д заасан мэдээллийг хэлэлцээд, шаардлагатай гэж үзвэл хууль тогтоомж, Улсын Их Хурлаас баталсан бодлого, төлөвлөлтийн баримт бичгийн хэрэгжилтийг хангуулах чиглэлээр тогтоол гаргаж болно.

**117 дугаар зүйл.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн тайлан, Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлан хэлэлцэх**

117.1.Улсын Их Хурал Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн тухайн жилийн явцын тайланг Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэлийн тайлантай нэгтгэн хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэнэ.

117.2.Засгийн газар Улсын хөгжлийн жилийн төлөвлөгөөний биелэлтийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.2-т заасан шалгуурыг хангаж, хуульд заасан хугацаанд Улсын Их Хуралд ирүүлнэ.

117.3.Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөр, Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэлийн тухайн жилийн гүйцэтгэлийн явцтай нэгтгэн гаргасан тайланг Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.2-т заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хүргүүлж болно.

117.4.Байнгын хороодын хамтарсан хуралдаанаас гарах санал, дүгнэлтэд дараах зүйлийг тусгана:

117.4.1.жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл нь тухайн жилийнхээ зорилтот түвшинд хүрсэн, шалгуур үзүүлэлтийг хангасан эсэхийг бүлэг тус бүрээр болон нэгдсэн дүнгээр;

117.4.2.тухайн жилийн төлөвлөгөөний гүйцэтгэл нь Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрт заасан зорилтын хэдэн хувьд хүрснийг бүлэг тус бүрээр;

117.4.3.жилийн төлөвлөгөөнд заасан төсөл, арга хэмжээ бүрэн хэрэгжээгүй бол түүний шалтгаан, нөхцөлийн талаар.

117.5.Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг хуульд заасан хугацаанд Төрийн байгуулалтын байнгын хороо, Эдийн засгийн байнгын хороо хамтран Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.2-т заасны дагуу хэлэлцэнэ. Шаардлагатай гэж үзвэл бусад Байнгын хороод эрхлэх асуудлынхаа хүрээнд хэлэлцэж санал, дүгнэлтээ хүргүүлж болно.

117.6.Энэ хуулийн 117.1, 117.5-д заасан тайланг Ерөнхий сайд, эсхүл үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байнгын хороо болон нэгдсэн хуралдаанд танилцуулна.

117.7.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 18.4-т заасан аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор танилцуулна.

117.8.Тамгын газар энэ хуулийн 117.1, 117.5-д заасан тайланд шинжилгээ хийж, 03 дугаар сарын 15-ны дотор Улсын Их Хурлын гишүүдэд тараана.

117.9.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд гишүүд энэ хуулийн 120.6-д заасан танилцуулга, аудитын тайлантай холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

117.10.Нэгдсэн хуралдаан тайланг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 17.8, 18.10-т заасан асуудлаар тогтоол батлах шаардлагатай гэж үзвэл энэ талаар холбогдох Байнгын хороонд чиглэл өгнө. Байнгын хороо нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу холбогдох тогтоолын төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанд танилцуулна. Улсын Их Хурал уг тогтоолыг 04 дүгээр сарын 01-ний дотор батална.

**118 дугаар зүйл. Урт хугацааны бодлогын баримт бичиг болон Хөгжлийн зорилтот хөтөлбөрүүдийн хэрэгжилтийн явцын болон гүйцэтгэлийн тайлан хэлэлцэх**

118.1.Улсын Их Хурал Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг урт хугацааны бодлогын баримт бичгийн явцын тайлантай нэгтгэн хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэнэ.

118.2.Урт хугацааны бодлогын баримт бичгийн гүйцэтгэлийн тайланг Улсын Их Хурал хуульд заасан хугацаанд хянан хэлэлцэнэ.

118.3.Тамгын газар энэ хуулийн 118.1, 118.2-т заасан тайланд шинжилгээ хийж, тайланг хэлэлцэж эхлэхээс ажлын 15 өдрийн өмнө Улсын Их Хурлын гишүүдэд тараана.

118.4.Хөгжлийн зорилтот хөтөлбөрийн гүйцэтгэлийн тайланг холбогдох Байнгын хороо хэлэлцэнэ. Энэ хуулийн 118.2-т заасан тайланг хэлэлцэх үндсэн Байнгын хороо нь Төрийн байгуулалтын байнгын хороо байх бөгөөд бусад Байнгын хороо өөрийн эрхлэх асуудлын хүрээнд хэлэлцэн санал, дүгнэлтээ Төрийн байгуулалтын байнгын хороонд хүргүүлнэ.

118.5.Ерөнхий сайд, эсхүл үндэсний хөгжлийн бодлого, төлөвлөлтийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн Байнгын хороод болон нэгдсэн хуралдаанд энэ хуулийн 118.1, 118.2-т заасан тайланг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.3, 20.3-т заасан зарчмын дагуу танилцуулна.

118.6.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.7, 20.7-д заасан аудитын тайланг Монгол Улсын Ерөнхий аудитор танилцуулна.

118.7.Нам, эвслийн бүлэг энэ хуулийн 118.1, 118.2-т заасан тайланг хэлэлцсэн бол санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороонд хүргүүлж, нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

118.8.Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд гишүүд энэ хуулийн 118.5-д заасан танилцуулга, аудитын тайлантай холбогдуулан асуулт асууж, үг хэлж болно.

118.9.Нэгдсэн хуралдаан энэ хуулийн 118.1, 118.2-т заасан тайланг хэлэлцээд Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 19.10, 20.12-т заасан асуудлаар тогтоол батлах шаардлагатай гэж үзвэл энэ талаар холбогдох Байнгын хороонд чиглэл өгнө. Холбогдох Байнгын хороо нэгдсэн хуралдаанаас өгсөн чиглэлийн дагуу уг тогтоолын төслийг боловсруулж, нэгдсэн хуралдаанд танилцуулж, батлуулна.

**АРВАН ТАВДУГААР БҮЛЭГ  
УЛСЫН ИХ ХУРЛЫН ХЯНАЛТЫН СОНСГОЛ  
ЗОХИОН БАЙГУУЛАХ ЖУРАМ**

**119 дүгээр зүйл.Улсын Их Хурлын хяналтын сонсгол явуулах  
талаар хүсэлт гаргах, хүсэлтийг шийдвэрлэх**

119.1.Улсын Их Хурлын хяналтын сонсгол явуулах хүсэлтийг доор дурдсаны дагуу бичгээр гаргах бөгөөд түүнд нийтийн сонсгол /цаашид “сонсгол” гэх/ зохион байгуулах үндэслэл, шаардлагыг тодорхой тусгана:

119.1.1.Монгол Улсын Ерөнхийлөгч хүсэлтээ Улсын Их Хуралд;

119.1.2.Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн, эсхүл цөөнхийн бүлэг хүсэлтээ Улсын Их Хурлын даргад;

119.1.3.Байнгын, дэд хорооны нийт гишүүний олонх хүсэлтээ Байнгын, дэд хорооны даргад.

119.2.Энэ хуулийн 119.1-д заасны дагуу хүсэлт гаргасан бол тухайн сонсголыг холбогдох Байнгын, дэд хороо зохион байгуулна.

119.3.Байнгын, дэд хороо өөрөө санаачлан сонсгол явуулахаар хуульд тусгайлан заасан асуудлаар тухайн Байнгын, дэд хорооны гишүүн хүсэлт гаргасныг хуралдаанд оролцсон гишүүдийн олонх нь дэмжсэн бол тухайн сонсголыг явуулна.

119.4.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 27.3, 29.2.4-т заасан иргэн, хуулийн этгээдийн бичгээр гаргасан хүсэлтийг холбогдох Байнгын, дэд хорооны хуралдаанд оролцсон гишүүдийн олонх дэмжсэн бол хяналтын сонсголыг явуулна. Хэрэв сонсгол зохион байгуулах шаардлагагүй гэж үзсэн бол үндэслэл бүхий хариуг хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдэд ажлын гурван өдрийн дотор бичгээр өгнө.

119.5.Энэ хуулийн 126.1-д зааснаас бусад тохиолдолд нэг асуудлаар сонсгол явуулахаар хэд хэдэн хүсэлт гарсан бол тухайн сонсголыг нэгтгэн явуулж болно.

119.6.Улсын Их Хурлын хяналтын сонсголыг явуулснаас хойш нэг жилийн дотор тухайн асуудлаар дахин сонсгол явуулахгүй.

**120 дугаар зүйл.Сонсгол зохион байгуулах харьяалал**

120.1.Сонсголыг дараах харьяаллын дагуу зохион байгуулна:

120.1.1.ерөнхий хяналтын, нэр дэвшигчийн болон хүний эрх, эрх чөлөөг хангахтай холбоотой хяналтын сонсголыг холбогдох Байнгын, эсхүл дэд хороо;

120.1.2.тухайн жилийн төсвийн төсөл болон төсвийн хууль тогтоомжийн хэрэгжилт, төсвийн гүйцэтгэл, төсвийн хүрээний мэдэгдлийн талаарх хяналтын сонсгол явуулах бол Төсвийн байнгын хороо, эсхүл Төсвийн зарлагын хяналтын дэд хороо, тухайн жилийн төсөв болон жилийн хөгжлийн төлөвлөгөөний уялдааны талаарх хяналтын сонсголыг Эдийн засгийн байнгын хороо.

120.2.Хуульд ерөнхий хяналтын сонсгол явуулахаар тусгайлан хугацаа тогтоосон бол тухайн сонсголыг холбогдох Байнгын, эсхүл дэд хороо зохион байгуулна.

120.3.Байнгын хороо Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.8-д заасан тогтоолоор сонсгол зохион байгуулах ажлын хэсгийг байгуулна.

120.4.Энэ хуулийн 120.1, 120.2-т заасан сонсголыг дэд хороо явуулсан бол сонсголын тайлан, санал, дүгнэлтээ холбогдох Байнгын хороонд танилцуулна. Гишүүд асуулт асууж, үг хэлж болно.

120.5.Энэ хуулийн 120.1, 120.2-т заасан сонсголыг Байнгын хороо явуулсан бол сонсголын тайлангийн агуулгыг өөрчлөхгүйгээр Байнгын хорооны санал, дүгнэлтэд тусган нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

120.6.Байнгын хороо энэ хуулийн 120.4, 120.5-д заасны дагуу сонсголын тайлан, санал, дүгнэлтийг хэлэлцээд шаардлагатай гэж үзвэл Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 10.1-д заасан асуудлаар холбогдох тогтоолын төслийг нэгдсэн хуралдаанд танилцуулж болно.

120.7.Сонсголыг Төсвийн зарлагын хяналтын дэд хороо явуулсан бол сонсголын санал, дүгнэлтээ Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 28.3-т заасны дагуу нэгдсэн хуралдаанд танилцуулна.

120.8.Сонсголыг нэгдсэн болон Байнгын, дэд, хянан шалгах түр хорооны хуралдаантай давхардуулахгүйгээр зохион байгуулах бөгөөд Улсын Их Хурлын чуулганы чөлөө цагт зохион байгуулж болно.

## **121 дүгээр зүйл. Сонсголын бэлтгэл хангах**

121.1.Энэ хуулийн 119.1-т заасан хүсэлтийг хүлээн авснаас хойш, эсхүл энэ хуулийн 119.3, 119.4-т заасны дагуу хүсэлтийг дэмжсэнээс хойш ажлын таван өдрийн дотор холбогдох Байнгын, дэд хороо сонсголыг товлон зарлана.

121.2.Сонсгол явуулах сэдэв, огноо, байр, оролцогч, ажиглагчийг бүртгэх ажиллагаа, бүртгэл эхлэх, дуусах хугацаа, саналыг хүлээн авах цахим болон шуудангийн хаяг, холбогдох бусад мэдээллийг агуулсан зарыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулж, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол давтамж, хүртээмжтэйгээр нийтэд мэдээлнэ.

121.3.Энэ хуулийн 119.1-д заасан этгээд сонсголын товыг хойшлуулах шаардлагатай гэж үзсэн бол хойшлуулах шалтгаан, хугацааг тодорхой дурдсан хүсэлтийг 121.1-д заасан Байнгын, дэд хороонд ирүүлнэ.

121.4.Байнгын, дэд хороо хүсэлтийг дэмжиж шийдвэрлэсэн бол хойшлуулах үндэслэл, шалтгаанаас хамааран хойшлуулах хугацаа ажлын таваас илүүгүй өдөр байна. Энэ тохиолдолд сонсголын товыг нийтэд зарласан арга хэрэгслээр дахин зарлана.

121.5.Сонсголд тодорхой асуудлаар санал хэлэх, тайлбар, дүгнэлт гаргах төрийн байгууллага, албан тушаалтныг оролцуулах бөгөөд албан тушаалтан



хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонсголд ирээгүй нь сонсголыг хойшлуулах үндэслэл болохгүй.

121.6.Энэ хуулийн 120.3-т заасан ажлын хэсэг тухайн асуудлаар сонсгол явуулахад шинжээч шаардлагатай гэж үзсэн бол үндэслэл бүхий хүсэлтээ 121.1-д заасан Байнгын, дэд хороонд ирүүлнэ. Байнгын, дэд хороо хүсэлтийг дэмжсэн бол Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 9.7, 9.10-т заасны дагуу шийдвэрлэнэ.

121.7.Сонсголд оролцох иргэн, хуулийн этгээд, ажиглагч /цаашид “оролцогч” гэх/ нь сонсгол болохоос ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө Байнгын хороо, түр хороонд бүртгүүлнэ.

121.8.Сонсголд оролцогчийн тооны дээд хязгаарыг сонсгол болох танхимын багтаамж, тухайн асуудлын хүрээнээс хамааран сонсгол даргалагч тогтооно.

121.9.Оролцогч санал, тайлбар, мэдээллээ сонсгол болохоос ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө бичгээр өгч болно.

121.10.Төсвийн хяналтын сонсгол явуулах хугацааг товлон зарламагц тухайн асуудлаар дүгнэлт гаргуулахаар төрийн аудитын байгууллагад холбогдох баримт бичгийг хүргүүлэх бөгөөд төрийн аудитын байгууллага гаргасан дүгнэлтээ сонсгол болохоос ажлын гурваас доошгүй өдрийн өмнө ирүүлнэ.

121.11.Энэ хуулийн 121.2-т заасны дагуу сонсголын товыг нийтэд мэдээлснээс хойш 14-өөс доошгүй хоногийн хугацаанд сонирхогч этгээдээс тухайн сонсголын асуудлын талаарх саналыг цахимаар, эсхүл шуудангаар хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй саналыг бүртгэхгүй.

121.12.Төсвийн хяналтын сонсгол зохион байгуулахад энэ хуулийн 121.11-д заасан хугацааг өөрөөр тогтоож болно.

121.13.Энэ хуулийн 121.11, 121.12-т заасан хугацаа өнгөрснөөс хойш 30 хоногийн дотор сонсгол явуулна.

121.14.Сонсголын зохион байгуулалтын асуудлыг Тамгын газар хариуцна.

## **122 дугаар зүйл.Сонсгол даргалагч**

122.1.Холбогдох Байнгын болон дэд хорооны хуралдаанаар сонсгол даргалагч /цаашид “сонсгол даргалагч” гэх/-ийг хуралдаанд оролцсон гишүүдийн олонхын саналаар сонгоно. Сонсгол даргалагчийн эзгүйд түүний томилсон гишүүн сонсгол даргална.

## **123 дугаар зүйл.Сонсголд оролцогч**

123.1.Хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээд, шинжээч, ажиглагчийг сонсголд оролцогч гэнэ.

123.2.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26.1.4-т зааснаас бусад сонсголд тухайн асуудлаар мэргэшсэн мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагыг заавал оролцуулна.

123.3.Мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллагыг сонголд оролцуулах асуудлыг энэ хуулийн 127.5-д заасан журмаар нарийвчлан зохицуулна.

123.4.Нэг асуудлаар ижил ашиг сонирхолтой гурав ба түүнээс дээш, эсхүл хэд хэдэн этгээд хамтарч сонголд оролцох хүсэлт гаргасан бол тэдгээрийн саналаар гурав хүртэл этгээд төлөөлөн сонголд оролцоно.

123.5.Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 26.1.4-т заасан сонголд нэр дэвшигч, түүнийг Улсын Их Хуралд танилцуулах эрх бүхий этгээд, эсхүл түүний төлөөлөгч, нэр дэвшигчээс асуулт асуух, нэр дэвшигч нь тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан эсэх талаар санал хэлэх, мэдээлэл өгөхөөр хүсэлт гаргасан болон хуульд заасны дагуу мэдээлэл өгөх иргэн, хуулийн этгээд, ажиглагч оролцоно.

123.6.Монгол Улсын Их Хурлын хяналтын сонголд хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийг ажиглагчаар оролцуулж болох бөгөөд ажиглагч нь сонголд хууль тогтоомжид заасны дагуу зохион байгуулагдаж байгаа эсэхэд хяналт тавина.

123.7.Ажиглагч нь сонголын үед нэр дэвшигчээс болон бусад оролцогчдоос асуулт асуух, үг хэлэх эрх эдлэхгүй.

## **124 дүгээр зүйл.Сонголд оролцогчийн эрх, үүрэг**

124.1.Энэ хуулийн 123.1-д заасан оролцогч дараах эрх эдэлнэ:

124.1.1.энэ хуульд заасан үндэслэл, журмын дагуу асуултад хариулах, тайлбар, санал хэлэх;

124.1.2.сонголын тэмдэглэл, гарсан шийдвэртэй танилцах, өөрийн хэлсэн санал, тайлбарыг хянах;

124.1.3.сонголд зохион байгуулагч болон даргалагчаас тэнцвэртэй, хүндэтгэлтэй хандахыг шаардах;

124.2.Сонголд оролцогч дараах үүрэг хүлээнэ:

124.2.1.сонголд зохион байгуулагчийн дуудсанаар сонголд хүрэлцэн ирэх;

124.2.2.сонголын дэг сахих;

124.2.3.сонголд зохион байгуулагч болон сонголд даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэх;

124.2.4.сонголд үнэн зөв мэдүүлэх, бодитой дүгнэлт өгөх;

124.2.5.холбогдох бусад хууль тогтоомжид заасан үүрэг хүлээх.

124.3.Сонголд оролцогч нь сонголын явцад бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох, яриаг нь таслах, сонголд даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.

124.4.Хэл яриа, сонголын бэрхшээлтэй хүмүүст хүртээмжтэй байлгах зорилгоор сонголыг дохионы хэлмэрчтэй явуулна.

124.5.Сонсгол зохион байгуулагч нь хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн сонсголд оролцох, ажиглах боломжийг хангана.

### **125 дугаар зүйл.Сонсгол даргалагчийн эрх, үүрэг**

125.1.Сонсгол даргалагч сонсголыг хуульд заасны дагуу удирдан зохион байгуулах, сонсголын асуудлыг тал бүрээс нь үнэн бодитойгоор тогтоох, сонсголд ач холбогдол бүхий нотлох баримтыг цуглуулах, үнэлэх, оролцогчийн эрх, үүргээ хэрэгжүүлэх нөхцөлийг бүрдүүлэх, сонсголын дэг сахиулах үүрэгтэй.

125.2.Сонсгол даргалагч дараах нийтлэг эрх эдэлж, үүрэг хүлээнэ:

125.2.1.сонсголын бэлтгэлийг хангах;

125.2.2.сонсголыг товлосон цагт эхлүүлж, дэгийн дагуу явуулах;

125.2.3.сонсголд оролцож байгаа этгээдэд асуулт асуух, үг хэлэх зөвшөөрөл өгөх;

125.2.4.сонсголын тайланг хянаж, эрх бүхий этгээдэд танилцуулах;

125.2.5.хүндэтгэн үзэх шалтгаантай оролцогчид чөлөө өгөх;

125.2.6.сонсголын дэг сахиулах, оролцогчдоос дэг сахихыг шаардах;

125.2.7.сонсголын дэг зөрчигчид холбогдох хууль тогтоомжид заасан арга хэмжээ авах;

125.2.8.сонсголын асуулт, хариулт, тайлбар, санал, мэдээлэл нь сонсголын сэдэвт хамааралгүй, ялгаварлан гадуурхсан, доромжилсон үг хэллэг хэрэглэсэн бол таслан зогсоох;

125.2.9.сонсголын дэг зөрчсөн, эсхүл энэ хуулийн 124.3-т заасан үйлдэл гаргасан оролцогчид сануулах, зайлшгүй шаардлагатай бол үг хэлэх эрхийг нь хасах;

125.2.10.сонсголын тогтсон сэдвээс өөр сэдвийг хөндсөн тохиолдолд сануулга өгөх;

125.2.11.сонсголын үйл ажиллагаанд саад учруулсан этгээдийг танхимаас гаргах.

### **126 дугаар зүйл.Сонсгол явуулах журам**

126.1.Сонсголыг дараах журмаар явуулна:

126.1.1.сонсгол даргалагч сонсголын зорилго, ирц, дэгийг танилцуулах;

126.1.2.сонсгол даргалагч оролцогчийн санал хэлэх, тайлбар, дүгнэлт гаргах, асуулт асуух дарааллыг тогтоох;

126.1.3.сонсголд дуудаж ирүүлсэн албан тушаалтан нь тухайн сэдвээр мэдээлэл өгөх эрх бүхий албан тушаалтан мөн эсэх талаар тодруулга авах;

126.1.4.оролцогчийн санал, мэдээлэл, дүгнэлтээ танилцуулах хугацаа 10 минутаас илүүгүй байх;

126.1.5. гишүүн оролцогчоос асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно;

126.1.6. гишүүн оролцогчоос асуулт асууж, хариулт авч дууссаны дараа 5 минутад багтаан үг хэлж болно;

126.1.7. сонсгол даргалагч сонсож байгаа асуудалтай холбогдуулан бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийн агуулгыг уншиж танилцуулан сонсголын тэмдэглэлд тусгуулна;

126.1.8. сонсгол даргалагч болон гишүүн бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох зэрэг зохисгүй үйлдэл гаргахыг хориглоно.

126.2. Энэ хуулийн 126.1.5, 126.1.6-д заасан үйл ажиллагаанд олонх, цөөнхийн төлөөлөлд ээлжлэн асуулт асуух, үг хэлэх боломж олгоно.

126.3. Хуульд өөрөөр заагаагүй бол оролцогч сонсголын үеэр сонсгол даргалагч, гишүүн, бусад оролцогчоос асуулт асуухгүй.

126.4. Улсын Их Хурлын хяналтын сонсголыг нээлттэй, хаалттай хэлбэрээр зохион байгуулах бөгөөд хувь хүн, байгууллага, төрийн нууцад хамаарах болон үндэсний аюулгүй байдлыг хангахтай холбоотойгоос бусад асуудлаар сонсголыг хаалттай явуулахыг хориглоно.

126.5. Улсын Их Хурлын хяналтын сонсголыг зохион байгуулах нарийвчилсан журмыг Улсын Их Хурлын тогтоолоор батална.

## **127 дугаар зүйл. Сонсголыг цахимаар явуулах**

127.1. Сонсголыг танхимаар, эсхүл цахимаар, түүнчлэн хосолмол хэлбэрээр явуулж болно.

127.2. Цахим сонсголыг энэ хуулийн 7 дугаар зүйлд заасан журмыг баримтлан явуулна.

127.3. Сонсголд оролцогчдод оролцогчийн эрх, үүрэг, сонсголын дэгийн талаарх мэдээллийг тусгаж Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулсан бүртгэлийн маягыг зохих журмын дагуу бөглөж ирүүлсний дараа цахим холбоосыг хүргүүлнэ.

## **128 дугаар зүйл. Сонсголын тайлан, тэмдэглэл**

128.1. Нэр дэвшигчийн сонсголоос бусад энэ хуульд заасан сонсголын тайланг сонсгол явуулснаас ажлын таван өдрийн дотор тухайн сонсголыг явуулсан Байнгын, дэд хороо гаргана.

128.2. Тайланд сонсголын үр дүнгийн талаарх дүгнэлт, сонсголын явцад ил болсон асуудал, түүнийг шийдвэрлэх арга замын талаар дурдах бөгөөд ажиглагч дүгнэлт ирүүлсэн бол дүгнэлтийг, түүнчлэн бичгээр ирүүлсэн санал, хүсэлт, мэдээллийг хавсаргана.

128.3.Нэр дэвшигчийн сонсголоос бусад хяналтын сонсголын тайланг боловсруулахад Тамгын газрын хяналт шалгалтын асуудал хариуцсан нэгж мэргэжил, арга зүйн туслалцаа үзүүлнэ.

128.4.Хуульд өөрөөр заагаагүй бол сонсголын тайлан, тэмдэглэл ил тод байх бөгөөд тайланг гаргаснаас хойш ажлын гурван өдрийн дотор Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст тэмдэглэлийн хамт байршуулна.

128.5.Сонсголын тэмдэглэлийг энэ хуульд заасан журмын дагуу хөтлөх бөгөөд тухайн сонсголын үр дүнтэй холбогдуулан Байнгын хороо, эсхүл Улсын Их Хурлаас шийдвэр гарсан бол тухайн шийдвэрийн хамт архивын нэгж болгон хадгална.

128.6.Энэ хуулийн 128.5-д заасан шийдвэр гараагүй бол тухайн сонсголын тэмдэглэлийг энэ хуульд заасан журмаар эмхэлж, сонсголын тайлангийн хамт архивын нэг нэгж болгон товъёоглож, хадгална.

### **129 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсгол**

129.1.Эрх бүхий байгууллага, албан тушаалтан хуульд заасны дагуу албан тушаалтныг томилох, зөвшилцөх, танилцуулах саналаа Улсын Их Хуралд албан ёсоор ирүүлнэ. Саналд нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих боловсрол, мэргэжил, мэргэшил, туршлага, мэдлэг, ур чадвар, ёс зүй, хуулиар тусгайлан заасан шаардлагыг хангаж байгаа талаарх үндэслэл бүхий нэр дэвшигчийн танилцуулга, хувийн ашиг сонирхлын урьдчилсан мэдүүлэг, бусад баримт бичиг, мэдээллийг хавсаргана.

129.2.Эрх бүхий этгээд хуульд заасны дагуу нэр дэвшигчийг санал болгохдоо Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 30.6-д заасан маягтын дагуу гаргаж Улсын Их Хуралд ирүүлнэ.

129.3.Нээлттэй сонгон шалгаруулалтад оролцохдоо гаргасан иргэний нэр дэвших тухай хүсэлт, мэдээллийг энэ хуулийн 129.2-т заасны дагуу ирүүлнэ.

### **130 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсголын товыг тогтоох, зарлах**

130.1.Нэр дэвшигчийн сонсгол явуулахаар хуульд тусгайлан заасан бол Байнгын хороо энэ хуулийн 129.1-д заасан саналыг Улсын Их Хурлын чуулганы хугацаанд хүлээн авсан тохиолдолд ажлын таван өдрийн дотор, чуулганы чөлөө цагт хүлээн авсан тохиолдолд ээлжит чуулган эхэлсэн өдрөөс хойш ажлын таван өдрийн дотор дараах ажиллагааг явуулна:

130.1.1.сонсголын тов тогтоож, нийтэд мэдээлэх;

130.1.2.энэ хуулийн 129.1-д заасан санал, нэр дэвшигчийн танилцуулгыг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй.

130.2.Байнгын хороо нэр дэвшигчийг өөрөө сонгон шалгаруулахаар хуульд заасан бол сонгон шалгаруулалтын дүнг гарснаас хойш ажлын таван өдрийн дотор Байнгын хороо энэ хуулийн 130.1-д заасан ажиллагааг хийнэ.

130.3.Энэ хуулийн 119.1.2-т заасны дагуу Улсын Их Хурлын 15-аас доошгүй гишүүн сонсгол явуулах хүсэлт гаргасан бол хүсэлтийг хүлээн авсанаас хойш ажлын

таван өдрийн дотор сонсгол товлон зарлана.

130.4.Энэ хуулийн 121.2-т зааснаас гадна доор дурдсан мэдээллийг агуулсан сонсголын зарыг Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулж, өдөр тутмын хэвлэл, мэдээллийн хэрэгслээр тогтмол давтамж, хүртээмжтэй байдлаар нийтэд мэдээлнэ:

130.4.1.энэ хуулийн 129.1, 129.3-т заасан санал, мэдээллийг байршуулсан цахим хуудас;

130.4.2.нэр дэвшигчээс асуух асуулт, нэр дэвшигчийн талаарх саналыг бичгээр хүлээн авах цахим болон шуудангийн хаяг.

130.5.Энэ хуулийн 131.1-д заасан хугацаа өнгөрснөөс хойш 30 хоногийн дотор сонсгол явуулна.

### **131 дүгээр зүйл.Нэр дэвшигчийн сонсголын бэлтгэл хангах**

131.1.Байнгын хороо энэ хуулийн 130.1, 130.2-т заасан ажиллагааг явуулснаас хойш 14-өөс доошгүй хоногийн хугацаанд нэр дэвшигчээс асуух асуулт, саналыг цахимаар, эсхүл шуудангаар хүлээн авах бөгөөд нэр, хаяггүй асуулт, саналыг бүртгэхгүй. Асуулт, санал хүлээн авах хугацааг Байнгын хороо тогтоох шаардлагатай бол тухайн сонсголын дэгийг боловсруулж, батлах зэрэг сонсголын бэлтгэлийг хангана.

131.2.Сонсголд оролцох, ажиглах иргэн, хуулийн этгээд нь сонсгол явуулахаас ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө сонсголд оролцох тухай хүсэлтээ Байнгын хороонд бүртгүүлнэ. Сонсголд оролцогчдод сонсголын журам, оролцогчийн эрх, үүргийг урьдчилан танилцуулна.

131.3.Сонсголд оролцогч нь нэр дэвшигч тухайн албан тушаалд тавигдах шаардлага хангасан, эсхүл хангаагүй тухай санал, мэдээлэл, асуултаа бичгээр гаргаж өгөх эрхтэй бөгөөд энэ нь сонсголд оролцож үг хэлэхэд саад болохгүй.

131.4.Энэ хуулийн 131.2-т заасны дагуу бүртгүүлэх хүсэлтийг цахимаар, эсхүл шуудангаар илгээж болох бөгөөд Байнгын хороо хүсэлтийг хүлээн авсан огноо, цаг, минутаар эрэмбэлэн бүртгэж, баталгаажуулна.

131.5.Хэвлэл, мэдээллийн байгууллага сонсголд оролцох хүсэлтээ сонсгол явуулахаас ажлын нэгээс доошгүй өдрийн өмнө цахимаар, эсхүл шуудангаар Байнгын хороонд ирүүлнэ.

131.6.Тухайн чиглэлийн мэргэжилтэн, мэргэжлийн холбоо, төрийн бус байгууллага, бусад байгууллагын төлөөллийг сонсгол даргалагчийн болон Байнгын хорооны гишүүний урилгаар сонсголд оролцуулж болно.

131.7.Сонсголд оролцож, тодорхой асуудлаар тайлбар, мэдээлэл хийх төрийн байгууллага, албан тушаалтан, иргэн, хуулийн этгээд, шинжээчид сонсгол болохоос ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө сонсголын товыг мэдэгдэнэ.

131.8.Байнгын хороо нь нэр дэвшигчийн мэдлэг, мэргэшил, ур чадвар, ёс зүй, туршлагын талаар мэргэжлийн, хараат бус дүгнэлт гаргах үүрэг бүхий шинжээч

/цаашид “хараат бус шинжээч” гэх/-ийг Байнгын хорооны хуралдаанд оролцсон гишүүний гуравны хоёроос доошгүйн саналаар томилно.

131.9.Сонгон шалгаруулах ажлын хэсэг нэр дэвшигчийг санал болгосон бол хараат бус шинжээчийг томилохгүй.

131.10.Хараат бус шинжээч дараах арга хэмжээг авч хэрэгжүүлнэ:

131.10.1.нэр дэвшигчийн баримт бичиг, олон нийтээс ирүүлсэн саналыг судлах;

131.10.2.нэр дэвшигчтэй болон бусад этгээдтэй ярилцлага хийх зэргээр мэдээлэл цуглуулах;

131.10.3.энэ хуулийн 131.8-д заасан асуудлаар үндэслэл бүхий дүгнэлт бичгээр гаргах;

131.10.4.нэр дэвшигчийн талаарх дүгнэлтээ нэр дэвшигчийн сонсгол, Байнгын хороо, нэгдсэн хуралдаанд танилцуулах.

131.11.Нэр дэвшигчийг санал болгосон этгээд болон бусад байгууллага, албан тушаалтан нэр дэвшигчийн талаарх баримт, мэдээллийг Байнгын хорооны гишүүн, эсхүл хараат бус шинжээчийн хүсэлтийн дагуу гаргаж өгөх үүрэгтэй.

## **132 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсгол явуулах**

132.1.Сонсгол даргалагч сонсголоор хэлэлцэх асуудал болон сонсгол зарласан огноо, оролцогчдын талаарх танилцуулга болон сонсголын дэгийг 10 минутад багтаан танилцуулна.

132.2.Сонсгол даргалагч, эсхүл Байнгын хорооны гишүүн нэр дэвшигчийн талаарх танилцуулгыг 10 минутад багтаан танилцуулна.

132.3.Нэр дэвшигч нь тухайн албан тушаалд томилогдсон тохиолдолд хийх ажил, нэр дэвшсэн үндэслэл, боловсрол, ажлын туршлага, тухайн албан тушаалд тавих шаардлагыг хангаж байгаа тухайгаа 10 минутад багтаан танилцуулна.

132.4.Хараат бус шинжээчийн дүгнэлтийг, эсхүл сонгон шалгаруулах ажлын хэсгийн тайланг 20 минутын дотор сонсоно. Дүгнэлт, тайланг энэ хуулийн 129.1, 129.3-т заасан санал, мэдээллийн хамт Байнгын хорооны гишүүдэд ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө хүргүүлнэ. Сонсгол даргалагч болон Байнгын хорооны гишүүн дүгнэлт, тайлантай холбогдуулан асуулт асууж болно.

132.5.Энэ хуулийн 132.4-т заасан дүгнэлт, тайлан сонссоны дараа сонсголд оролцогчид нэр дэвшигчээс асуулт асууна. Оролцогч дөрвөн минутад багтаан асуух бөгөөд даргалагчийн зөвшөөрлөөр сунгаж болно.

132.6.Энэ хуулийн 132.1, 131.3-т заасны дагуу ирүүлсэн асуулт, саналыг сонсгол даргалагч, эсхүл Байнгын хорооны гишүүн танилцуулж, нэр дэвшигчээс хариулт авна.

132.7.Нэр дэвшигчээс асуулт асуух Байнгын хорооны гишүүдийн дарааллыг тогтоохдоо олонх, цөөнхийн төлөөлөл ээлжлэн асуух боломж олгоно.

132.8.Байнгын хорооны гишүүн нэр дэвшигчээс асуулт асуух, хариулт авах хугацаа 20 хүртэл минут байх бөгөөд энэ хугацаанд багтаан хэдэн ч асуулт асууж, хариулт авч болно. Хариулт хангалтгүй гэж үзвэл нэмэлт хугацаа олгох эсэхийг сонсгол даргалагч шийдвэрлэнэ.

132.9.Нэр дэвшигч Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай хуулийн 4.1.12, 4.1.15-д заасантай шууд болон шууд бусаар холбогдох асуултад хариулахгүй байх эрхтэй.

132.10.Асуулт, хариулт дууссаны дараа нэр дэвшигчтэй холбогдуулан сонсгол даргалагч, гишүүн, оролцогч үг хэлж болох бөгөөд дараах зарчмыг баримтална:

132.10.1.нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан, хангаагүй болон төвийг сахисан байр суурь бүхий оролцогчид байгаа бол тэдгээрийг тэнцвэртэй сонсох;

132.10.2.Байнгын хорооны бүрэлдэхүүн дэх олонх, цөөнхийн төлөөлөл ээлжлэн үг хэлэх.

132.11.Энэ хуулийн 132.10-т заасны дагуу үг хэлэх хугацаа тав хүртэл минут байх бөгөөд шаардлагатай бол хуралдаан даргалагч тав хүртэл минутаар сунгаж болно.

132.12.Үг хэлэх, асуулт асуухдаа бусдыг ялгаварлан гадуурхах, доромжлох, яриаг нь таслах, сонсгол даргалагчийн зөвшөөрөлгүйгээр үг хэлэх, хүч хэрэглэх зэрэг зохисгүй үйлдэл гаргасан, эсхүл даргалагчийн хууль ёсны шаардлагыг биелүүлэхээс татгалзсан бол даргалагч дэг сахихыг шаардах, шаардлагыг үл биелүүлбэл оролцогчийг танхимаас гаргах хүртэл арга хэмжээ авна.

132.13.Тухайн албан тушаалд хоёр, эсхүл түүнээс дээш тооны хүн нэр дэвшиж байгаа бол нэр дэвшигчдийг сонсголын танхимд нэг нэгээр нь оруулна.

132.14.Нэр дэвшигч нь хүндэтгэн үзэх шалтгаангүйгээр сонсголд оролцоогүй бол тухайн албан тушаалд томилохоос татгалзах үндэслэл болно. Хүндэтгэн үзэх шалтгаанаар сонсголд оролцоогүй бол сонсголыг энэ хуульд заасны дагуу дахин зарлаж зохион байгуулна.

132.15.Нэр дэвшигчийн сонсголын хугацаа гурав хүртэл хоног үргэлжилж болно.

132.16.Хуульд өөрөөр заагаагүй бол нэр дэвшигчийн сонсголыг нээлттэй явуулна. Хэрэв нэр дэвшигчээс үндэслэл бүхий хүсэлт гаргасныг Байнгын хорооны гишүүдийн олонх дэмжсэн тохиолдолд сонсголыг хаалттай явуулж болно.

132.17.Сонсголыг хэвлэл мэдээллийн болон нийгмийн сүлжээний хэрэгслээр бүрэн хэмжээгээр нийтэд шууд дамжуулна.

### **133 дугаар зүйл.Нэр дэвшигчийн сонсголын тайлан гаргах**

133.1.Нэр дэвшигчийн сонсгол явуулснаас хойш ажлын хоёр өдрийн дотор сонсголд оролцсон гишүүд хаалттай хуралдаж, хуралдаанд оролцсон гишүүдийн



олонхын саналаар сонсголын тайлан гаргана. Тайланд сонсголын дүнд үндэслэн гаргасан нэр дэвшигч тухайн албан тушаалд тавих шаардлага хангасан эсэх дүгнэлт, түүний үндэслэлийг тусгаж, холбогдох бусад мэдээллийг хавсаргана.

133.2.Сонсголын явцад ил болсон асуудал, түүнийг шийдвэрлэх зөвлөмж, эсхүл бусад асуудлын талаар сонсголын тайланд тусгаж болно.

133.3.Сонсголын тайланг нийтлэхээс ажлын хоёроос доошгүй өдрийн өмнө нэр дэвшигч болон түүнийг санал болгосон этгээдэд хүргүүлнэ.

133.4.Энэ хуулийн 133.1-д заасан хугацаа өнгөрснөөс хойш ажлын таван өдрийн дотор дараах ажиллагааг хийнэ:

133.4.1.сонсголын тайланг Улсын Их Хурлын цахим хуудаст байршуулах бөгөөд хувь хүний нууцад хамаарах мэдээллийг нийтлэхгүй;

133.4.2.сонсголын тайланг Улсын Их Хурлын нийт гишүүнд хүргүүлэх;

133.4.3.эрх бүхий этгээдийн санал, сонсголын тайланг Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэн санал, дүгнэлт гаргах.

133.5.Сонсголын тайлан, Байнгын хорооны санал, дүгнэлтийг нэгдсэн хуралдаанд танилцуулна.

133.6.Эрх бүхий этгээд томилгооны шийдвэр гаргахдаа нэр дэвшигчийн сонсголын тайлан, Байнгын хорооны санал, дүгнэлт, тэдгээрийн үндэслэл, баримт, мэдээллийг харгалзан үзнэ.

133.7.Сонсгол дууссаны дараа сонсголын үйл ажиллагаа болон сонсголын үед хэлэлцэгдсэн асуудал, асуулт, хариулт, мэдээлэл, дүгнэлт зэрэгтэй холбогдуулан маргаан үүсгэхгүй.

## **АРВАН ЗУРГАДУГААР БҮЛЭГ БУСАД АСУУДАЛ**

### **134 дүгээр зүйл. Чуулганы хуралдааныг нэвтрүүлэх, мэдээлэх журам**

134.1.Чуулганы хуралдааныг телевизийн тусгай сувгаар шууд нэвтрүүлэх түүнчлэн телевиз, радиод тусгай цаг гаргаж олон нийтэд сурталчлах, мэдээлэх ажлыг Тамгын газар зохион байгуулна.

134.2.Чуулганы хуралдаан, Улсын Их Хурлын үйл ажиллагааг сурвалжлахтай холбогдсон журмыг Улсын Их Хурлын дарга батална.

### **135 дугаар зүйл. Чуулганы хуралдааны тэмдэглэл хөтлөх, түүнийг хадгалах журам**

135.1.Чуулганы нэгдсэн, Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэл /цаашид "хуралдааны тэмдэглэл" гэх/-ийг бичгээр болон цахим мэдээлэл тээгчид нэгэн зэрэг дуу, дүрс бичлэгийн хэрэгсэл ашиглан хадгалах ба хуралдааны тэмдэглэл дэлгэрэнгүй ба товч гэсэн хэлбэртэй байна.

135.2.Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэлд дараах баримт бичгийг хавсарган хадгална:

135.2.1.тухайн хуралдаанаар хэлэлцэх асуудлын төлөвлөгөө, хуралдаанд урилгаар оролцсон болон байлцсан хүмүүсийн нэр, албан тушаал;

135.2.2.хуралдаанаар хэлэлцсэн хууль, тогтоолын төсөл /хувилбарууд/, үзэл баримтлал, танилцуулга, санал, судалгаа бусад баримт бичиг;

135.2.3.хэлэлцэж байгаа асуудлаар гишүүд, ажлын хэсэг, бусад Байнгын, дэд, хянан шалгах түр хороо, нам, эвслийн бүлгээс холбогдох Байнгын хороонд бичгээр ирүүлсэн саналын томьёолол, тэдгээрийн үндэслэл, тооцоо, судалгааг тайлбарласан баримт бичиг;

135.2.4.ажлын хэсгээс Байнгын, дэд, хянан шалгах түр хороонд, Байнгын, дэд хороо, нам, эвслийн бүлгээс нэгдсэн болон Байнгын хорооны хуралдаанд оруулсан санал, дүгнэлт, зарчмын зөрүүтэй саналын томьёолол, санал хураалтын дүн;

135.2.5.хэлэлцэж байгаа асуудалтай холбогдуулан Улсын Их Хурал, гишүүдэд иргэд, байгууллагаас ирүүлсэн санал;

135.2.6.гишүүн хуралдааны тэмдэглэлд тусгайлан тэмдэглүүлэхээр бичгээр гаргасан санал;

135.2.7.гишүүдийн ирцийн мэдээ.

135.3.Хуралдааны товч тэмдэглэлд дараах мэдээллийг тусгана:

135.3.1.хуралдаан эхэлсэн, завсарласан, дууссан болон асуудлыг хэлэлцэж эхэлсэн, дууссан он, сар, өдөр, цаг, минут;

135.3.2.хэлэлцсэн хууль, тогтоолын төсөл буюу асуудал, түүнийг танилцуулсан албан тушаалтан, хуралдаанд оролцогч, урилгаар байлцсан хүмүүс;

135.3.3.санал хураалтын дүн /тоо, хувиар/, санал өгсөн гишүүн бүрийн дэмжсэн, дэмжээгүй саналын тоо;

135.3.4.хуралдааны ирцийн мэдээ /тоо, хувиар/, хуралдаанд ирээгүй гишүүний нэр, шалтгаан /томилолттой байсан, хоцорч ирсэн, чөлөө авсан, өвчтэй байсан, тасалсан/;

135.3.5.гишүүний тусгайлан тэмдэглүүлэхээр хэлсэн үг;

135.3.6.энэ хуулийн 15.1-д заасны дагуу хуралдааны дэг сахиулахтай холбогдуулан авсан арга хэмжээ;

135.3.7.сонгогч болон бусад этгээдийг Улсын Их Хурлын үйл ажиллагаатай танилцуулсан тухай;

135.3.8.дуу болон дүрсний бичлэгт тусгагдах боломжгүй, хуралдааны явцад болсон үйл явдлыг дэс дарааллын дагуу нэг бүрчлэн товч тэмдэглэлд буулгах.

135.4.Гишүүний хэлсэн үгийг хуралдааны тэмдэглэлд тодорхой тусгах бөгөөд тусгайлан тэмдэглүүлэхээр хэлсэн үгийг тухайн гишүүнээр хянуулж гарын үсэг зуруулна.

135.5.Гишүүн хуралдааны тэмдэглэлтэй аливаа хязгаарлалтгүйгээр танилцах эрхтэй бөгөөд төрийн нууцад хамрагдсан хуралдааны тэмдэглэлтэй танилцсан бол нууцыг задруулахгүй байх арга хэмжээг авна.

135.6.Хууль санаачлагчаас өргөн мэдүүлсэн болон нэгдсэн хуралдааны анхны, эцсийн хэлэлцүүлгийн дүнг тусгасан хууль, тогтоолын төслийг гарсан шийдвэрийн хамтаар дарааллаар нь байршуулан дугаарлаж, хуралдааны товч тэмдэглэлд хавсаргана.

135.7.Нэгдсэн хуралдааны товч тэмдэглэлтэй Ерөнхий нарийн бичгийн дарга, Байнгын болон дэд, хянан шалгах түр хорооны хуралдааны товч тэмдэглэлтэй холбогдох Байнгын болон дэд, хянан шалгах түр хорооны дарга, ажлын хэсгийн хуралдааны тэмдэглэлтэй түүний ахлагч тус тус танилцаж гарын үсэг зурна.

135.8.Хуралдаанаар хэлэлцсэн асуудлыг энэ хуульд заасан журмаар эмхэлж архивын нэг нэгж болгон товъёглож, архивын тухай хууль тогтоомжид заасан журмын дагуу хадгална.

135.9.Хууль тогтоомж, бүлгийн дүрэмд өөрөөр заагаагүй бол Улсын Их Хурал дахь нам, эвслийн бүлгийн хуралдааны тэмдэглэлийг энэ хуульд заасан журмын дагуу хөтлөх бөгөөд түүнийг хадгалах, ашиглах, архивын нэгж болгох, архивт шилжүүлэх журмыг бүлэг өөрөө тогтооно.

### **136 дугаар зүйл.Хуралдааны тэмдэглэлийг ашиглах, хадгалах журам**

136.1.Хуралдааны тэмдэглэл болон дуу, дүрсний бичлэгийг чуулганы мэдээлэл бэлтгэж нийтлэх, хэвлэл мэдээллийн байгууллагад мэдээлэл, лавлагаа өгөх, маргаантай асуудлыг шийдвэрлэх зорилгод ашиглах ба Улсын Их Хурлын албан ёсны цахим хуудаст байршуулж олон нийт танилцах бололцоог хангана.

136.2.Хуралдааны тэмдэглэл, дуу, дүрсний бичлэгтэй гишүүд, Тамгын газрын ажилтан 7 хүртэл хоногийн хугацаатай шууд танилцаж болох ба зөвшөөрөлгүйгээр олшруулах, хувилахыг хориглоно.

136.3.Бусад байгууллагын ажилтан, албан тушаалтан хуралдааны тэмдэглэл, дуу, дүрсний бичлэгтэй Ерөнхий нарийн бичгийн даргын зөвшөөрснөөр Тамгын газрын архивт танилцана.

136.4.Хуралдааны тэмдэглэлийг Тамгын газрын архивт хадгалах бөгөөд түүнийг ашиглах, хадгалах нарийвчилсан журмыг Ерөнхий нарийн бичгийн дарга батална.

136.5.Төрийн нууцтай холбоотой асуудал хэлэлцсэн хуралдааны тэмдэглэл, түүнчлэн төрийн нууцад хамаарах баримт бичгийг архивын нэгж болгох, тэдгээрийг ашиглах, хадгалах асуудлыг төрийн нууцын хууль тогтоомж, тэдгээрийн дагуу баталсан дүрэм, журам, зааврын дагуу зохицуулна.

### **137 дугаар зүйл.Хууль хүчин төгөлдөр болох**

137.1.Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын 2024 оны ээлжит сонгуулиар байгуулагдсан Улсын Их Хурлын анхдугаар чуулганы хуралдаан эхэлсэн өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны .... дугаар  
сарын ....-ны өдөр

Улаанбаатар  
хот

ХУУЛЬ ХҮЧИНГҮЙ БОЛСОНД ТООЦОХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** 2020 оны 05 дугаар сарын 13-ны өдөр баталсан Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийг хүчингүй болсонд тооцсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ХУУЛЬ ТОГТООМЖИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуульд дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

**“1/17 дугаар зүйлийн 17.2.4 дэх заалт:**

17.2.4.хууль тогтоомжийн төслийн хүний эрхэд нөлөөлөх байдлыг үнэлэх.

**2/19<sup>1</sup> дүгээр зүйл.**Яаралтай хэлэлцүүлэхээр өргөн мэдүүлэх хууль тогтоомжийн төсөлд хууль зүйн дүгнэлт хийх:

19<sup>1</sup>.1.Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 33 дугаар зүйлд заасан хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэхэд хууль зүйн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага хууль зүйн дүгнэлт гаргаж ирүүлсэн байна.

**3/45 дугаар зүйлийн 45.4 дэх хэсэг:**

45.4.Энэ хуулийн 45.3-т заасан Эрх зүйн мэдээллийн нэгдсэн сан нь хууль тогтоомж, бусад эрх зүйн акт болон хууль тогтоомжийн төслийг Үндсэн хууль, Монгол Улсын олон улсын гэрээ, бусад хуультай нийцэж байгаа эсэх, уялдааг шалгах боломжтой мэдээллийн шинэ технологид тулгуурласан шийдэл бүхий байна.

**4/49 дүгээр зүйлийн 49.8 дахь хэсэг:**

49.8.Энэ хуулийн 49.2, 49.3-т заасан үнэлгээний тайлан, дүгнэлт, зөвлөмжийг Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай хуулийн 13.7-д заасны дагуу Улсын Их Хурлын хяналт шалгалтын мэдээллийн нэгдсэн санд тухай бүр байршуулна.”

**2 дугаар зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.22 дахь заалтын “Монгол Улсын Их Хурлын тухай болон Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай” гэсний дараа “, Монгол Улсын Их Хурлын хяналт шалгалтын тухай” гэж 40 дүгээр зүйлийн 40.1.7 дахь заалтын “зөвшөөрөл” гэсний дараа “, энэ хуулийн 19<sup>1</sup> дүгээр зүйлд заасны дагуу гаргасан хууль зүйн дүгнэлт” гэж нэмсүгэй.

**3 дугаар зүйл.**Хуульд тогтоомжийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

## **“41 дүгээр зүйл.Хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хуралд өргөн мэдүүлэх**

41.1.Хууль санаачлагч энэ хуулийн 40 дүгээр зүйлд заасны дагуу хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг хангаж, хууль тогтоомжийн төслийг Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлэхээс өмнө өргөн мэдүүлэх тов тогтоолгох тухай албан бичгийг Улсын Их Хурлын Тамгын газарт хүргүүлнэ.

41.2.Улсын Их Хурлын Тамгын газар хууль санаачлагчаас Улсын Их Хуралд өргөн мэдүүлэхээр ирүүлсэн хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг энэ хуулийн 41.3-т заасны дагуу хянана.

41.3.Улсын Их Хурлын Тамгын газар хууль тогтоомжийн төслийн бүрдүүлбэрийг ажлын 5 өдрийн дотор дараах шаардлагыг хангасан эсэхээр хянан үзнэ:

41.3.1.энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэх;

41.3.2.хуулийн төслийг үзэл баримтлалын хүрээнд боловсруулсан эсэх;

41.3.3.хуулийн төслийг хууль тогтоомжийн хэрэгцээ, шаардлагыг тандан судалсан, эсхүл хууль тогтоомжийн хэрэгжилтийн үр дагаварт үнэлгээ хийсэн судалгаанд үндэслэн боловсруулсан эсэх;

41.3.4.Монгол Улсын Их Хурлын тухай хуулийн 36 дугаар зүйлд заасан хууль санаачлах эрхийн хүрээ хязгаарыг хангасан эсэх;

41.3.5.энэ хуулийн 40.1.2-т заасан зардлын тооцооллыг холбогдох журам, зааврын дагуу боловсруулсан эсэх.

41.4.Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга хууль тогтоомжийн төсөл энэ хуульд заасан шаардлагыг хангасан эсэх талаар Улсын Их Хурлын даргад танилцуулах ба шаардлагатай гэж үзвэл өргөн мэдүүлэх хууль, тогтоолын төслийн талаар хууль зүйн дүгнэлт гаргуулж болно.

41.5.Энэ хуулийн 41.4-т заасан хууль зүйн дүгнэлтийг Улсын Их Хурлын Тамгын газар ажлын 5 өдрийн дотор гаргаж, Улсын Их Хурлын даргад танилцуулна.

41.6.Төслийг өргөн мэдүүлэх талаар Улсын Их Хурлын даргаас товлосон хугацааг Улсын Их Хурлын Тамгын газар хууль санаачлагчид албан бичгээр мэдэгдэх бөгөөд хууль санаачлагч уг хугацаанд багтаан хууль тогтоомжийн төслөө Улсын Их Хурлын даргад өргөн мэдүүлнэ.

41.7.Улсын Их Хурлын Тамгын газар энэ хуулийн 41.3-т заасны дагуу хянаж, эсхүл 41.5-д заасны дагуу хууль зүйн дүгнэлт гаргасан хууль тогтоомжийн төсөл хуульд заасан шаардлагыг хангаагүй гэж үзсэн бол Улсын Их Хурлын Ерөнхий нарийн бичгийн дарга Улсын Их Хурлын даргад танилцуулж, хууль тогтоомжийн төслийг энэ хуульд заасан шаардлага хангуулахаар хууль санаачлагчид буцаана.

41.8.Улсын Их Хурлын Тамгын газраас хуулийн төслийн бүрдүүлбэрийг хянасан талаарх албан бичгийг хууль санаачлагчид ажлын 14 өдрийн дотор мэдэгдээгүй бол бүрдүүлбэр хангасанд тооцно.

41.9.Хууль санаачлагч энэ хуулийн 23.1, 25.1-д заасан хуулийн төсөл, Засгийн газрын бүтэц, бүрэлдэхүүнд өөрчлөлт оруулах тухай, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хуулийн төслүүдийг үзэл баримтлалын хамт тусад нь өргөн мэдүүлнэ.

41.10.Хуулийг дагаж мөрдөж эхэлсэн өдрөөс хойш тухайн хууль болон түүний зүйл, хэсэг, заалт, дэд заалтын дагаж мөрдөх хугацаанд өөрчлөлт оруулах хуулийн төсөл өргөн мэдүүлэхгүй.”

**4 дүгээр зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1.2 дахь заалт, 5 дугаар зүйлийн 5.1 дэх хэсгийн “38 дугаар зүйл” гэснийг “36 дугаар зүйл” гэж тус тус өөрчилсүгэй.

**5 дугаар зүйл.** Хууль тогтоомжийн тухай хуулийн 42 дугаар зүйлийн 42.3 дахь хэсгийн “Тамгын газрын” гэснийг хассугай.

**6 дугаар зүйл.**Хууль тогтоомжийн тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.2.1 дэх заалтыг хүчингүй болсонд тооцсугай.

**7 дугаар зүйл.**Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг



Төсөл

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ОЛОН УЛСЫН ГЭРЭЭНИЙ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.** Олон улсын гэрээний тухай хуулийн 24.4 дэх хэсгийн “Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулна.” гэснийг “Засгийн газар Монгол Улсын олон улсын гэрээгээр хүлээсэн үүргийн биелэлтэд хяналт тавьж, хэрэгжилтийг зохион байгуулж, энэ хуулийн 8.1.1-д заасан олон улсын гэрээний хэрэгжилтийн талаар Улсын Их Хуралд хоёр жил тутам танилцуулна.” гэж өөрчлөн найруулсугай.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ**

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

**ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦЭД МАРГААН ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ  
АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

**1 дүгээр зүйл.** Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 36.2-т “Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 27 дугаар зүйлд” гэснийг “Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуульд” гэж өөрчилсүгэй.

**2 дугаар зүйл.** Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг

## МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2024 оны ... дугаар  
сарын ... -ны өдөр

Улаанбаатар  
хот

### ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

**1 дүгээр зүйл.**Төсвийн тухай хуулийн 12<sup>2</sup> дугаар зүйлийн 12<sup>2.1</sup> дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“12<sup>2.1</sup>.Эдийн засаг, хөгжлийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага Төсвийн тогтвортой байдлын зөвлөлөөс ирүүлсэн макро эдийн засгийн үндсэн үзүүлэлт, төлөв байдлын таамаглалд үндэслэн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдлийн төслийг боловсруулна. Төсвийн хүрээний мэдэгдлийн төслийн үзэл баримтлалд бодлогын өөрчлөлт, түүний үндэслэлийг эдийн засгийн үндсэн үзүүлэлт бүрээр тусгана.”

**2 дугаар зүйл.**Энэ хуулийг Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хууль /Шинэчилсэн найруулга/ хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

Гарын үсэг